


# ЭХЛЭЛ

Библи Судлал



“Итгэлээр Ноа.... итгэлийн дагуу зөвт байдлыг өвлөгч болжээ. ” - Hebrews 11:7

## ЭХЛЭЛ НОМНЫ ТАНИЛЦУУЛГА

Эхлэл ном бол Библийн хамгийн анхны ном бөгөөд Хуучин Гэрээ болон Шинэ Гэрээ хоёрын суурь нь болдог. “Женисес” гэдэг нь эхлэл гэсэн утгатай грек үг юм. Эхлэл ном нь олон зүйлсийн эхлэлийг болон Бурханы төлөвлөгөөний дагуу хүн төрлөхтнийг тэр тусмаа хамгийн эхлээд Түүний сонгосон ард түмэн буюу Израйль үндэстнийг гэм нүглээс чөлөөлөхөөр Нэгэн амлагдсан Аврагч ирэх тухай өгүүлдэг.

**“Судар бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заахад, зэмлэхэд, залруулахад, зөвт байдал дотор чиглүүлэхэд тустай. Энэ нь Бурханы хүн аливаа сайн үйлд бүрэн бэлтгэгдсэн байхын тулд юм”**(2Тимот 3:16-17). Тиймээс Бурхан Өөрийн илчлэн харуулахыг хүсэж буй олон үнэнг танд ойлгуулахын тулд Тэрээр энэхүү Эхлэл номыг зохиожээ. Бурханы Үг таныг зөв замаар удирддаг төдийгүй Түүнтэй хамт хэрхэн зөв амьдрахыг тань зааж өгдөг. Тэрээр таныг Өөрийнх нь хүчирхэг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийнх нь нэг байгаасай гэж хүсдэг.

Хэрэв та Бурханы Ариун Сүнснээс хэрхэн амьдрахыг зааж өгөөч гэж гуйхад та өөрийн амьдралд буй Бурханы таалалд нийцэхгүй зүйлсээ олж харах болно. **“Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.** (1Иохан 1:9). Бурханы тусламжтайгаар юу сурсанаа хэрэгжүүл. Тэрээр хэлэхдээ: **“Би чамтай хамт байгаа тул бүү ай! Өөрийнхөө талаар бүү санаа зов. Учир нь Би чиний Бурхан. Би чамайг тэнхрүүлж, үнэхээр чамд тусална. Би заавал Өөрийн зөв баруун мутраар чамайг хамгаална”** (Исаиа 41:10).

Бурхан онгод оруулснаар Мосе Эхлэл номыг бичжээ. Есүс: **“Мосе...Миний тухай бичсэн юм”** гэж айлдлаа (Иохан 5:46). Судруудыг Есүс **“...Намайг гэрчилдэг”** гэж хэлжээ. Эхлэл номыг судлахдаа Есүс хэрхэн илчлэгдсэнийг хараад таны зүрх баяр жаргалтай болоосой хэмээн би залбирч байна. Та энэ номны хуудас бүр дээр Есүстэй уулзах болтугай. Хэрвээ та хүсвэл энэ номыг судлах бүртээ Дуулал 119:18-ын дагуух **“Таны хуулийн гайхамшигт зүйлсийг надад харуулахаар нүдийг минь нээгээч”** гэсэн энэхүү залбирлаар хичээлээ эхэлж болно.

## ТҮҮХ 1. БУРХАН ЕРТӨНЦИЙГ БҮТЭЭСЭН



Өхлэл 1:1-28, 31

Эхэнд Бурхан тэнгэр газрыг бүтээжээ. Газар нь ямар ч хэлбэр дүрсгүй, эзгүй хоосон, гүний гадаргуу дээгүүр нь харанхуй бүрхэж, Бурханы Сүнс усны мандал дээгүүр элин хальж байлаа. Тэгээд Бурхан – Гэрэл бий болог! гэсэнд гэрэл бий болов. Бурханыг харахад тэр гэрэл нь сайхан байв. Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. Бурхан гэрлийг өдөр, харанхуйг шөнө хэмээн нэрлэжээ. Үдэш болоод, өглөө болжээ. Тэр нь анхны өдөр болой. Бурхан – Усан дотор огторгуй бий болж, усыг уснаас салга! гэж айлдав. Тийнхүү Бурхан огторгуйг бий болгоод, огторгуйн дээрх усыг огторгуйн доорх уснаас салгасанд тэр нь ёсоор болов. Бурхан огторгуйг тэнгэр гэж нэрлэжээ. Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь хоёр дахь өдөр бөлгөө. Бурхан – Тэнгэрийн доорх

ус нэг дор хуримтлагдаж, хуурай газар ил гараг! хэмээсэнд тэр нь ёсоор болжээ. Бурхан хуурай газрыг эх газар, хуримтлагдсан усыг далай хэмээн нэрлэв. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. Тэгээд Бурхан – Газар дэлхий нялх ногоо, үрт ургамал, үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулаг! гэсэнд тэр нь ёсоор болжээ. Газар дэлхий нялх ногоо, үрт ургамал, үрт жимсний модыг төрөл төрлөөр нь ургуулав. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь гурав дахь өдөр болой. Тэгээд Бурхан - Өдрийг шөнөөс салгахын тулд огторгуйд гэрэлтүүлэгчид бий болог. Эдгээр нь тэмдэг, дөрвөн улирал, өдөр, жилүүдэд зориулагддаг. Тэнгэр огторгуйд гэрэлтүүлэгчид байж, газар дэлхийг гийгүүлэг гэсэнд тэр нь ёсоор болжээ. Бурхан илүү том нь өдрийг, арай жижиг нь шөнийг захирч байхаар хоёр том гэрэлтүүлэгчийг бүтээв. Тэр бас оддыг бүтээлээ. Бурхан газар дэлхийг гэрэлтүүлэхийн тулд, мөн өдөр шөнө хоёрыг захирахын тулд болон гэрлийг харанхуйгаас салгахын тулд тэднийг тэнгэр огторгуйд байрлуулав. Үдэш болоод, өглөө боллоо. Тэр нь дөрөв дэх өдөр болой. Бурхан – Уснууд амьтдаар дүүрч, жигүүртэн шувууд

газар дэлхий дээгүүр, тэнгэр огторгуйгаар нисэг гэв. Тэгээд Бурхан далай тэнгисийн аварга том амьтад хийгээд усаар дүүрэн үржин амьдардаг, хөлхөн хөдлөгч аливаа амьтдыг төрөл төрлөөр нь бүтээв. Бас аливаа жигүүртэн шувуудыг төрөл төрлөөр нь бүтээв. Бурханыг харахад тэр нь сайхан байжээ. Бурхан тэднийг адислаж, - Өсөн төлжиж, далай тэнгисийг дүүргэ. Бас жигүүртэн шувууд газар дэлхийд өсөн үржиг хэмээв. Үдэш болоод өглөө боллоо. Тэр нь тав дахь өдөр болой. Бурхан - Газар дэлхийн амьтдыг төрөл төрлөөр нь буюу мал адгуус, мөлхөгчид, газрын зэрлэг араатныг төрөл төрлөөр нь бий болог хэмээн айлдав. Бурхан газар дэлхийн зэрлэг араатныг төрөл төрлөөр нь, газраар мөлхөгч бүгдийг төрөл төрлөөр нь бий болгов. Бурханыг харахад тэр

нь сайхан байжээ. Тэгээд Бурхан — Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээж, далайн загас, огторгуйн шувууд, мал адгуус, бүх газар дэлхий, газраар мөлхөгч бүгдийг тэдэнд захируулья хэмээн айлдав. Тэгээд Бурхан Өөрийнхөө дүр төрхөөр хүнийг бүтээж, Бурханы дүр төрхөөр эрэгтэй, эмэгтэй хүнийг бүтээв. Бурхан тэднийг адислаж, тэдэнд - Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэн, газрыг эзэмш! Далайн загас, огторгуйн шувууд хийгээд газар дэлхий дээр хөдөлдөг бүх амьтдыг захир хэмээн айлдав.

Бурхан Өөрийнхөө бүтээсэн бүгдийг харахад нэн сайхан байжээ. Үдэш болоод, өглөө болов. Тэр нь зургаа дахь өдөр болой.

## Хийх Зүйлс

А. Асуулт бүрт хариулж бич. Хэрэв чадахгүй бол Библийн түүхийг дахиад нэг унш. Асуултанд хариулсныхаа дараа Библийн түүхийн аль ишлэлд хариулт нь байгааг лавлаж хар. Хамгийн сүүлд зөв хариулсан эсэхээ номныхоо арын хавтсан дахь жагсаалтаас хар.

1. **“Бүтээлийн эхний өдөр”** Бурханы Сүнс усны мандал дээгүүр \_\_\_\_\_ байлаа. (1-р бүлгийн 2-р ишлэл). Тэгээд Бурхан “\_\_\_\_\_ бий болог” гэв (3). Мөн Тэрээр \_\_\_\_\_ аас салгажээ (4).

2. **“Бүтээлийн хоёр дахь өдөр”** Бурхан \_\_\_\_\_ бий болгоод, огторгуйн дээрх \_\_\_\_\_ огторгуйн доорх \_\_\_\_\_ салгав (7).

3. **“Бүтээлийн гурав дахь өдөр”** Бурхан тэнгэрийн доорх усыг хуримтлуулагдаж, \_\_\_\_\_ ил гараг! хэмээв (9). Түүнчлэн Тэрээр “Газар дэлхий дээр нялх \_\_\_\_\_, \_\_\_\_\_ ургамал, үрт жимсний \_\_\_\_\_ ургуулаг! (11).

4. **“Бүтээлийн дөрөв дэх өдөр”** Бурхан илүү том нь \_\_\_\_\_, арай жижиг нь \_\_\_\_\_ захирч байхаар хоёр том \_\_\_\_\_ бүтээв. Тэр бас \_\_\_\_\_ бүтээлээ (16). Эдгээр нь \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ дэд зориулагддаг (14).

5. **“Бүтээлийн тав дахь өдөр”** Бурхан \_\_\_\_\_ аварга том \_\_\_\_\_ хийгээд усаар дүүрэн \_\_\_\_\_ хөлхөн хөдлөгч аливаа \_\_\_\_\_ бүтээв (21). Тэрээр мөн тэнгэр огторгуйгаар нисэх \_\_\_\_\_ бүтээжээ (20).

6. **“Бүтээлийн зургаа дахь өдөр”** Бурхан газар дэлхийн \_\_\_\_\_ төрөл төрлөөр нь, \_\_\_\_\_ төрөл төрлөөр нь, газраар \_\_\_\_\_ бүгдийг төрөл төрлөөр нь бүтээв (25). Тэгээд \_\_\_\_\_ Өөрийнхөө дүр төрхөөр \_\_\_\_\_ бүтээв (27). Бурхан Өөрийнхөө хийсэн бүгдийг харахад нэн \_\_\_\_\_ байжээ (31).

7. **“Бүтээлийн долоо дахь өдөр”** Бурхан Өөрийн хийж бүтээсэн ажлаа \_\_\_\_\_, хийж бүтээсэн ажил нь дууссан учир Тэрээр \_\_\_\_\_ (2:2).

Б. **“Эхлэл 1:1”**-ийг бичиж аваад цээжил. Мөн Бурхан бүтээлийн өдрүүдэд өдөр бүр юу хийснийг нь цээжил.

## **Бодох Зүйлс**

Энэ дэлхийн үйл хэрэгт амин чухал байдлаар оролцдог Бурхан байдгийг Библид заадаг.

Бидний эргэн тойронд харагддаг байгалийн гайхамшгууд үүнийг баталдаг. **“Тэнгэр нь Бурханы сүр жавхланг зарлаж, Огторгуй нь Түүний гарын бүтээлийг тунхаглаж байна”** (Дуулал 19:1). Бурханы хүч чадал оршиж байгаа нь Түүний бүтээлээр дамжуулан илэрхий харагддаг. Гэвч хүмүүс Бурханыг алдаршуулсан ч үгүй, Түүнд талархал өргөсөн ч үгүй, харин бодол санаандаа хоосорч, мунхаг зүрх сэтгэл нь харанхуй болжээ. (Ром 1:19-25). **“Мунхаг хүн зүрхэндээ ‘Бурхан байдаггүй’ гэсэн”** (Дуулал 14:1а).

Библи ямар ч үнэнг үгүйсгэдэггүй харин ч үнэн байдал нь шинжлэх ухаанаар батлагдсан байдаг. Зарим “шинжлэх ухааны” онолууд, жишээлбэл хувьслын онол Библийг үгүйсгэдэг. Харин Бурханы Үг бол үнэн бөгөөд бүх үнэн Бурханы Үгийг хүлээн зөвшөөрдөг.

## **Есүс Бүтээлийн Бэлэг Байсан**

**“Эзэн бол бидний Бурхан, Эзэн бол ганц!”** (Дэд хууль 6:4а). Хэдийгээр Бурхан ганц боловч энд нэгэн нууц байна. **“Тэгээд Бурхан ‘Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу хүнийг бүтээе’ хэмээн айлдав”** (Эхлэл 1:26а). Ганц Бурхан маань Өөрийгөө олон тоогоор илэрхийлдэг. Учир нь Тэнгэрлэг Эцэг, Ариун Сүнс болон Есүс нь нэг юм. **“Учир нь бүх Бурханлаг бүрэн дүүрэн нь Түүн [Есүс] дотор биет хэлбэрээр оршдог**

юм”(Колоссой 2:9).

Есүсийн нэг нэр бол “Үг” юм. “Эхэнд Үг байсан, Үг Бурхантай хамт байсан ба Үг нь Бурхан байсан. Бүх юм Түүгээр бий болсон. Бий болсон юмсаас Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч байхгүй. Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм. (Иохан 1:1, 3, 14). Бурхан биднийг Өөртөө буцааж авах төдийгүй мөн мөнхийн амийг бидэнд өгөхөөр Есүсийн дүрээр хүн болон ирсэн нь үнэхээр гайхалтай биш гэж үү!

## **Бурхан Хэлсэн Зүйлээ Хийдэг**


Та Бурхан “Гэрэл бий болог” гэж хэлэхэд гэрэл бий болсныг ажигласан уу? Тэрээр мөн “Огторгуй бий болог” гэж хэлэхэд хүртэл бий болж байсан. Бурхан хийнэ гэж хэлсэн л бол хийдэг. Агуу дайчин эр Иошуа үхэхийнхээ өмнө хүмүүст хандан “Бурхан ЭЗЭНий тань та нарын тухайд айлдсан бүх сайн үгсээс нэг нь ч бүтэлгүйтэж унаагүй, нэг нь ч хөсөрдөөгүй, бүгд биелсэн гэдгийг та нар бүх зүрх, бүх сэтгэлээрээ мэдэж байгаа” гэж хэлж байжээ. (Иошуа 23:14.6). “Түмэн цэргийн ЭЗЭН тангараглан, “Үнэхээр Миний бодсон хэрэг биелж, Миний төлөвлөсөн ёсоор бүтнэ” (Исаиа 14:24). Бид Түүний амлалтанд бүрэн найдаж болох учраас ямар гайхалтай вэ! Нөгөө талаараа бас бид Түүний сануулганд маш анхааралтай хандах хэрэгтэй. Учир нь Бурхан хийнэ гэж хэлсэн зүйлээ заавал хийдэг Бурхан юм.

Амьдралд тань биелнэ гэдэгт итгэх хэрэгтэй Бурханаас танд өгөгдсөн амлалтууд танд бий юу? Тэрээр танд амласан бүх зүйлсээ зөв цаг нь ирэхээр биелүүлнэ гэдэгт та бүрэн итгэх хэрэгтэй.

## **Бүтээлийн Баримтнаас Заах Сүнслэг Зүйлс**

Бид Бурханы тухай болон Түүний замуудыг Библиэс суралцаж болно. Мөн бодит ертөнц дээр Бурханы бүтээл үүссэн түүхээс бид сүнслэг ертөнцөд хийсэн Түүний ажлуудыг харж чадна. Эдгээр зүйлсийг ойлгуулж илчилж өгөхийг Ариун Сүнснээс гуй. Хэрвээ та Бурханы Үгийг тэвчээртэйгээр судалж, ойлгосон зүйлсээ дуулгавартай дагах юм бол Бурхан хийх болно. Та Эхлэл номыг судалж байхдаа 1-р хичээлээ дахин дахин эргэж харах хэрэгтэй. Ингэснээр та Бурхан таны дотор бий болгохыг хүсэж байгаа шинэ зүйлсийг олж харах болно. Учир нь танд Бурханаас бэлдсэн агуу их өв залгамж бий. Түүнээс нь таныг улам ихээр авч эзэмшээсэй гэж Тэрээр хүсдэг. “Бүү ай. Бүү зүрхшээ” (Дэд хууль 1:21.6).

## Бүтээлийн Эхний Өдөр – Харанхуйг Гийгүүлэх Гэрэлтүүлэгчийн Зураг



Ямар айдас төрүүлэм зураглал вэ! Бурхан гэрлийг бий болгох хүртэл Ариун Сүнс харанхуй, эзгүй хоосон, усны давалгаа дээгүүр элин хальж байлаа. “Гэвч нүгэлтнүүд нь шидлэн давалгаалах далай мэт юм. Учир нь далай бол дөлгөөн байж чаддаггүй, ус нь хог, шавар шидлэн гаргадаг билээ. “Хилэнцтэнд амар амгалан байхгүй” гэж миний Бурхан айлдаж байна (Исаиа 57:20-21). Та аймшигтай, хоосон харанхуй дотор

алхаж яваагаа мэдэрдэг үү? Яагаад гэвэл “Харанхуйгаас гэрэл гэрэлтэг” гэж айлдсан Бурхан бол Христийн нүүрэн дэх Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний

**зүрхэнд гэрэлтсэн Нэгэн мөн”(2Коринт 4:6).**

Бурхан энэхүү ертөнц сүнсний хувьд ямар харанхуй байсан, мөн үүнийг гэрэлтүүлэхийн тулд нэгэн Аврагч зайлшгүй хэрэгтэй гэдгийг мэдэж байсан. **“Түүнд амь байсан бөгөөд амь нь хүмүүсийн гэрэл байв. Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв”** (Иохан 1:4, 12).

Та Христ дотор шинэ бүтээл болохын тулд Есүсийг болон Түүний гэрлийг амьдралдаа хүлээн авсан уу? **“Салхи дуртай газраараа үлээдэг... Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг гэж айлдав”(Иохан 3:8).** Тиймээс хэрэв хэн нэгэн хүн Христ дотор байвал тэр хүн шинэ бүтээл мөн. **Хуучин юмс нь өнгөрчээ. Харагтун, шинэ болсон байна”** (2Коринт 5:17). Та Есүсийг зүрх сэтгэлдээ хүлээн авч, Сүнсээр дахин төрсөн үү?


Энэ дэлхийг бүтээсэн бүтээлийн эхний өдөр Бурхан гэрлийг харанхуйгаас салгажээ. Үүнтэй адилхан Тэрээр биднийг Христ дотор шинэ бүтээл болгохдоо харанхуйгаас тусгаарлагдсан гэрэл болон амьдруулахыг хүсдэг. Есүс **“ариун, гэмгүй, бузартаагүй агаад нүгэлтнүүдээс тусгаарлагдсан”** байсан (Еврей 7:26). **“Тэрээр зөвт байдлыг хайрласан бөгөөд ёс бусыг жигшсэн”** (Еврей 1:9). Бид нар мөн **“харанхуйн үр жимсгүй ажлуудад оролцох ёсгүй, харин тэдгээрийг илчлэх ёстой** (Ефес 5:11). **“Тиймээс харанхуйн үйлсийг хажуу тийш тавьж, гэрлийн зэвсгүүдийг агсацгаая”** (Ром 13:12 б). Бурханы Үг болон Түүний Сүнс бидний дотор байх үед юу нь буруу, юу нь зөв болохыг хэлж өгнө

Тэр гэрэл дотор байдагчлан, та ч гэсэн ямар ч гэмгүйгээр гэрэл дотор алхаж байна уу? **“Харин Тэр Өөрөө гэрэл дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ.** (1Иохан 1:7).

Есүсийн гэрэл бидний амьдралд гэрэлтэж байх үед бид “гэрэл мэт үзэгдэн өөрсдийнхөө дунд амьдардаг буруу, гажууд үеийнхний дотор өөрсдийгөө гэм зэмгүй, буруугүй Бурханы хүүхдүүд гэдгээ баталж” чадна. (Филлиппой 2:15). Есүс “Та нар дэлхийн гэрэл мөн” хэмээн айлджээ. Зөвхөн “Ариун Сүнс тань дээр буух үед” та хүчийг олж хаа байгаа газраасаа эхлэн энэ дэлхийн хязгаар хүртэл Есүсийг гэрчилж чадна. (Үйлс 1:8) Та өөрийн ертөнцдөө гэрэл нь мөн үү?

## Бүтээлийн Хоёр дахь Өдөр – Христийн Загалмайн Зураг

Бүтээлийн хоёр дахь өдөр Бурхан тэнгэрийн доорх усыг тэнгэрийн дээрх уснаас салгаж огторгуйг (тэнгэр) бүтээв. Үүнтэй адилхан Есүс загалмай дээр Бурханаас (дээрх) болон хүн төрөлхтнөөс (доорх) салгагдсан юм. “Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?” (Матай 27:46.6). Тэр “амьдын газраас таслагдсан” (Исаиа 53:8). Есүс зөвхөн энэ дэлхийн гэрэл болон төрөөд зогсоогүй



Тэрээр мөн энэ дэлхийн гэмийн төлөө үхэх ёстой байсан юм. Учир нь Бурхан тэнгэрийг бүтээхээсээ өмнө зөвхөн үүнийг бүтээхийн тулд биш мөн Есүсийг загалмай дээр цовдлогдон нас барахыг бүр эртнээс төлөвлөсөн байжээ. Есүс “Бурханы урьдаас мэдэх мэдлэг болон урьдаас тогтоосон төлөвлөгөөний дагуу тушаагдсан”. “Гэвч Түүнийг няцалж, өвтгөх нь ЭЗЭНий таалал байв”. Христ “Дэлхийн сууриас хойш алагдсан Хурга” байв. (Илчлэлт 13:8).

Тэнгэр усыг хоёр хуваасантай адил Христийн загалмай мөн

хүн төрөлхтнийг хоёр хуваажээ. “Загалмайн үг нь мөхөгсдийн хувьд мунхаг явдал боловч аврагдаж байгаа бидний хувьд Бурханы хүч мөн” (1Коринт 1:18).

Бүтээлийн энэ хоёр дахь өдрийн ажил бидэнд юуг хэлж байна вэ? Загалмайн үг бидний амьдралд хэрэгжих ёстой. “**Би Христтэй хамт цовдлогдсон. Амьд байгаа нь би биш, харин миний дотор Христ амьд байна**” (Галат 2:20а). Бид өөрсдийн амьдрал дахь гэм нүглээ Христийн загалмай дээр авчирч өгөх ёстой. Хэрвээ бид нар Христ дотор байвал Түүнтэй хамт цовдлогдсон. Бид гэмд үхсэн. “**Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно**” (Ром 8:13). Бид өөрсдийн гэмээ Бурханы өмнө улайвал Түүнээс ариусгал ирнэ. Учир нь гэм аль хэдийн загалмай дээр шийтгэгдсэн юм.

“**Хэрэв хэн нэгэн Миний араас явахыг хүсвэл, тэр хүн өөрийгөө үгүйсгэж, өдөр бүр загалмайгаа үүрч, Намайг дага**” (Лук 9:23). Бурханы хүслийн төлөө өөрийгөө бүрэн зориулах энэхүү дуудлага нь Есүсийн жинхэнэ дагалдагчдыг заримдаа Түүнийг дагана хэмээдэг хүмүүсээс ялгаж өгдөг. Жинхэнэ дагалдагч нар нь Бурханаар болон Христ доторх ах дүүгээрээ хайрлагддаг боловч Христийг үзэн яддаг энэ дэлхийд ч гэсэн үзэн ядагддаг. Та Христтэй хамт цовдлогдсон нэгэнтэй адил амьдардаг уу?

## **Бүтээлийн Гурав дахь Өдөр – Дахин Амилалтын Зураг**

Бүтээлийн гурав дахь өдөр хуурай газар үзэгдэж, амьд ургамал ногоонууд ч бий болжээ. Есүс нэгэн удаа Өөрийгөө ургамлын үртэй адилтгажээ. “**Хэрэв улаан буудайн үр газар унаад үхэхгүй бол тэр ганцаараа үлдэнэ. Харин**



**хэрвээ тэр үхвэл олон үр бий болгоно”** (Иохан 12:24). Есүс энэ зүйрлэлээр дамжуулан Би үхэх ёстой. Хэрэв Би үхвэл олон хүмүүст шинэ амийг өгч чадна гэдгээ илэрхийлж байв. Амийн өмнө заавал үхэл байх ёстой. Хэдийгээр Аврагч маань үхээд хэнийг ч авраагүй гэсэн Бурханы төлөвлөгөөн дотор буюу “Судрын дагуу” гурав дахь өдрөө дахин амилсан юм. (1Коринт 15:4).

Есүс амьд! Тэрээр хэлэхдээ **“Яагаад гэвэл Би амьд байна. Та нар ч амьд байна”** (Иохан 14:19.6). Зөвхөн сүүлчийн өдөр бид амилах (бидний бие махбодь дахин амилна) биш харин шинэ амьдралаар амьдрах болно. Учир нь бид нүгэлд үхсэн боловч Бурханы хувьд амьд байгаа юм (Ром 6:11). **“Тиймээс Тэр Өөрөөр нь дамжуулан Бурханд ойртогсдыг бүрэн төгс аврах чадвартай. Учир нь Тэр тэдний төлөө зуучлан залбирахын тулд үргэлж амьд байдаг”** (Еврей 7:25).

Есүсийг дагахын тулд бид Түүнтэй адилхан үхэх ёстой. Есүс загалмай дээр бүгдийг төгсгөсөн учир бид өөрсдийн гэм нүгэлд үхэх ёстой. Ингэснээр бид Түүний дахин амилалтын дагуу шинэ амьдрал буюу хүчирхэг, зөвт амьдралаар амьдрах болно. Бид өөрсдийн хуучин гэмт амьдралаа орхиж, Христтэй хамт шинэ амьдралаар амьдарч чадна. (Ромын 6-р бүлгийг судал). Бид ингэж амьдрахын тулд өдөр бүр өөрсдийн амьдралаа хянаж үзэх хэрэгтэй. Бурхан Өөрийн Сүнсээр дамжуулан хуучин бодол, үйлсийг чинь зайлуулж, оронд нь танд шинэ бодол, шинэ үйлс өгөхийг хүсэж байгаа ямар нэгэн хэсэг таны амьдралд байна уу?

## **Бүтээлийн Дөрөв дэх Өдөр- Дэлхий Дээрх Амьдралын Зураглал.**

Есүс зөвхөн бидэнд авралыг өгөхийн тулд биш мөн **“бидний төлөө Бурханы оршихуйд үзэгдэхийн тулд тэнгэрт өөрт нь орсон билээ”**(Еврей 9:24.6). Бүтээлийн дөрөв дэх өдөр



тэнгэрүүд болон “хоёр агуу гэрэлтүүлэгчийн” бүтээл рүү бидний анхаарал чиглэгддэг. Учир нь энэ хоёр гэрэлтүүлэгч нь “Зөвт Байдлын Нар” болох Христийг болон Нарны гэрлийг тусгадаг шөнийн саран адил Түүний гэрлийг харанхуйн амьдралд гэрэлтүүлдэг Бурханы хүмүүсийг санагдуулдаг. Зөвхөн сар л “шөнийг захирахын” тулд бүтээгджээ. (Эхлэл 1:16).

Үүнчлэн Бурханы хүмүүст гэмийг болон Сатаныг ялан дийлэх эрх мэдэл байдаг. Гэвч бид **Христ дотор тэнгэрлэг газарт амьдрах үедээ л энэ эрх мэдэлтэй байж чадна.** (Ефес 1:3.6).”**Тиймээс хэрэв та нар Христтэй хамт амилуулагдсан л юм бол дээгүүрх зүйлсийг эрсээр бай. Тэнд Христ Бурханы баруун талд заларч байгаа. Та нар оюун ухаанаа газар дахь зүйлс дээр биш, харин дээгүүрх зүйлс дээр төвлөрүүл.** (Колоссой 3:1-2).

Дэлхий нар сар хоёрын дунд ирэх үед сар хиртэж, харанхуй болдог байна. Үүнтэй адилхан бид өөрсдийн амьдрал болон Есүсийн хооронд дэлхийн зүйлс орж ирэхийг зөвшөөрвөл бид энэ дэлхийн гэрэл байж чадахаа больж ямар ч ялалтгүй, ямар ч гэрчлэлгүй амьдрах болно. “**Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла. Хэрэв хэн нэг нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцэгийн хайр байхгүй**”(1Иохан 2:15). “**Ертөнцтэй найзлах нь Бурханы эсрэг дайсагнал гэдгийг та нар мэдэхгүй гэж үү? Тэгэхлээр ертөнцийн найз байхыг хүссэн хэн боловч өөрийгөө Бурханы дайсан болгож байгаа юм**”(Иаков 4:4.6). Үүнийг бид энэ дэлхийн хүмүүсийг хайрлахгүй байх хэрэгтэй гэж ойлгож болохгүй. Харин энэ нь Бурханы зам болон бодол санааны эсрэг аливаа бузар бодол санааг

хайрлахгүй байх ёстой гэсэн утгатай. Та эгшин бүрт “тэнгэрлэг газар” буюу Бурханы оршихуйд ухамсартайгаар амьдарч байна уу?

## **Бүтээлийн Тав дахь болон Зургаа дахь Өдрүүд Үр жимс ба Эрх мэдлийн Зураглал**



Байгалийн бүх зүйлс үр жимс гаргаж, өөрсдийн төрлийн дагуу үржиж байдгийг бид хардаг. Харин хүнд энэ дэлхийг халамжилж, бүх амьд оршигч зүйлсийг захирах тушаал нэмж өгөгдсөн билээ. Бид 3-р хичээлээс хүн энэ даалгаврыг яах аргагүй биелүүлж чадаагүйг харах болно. Одоо хүн өөртэйгөө адил Бурханы алдраас салсан, Сатаны боолчлолд буй хүнийг л

төрүүлж чадна. Гэвч Эзэнийг магъя!

**“... Учир нь хуулийн хийж чадаагүйг Бурхан хийсэн юм. Тэр Өөрийн Хүүг нүгэлт махан биетэй адил байдалд нүглийн тулд илгээж, махан биеийн дотор нүглийг шийтгэв. Ингэснээр хуулийн шаардлага нь махан биеийн дагуу бус, харин Сүнсний дагуу явагч бидэнд биелэгдэх болно”**(Ром 8:3-4). Бид Христээр дамжуулан Түүний төрхтэй адил болгогдсон зөвт байдлын үр жимс гаргадаг Бурханы хүүхдүүд болж чадах билээ: **“Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм”** (Ром 8:14).

**“Харин Сүнсний үр жимс нь хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм”** (Галат 5:22-23а). **“Ингэхдээ Бурханы магтаал болоод алдрын төлөө Есүс Христээр ирэх зөвт байдлын үр жимсээр дүүрэн байгтун”**

(Филлиппой 1:11). “Би бол усан үзмийн мод, та нар бол мөчрүүд. Хүн Миний дотор байж, Би мөн түүний дотор байвал, тэр хүн их жимс ургуулна. Учир нь Надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй” (Иохан 15:5).

Учир нь Есүс үхлийг ялан дийлсэн бөгөөд Тэрээр: “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн. Иймээс явж, бүх үндэстнийг дагалдагч болгогтун. Эцэг, Хүү, Ариун Сүнсний нэрээр тэдэнд баптисм хүртээж, Миний та нарт тушаасан бүгдийг сахин биелүүлэхийг тэдэнд заа. Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно гэж айлдав”(Матай 28:18-20). Энэ дэлхийд Христийн ажлыг хийх эрх мэдэл бидэнд өгөгдсөн. Сатан бидэнд ялагдсан. “Харагтун,

Би та нарт ... дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдэл өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй” (Лук 10:19).

“Бяцхан хүүхдүүд ээ, та нар Бурханы бөгөөд тэднийг дийлсэн. Учир нь та нарын дотор байгаа Тэр бол дэлхийд байгч нэгнээс агуу” (1Иохан 4:4).

Та Бурханы хүүхэд шиг үр жимстэй, ялалттай амьдралаар амьдарч байна уу ?



## **Бүтээлийн Долоо дахь Өдөр – Амралтын Зураглал**

Бурхан Өөрийн үгээрээ бүх зүйлсийг бүтээснийхээ дараа амарсан. Бурханы хүсэл биелэх хүртэл амралт байсангүй. Бурхан Өөрийн хүмүүстээ амралтыг өгсөн байдаг. “Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ бүгд Над уруу ир. Би та нарт амралтыг өгье. Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу

**билээ. Тэгээд та нар сэтгэлдээ амралтыг олох болно”** (Матай 11:28-29).

Есүс Бурханы хүслийг биелүүлэхээр ирсэн: **“Энэхүү хүслээр бид Есүс Христийн нэг удаа бүгдийн төлөө биеэ өргөсөн өргөлөөр дамжуулан ариусгагдсан юм. Учир нь Христ ариун болгогдогсдыг ганц тахилаар үүрд төгс болгожээ”** (Еврей 10:10, 14). Бурхан бүтээлийн ажлаа дуусгасантай адил Христ ч гэсэн авралын ажлаа дуусгасан бөгөөд одоо Тэрээр Бурханы баруун гар талд сууж байгаа. Христийн ажил дууссан учир итгэлээр бид *сүнсний* амралтанд ордог бөгөөд Түүгээр уучлагдсан төдийгүй Бурханы амар тайван бидэнд байгаа гэдгийг мэддэг. Христийн хийсэн ажилд бид юуг ч нэмэрлэж чадахгүй. **“Тэр биднийг зөвт байдлын дотор хийсэн үйлсээр минь бус, харин Өөрийнхөө өршөөлийн дагуу аварсан юм”** (Тит 3:5a). **“Тэгэхлээр Бурханы хүмүүст Амралтын өдрийн амралт үлддэг. Учир нь Бурхан Өөрийн ажлуудаас амарсны адил Түүний амралт уруу орсон хүн өөрийн ажлуудаас амарсан юм** (Еврей 4:9-10). Бидний төлөөх Христийн ажил дууссан гэдгийг бид хүлээн зөвшөөрсөн үедээ л амралтыг авна.

Зарим хүмүүс Христ дотор энэхүү амралт уруу орж чаддаггүйн шалтгаан нь хуучин хүнээсээ Христ дотор шинэ бүтээл болох гэж өөрсдөө чармайдагт байгаа юм. Үүнд ямар ч хүчин чармайлт хэрэггүй. Учир нь бид аль нэг талаараа хуучин хүндээ хүлэгдчихсэн юм биш, харин энэ хүн маань Христтэй хамт цовдлогдсон. Тиймд бид одоо эрх чөлөөтэй, шинэ бүтээл болсон. Хэрвээ бидний дотор Бурханы Сүнс амьдарч байгаа бол бид нар махан бие дотроо бус Сүнсэн дотор байгаа юм. (Ром 8:9). Хэрэв Бурхан бидний дотор ажлаа хийхийг нь зөвшөөрөх юм бол бид үнэхээр амралтыг олох болно.

Бурхан долоо дахь өдрийг ариун өдөр болгосон. Энэ нь Бурхан долоо дахь өдрийг онцгойгоор ашиглахаар тусгаарласан гэсэн утгатай. Арван Хуулийн нэг нь бидэнд Бурхан үргэлж Өөрийн

хүмүүсийг зургаан өдрийн дотор бүх ажлаа хийж дуусгаад харин долоо дахь өдрийг амралт болон сүнслэг ивээлийг авах өдөр болгоосой гэж хүсдэгийг харуулдаг. **“Хэрэв чи амралтын өдрийг үл бузарлаж, Миний ариун өдөр өөрийн таашаалыг үйлдэхээс татгалзан хөлөө татвал, амралтын өдрийг баясгалант, ЭЗЭНий ариун өдрийг эрхэм хүндэт гэж нэрлэж, өөрийн замаар явалгүй, өөрийн таашаалыг хайлгүй, чалчилгүй, энэ өдрийг хүндэтгэвэл, чи ЭЗЭНий дотор баяр хөөрийг авна. Би чамайг газрын өндөрлөгүүдээр аялуулан, эцэг Иаковын чинь өв хөрөнгөөр чамайг тэжээнэ”** гэж **ЭЗЭНий ам айлдсан юм.** (Исаиа 58:13-14).

Бид энэ дэлхий дээрх ажлаа Бурханы хүчээр хийж, Түүний чиглүүлэгийн дагуу яван “амарч” байхад Бурхан биднийг мөнхийн үнэ цэнэтэй онцгой арга замуудаар ашигладаг. Тэгээд бид амьдралынхаа төгсгөлд тэнгэрт одохдоо ажлаа дуусган бүрэн “амралтыг” авдаг.

**“- Одооноос эхлэн Эзэн дотор үхэгсэд нь ерөөлтэй еэ!” гэж бичигтүн гэх дуу тэнгэрээс гарахыг би сонсов. Сүнс – Тийм ээ, тэд ажлаасаа салж амраг. Учир нь үйлс нь тэднийг дагадаг гэж айлддаг.** (Илчлэлт 14:13).

## ТҮҮХ 2. БУРХАН ХҮНИЙГ ХАНГАВ ?

Эхлэл 2:7-9, 15-18, 21-25

ЭЗЭН Бурхан тоос шорооноос хүнийг бүтээж, амин амьсгалыг хамраар нь үлээж оруулахад, хүн амьд оршигч болжээ. Эзэн Бурхан дорно зүгт Еденд цэцэрлэг байгуулаад, тэнд Өөрийн бүтээсэн хүнийг авчирч тавьжээ. Эзэн Бурхан тэнд янз бүрийн моддыг ургуулсан нь харахад үзэсгэлэнтэй, идэхэд сайхан байв. Тэр цэцэрлэгийн гол дунд бас амин мод хийгээд сайн мууг мэдүүлэгч мод байжээ.

ЭЗЭН Бурхан хүнийг аваад, Еден цэцэрлэгийг арчлуулан сахиулахын тулд тэнд суулгав. Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. - Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг дураараа идэж болно. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! хэмээн айлдав.

ЭЗЭН Бурхан –Хүн ганцаараа байх нь сайн биш учир Би түүнд тохирох туслагчийг бүтээе хэмээн



айлджээ.

ЭЗЭН Бурхан Адамыг гүн пойронд автуулж, түүнийг унтаж байх зуур нь хавиргаас нь нэгийг сугалж аваад, ормыг нь махаар бөглөжээ. ЭЗЭН Бурхан Адамаас авсан тэр хавиргаараа эмэгтэй хүн бүтээгээд, түүнийгээ Адамд авчирч өгөв. Адам “Энэ бол яснаас минь авсан яс, Махнаас минь тасалсан мах бөгөөд Түүнийг Эрэгтэй хүнээс гаргаж авсан тул Эмэгтэй гэж нэрлэе гэж хэлжээ. Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу. Хүн ба түүний эхнэр хоёулаа нүцгэн байсан бөгөөд тэд огт ичсэнгүй.

### Хийх Зүйлс

Дутуу үгсийг олж, хоосон зайг бөглө.

1. Бурхан Адамд амьдрах газрыг бий болгож өгчээ. Бурхан дорно зүгт \_\_\_\_\_нд \_\_\_\_\_ байгуулав. (8-р ишлэл).
2. Бурхан Адамд хийх ажлыг нь өгчээ. ЭЗЭН Бурхан хүнийг аваад, Еден цэцэрлэгийг \_\_\_\_\_ тулд тэнд суулгав.(15).
3. Бурхан хүнд үхлээс зайлах зааврыг өгсөн. Тэгээд Эзэн Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. - Чи энэ цэцэрлэгийн \_\_\_\_\_ ч модны жимсийг \_\_\_\_\_ идэж болно. Харин чи \_\_\_\_\_

\_\_\_\_\_ модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй \_\_\_\_\_! хэмээн айлдав.(16-17).

4. Бурхан Адамд эхнэрийг бүтээж өгсөн. Бурхан Адамын \_\_\_\_\_ нь нэгийг сугалж аваад (21) түүгээрээ \_\_\_\_\_ бүтээгээд (22) түүнийгээ Адамд авчирч өгөв.

### **Бурхан Биднийг Хангадаг**

Бурхан хүнийг хэрхэн хайрлаж, түүнд хэрэгтэй бүхнээр нь хангадаг вэ! Үр жимстэй амьдруулахын тулд Бурхан бидэнд юу хэрэгтэйг мэддэг.”**Миний Бурхан Өөрийн алдар дахь баялгаар Христ Есүс дотор та нарыг хэрэгтэй бүхнээр тань хангана**” (Филиппой 4:19).

Бурхан биднийг Өөрт нь итгэж, Өөртэй нь нөхөрлөн, Өөрийнх нь дотор баярлаж, Өөртэй нь хамт хаанчлаасай гэж хүсдэг. Тэр бидний сайны төлөө тушаалуудаа өгсөн. “**Бидний үргэлжийн сайн сайхны төлөө, мөн биднийг өнөөдрийнх шиг амьд байлгахын тулд Эзэн эдгээр бүх зарлигийг дагахыг, өөрсдийн Бурхан Эзэнээс эмээхийг бидэнд тушаасан**” (Дэд хууль 6:24). Бид ямар гайхамшигтай Бурхантай юм бэ!

### **Бүх Гэрлэлтийн Төлөөх Бурханы Төлөвлөгөө**

Гэрлэлт нь Бурханы санаа байсан агаад Түүний оюун ухаанд ямар гайхамшигтай төлөвлөгөө байсан гээч! Гэвч Өөрийнх нь хүмүүс гэрлэхдээ Түүний төгс төлөвлөгөөн дотор байгаагүйд Тэрээр хичнээн их гунигласан бол! Эхлэл номонд Түүний төлөвлөгөө өгөгдсөн байдаг.

1. *Эр хүн эцэг эхээ орхих болно.* Эр хүн өөрийнх нь цаг ирж гэр бүл толгойлдог болсон ч гэлээ эцэг эхээ үргэлж хүндлэх ёстой. Харин эхнэрээ бүрэн дүүрнээр хайрлах ёстой. “**Нөхрүүдээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла. Тиймээс нөхрүүд ч эхнэрүүдээ өөрийн бие адил хайрлах ёстой. Эхнэрээ хайрладаг хүн өөрийгөө хайрладаг. Учир нь хэн ч хэзээ ч өөрийн махан биеийг үзэн**

ядаж байгаагүй. Харин тэжээж, хамгаалдаг. (Ефес 5:25, 28-29а).

2. Эр хүн эхнэртэйгээ нийлдэг. Амьдрахын тулд эр хүн эхнэртэйгээ яг цавуудуулчихсан юм шиг наалдах хэрэгтэй. Есүс гэрлэлтийн энэ төлөвлөгөөг бүр баталж өгсөн байдаг.

**“Иймээс Бурханы хамтад нь нийлүүлснийг хэн ч бүү салгаг”** (Матай 19:6.б).

Яагаад хүмүүс салахыг хүсээд байдаг юм бэ? Үүнд нэг л шалтгаан бий. Есүс **“та нарын зүрх сэтгэл хатуурсан”** (Матай 19:8) гэж хэлсэн байдаг. Бурхан үүнийг төлөвлөөгүй. Харин ч Тэрээр салалтыг үзэн яддаг хэмээн айлдсан. (Малахи 2:16). Бурхан биднийг нэгнээсээ салж хагацаж байхын оронд бүх уур хилэн өшөө хорслоо хаяасай хэмээн хүсдэг. **“Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд”** (Ефес 4:32).

3. Эр хүн эхнэртэйгээ нийлж нэгэн бие болдог. Биеийн нэгдэл нь оюун ухаан, зүрх сэтгэл, сүнснүүд нэгдсэний гайхамшигтай илэрхийлэл болдог. **“Бүгд гэрлэлтийг хүндлэгтүн. Ор дэр нь ч бузартаагүй байг. Учир нь хууль бусаар эр эм бологсод болон завхайрагчдыг Бурхан шүүнэ”** (Еврей 13:4).

4. Тэд нүцгэн байгаадаа ичдээгүй байсан. Энэ дэлхийд гэм орж ирэхээс өмнө эхний хос нэг нэгэндээ болон Бурханы өмнө бүх юм нь нээлттэй байсан бөгөөд нуух юм тэдэнд юу ч байсангүй. Адам Ева хоёр анх гэм үйлдэх үедээ нүцгэн байгаагаа ухаарцгаасан байна. (3-р түүхийг үз). Бурхан Өөрөө амьтны цус урсган арьсаар нь тэдэнд хувцас хийж өгчээ.

Зөвхөн Христийн золилтын цусаар Христ дотор шинэ бүтээл болсон хосууд л хоорондын жинхэнэ нээлттэй байдлыг дахин авах болно. Буруугаа хүлээх болон хэрэгцээгээ Бурхантай болон нэг нэгэнтэйгээ хуваалцаж чадна. **“Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө хүний мөсөөр гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ”** (Үйлс 24:16).

**“Хайр нь хоёр нүүргүй байг”** (Ром 12:9а). Жинхэнэ хайр нь гэрлэсэн хүндээ хэдийгээр уурламаар байсан ч олон удаа хүлцэнгүй ханддаг.

### ТҮҮХ 3. ХҮН БУРХАНААС ТУСГААРЛАГДАВ.



Эхлэл 3:1-21, 24

ЭЗЭН Бурханы бүтээсэн аливаа хээрийн зэрлэг амьтдын дотроос могой хамгийн илүү зальтай байжээ. Тэр могой “Та нарт энэ цэцэрлэгт байгаа бүх модны жимснээс илэж болохгүй гэж Бурхан үнэхээр хэлсэн үү? хэмээн эмэгтэйтээс асуужээ. Тэр эмэгтэй могойд хандаж “Бид энэ цэцэрлэг дэх модны жимснээс илэж болно. Харин цэцэрлэгийн голд байгаа жимсний тухайд Бурхан “Та нар түүнээс бүү ид, бас түүнд бүү хүр, тэгвэл та нар үхнэ” гэж айлдсан хэмээжээ. Тэр могой эмэгтэйд “Та нар ерөөсөө үхэхгүй. Та нар идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн муут мэдэх болно гэдгийг Бурхан мэддэг билээ” гэжээ. Тэгээд тэр модны жимс идэхэд амттай, харахад тааламжтай, оюун ухааныг нь задалмаар байсныг нь тэр эмэгтэй үзээд, түүнээс авч иджээ. Тэгээд тэр хоёрын нүд нээгдэж, хоёулаа нүцгэн байгаагаа мэдээд, ишжир модны навчсыг хооронд нь холбож, өөрсөддөө бэлхэмж хийжээ. Өдрийн сэрүүнд ЭЗЭН Бурханы

цэцэрлэг дундуур алхаж яваа чимээг сонсоод, эр хүн эхнэртэйгээ хоёул ЭЗЭН Бурханы оршихуйгаас цэцэрлэгийн модон дотор нуугджээ. Гэтэл ЭЗЭН Бурхан хүнийг дуудаж, “Чи хаана байна вэ?” гэсэнд тэрээр “Би таны дууг цэцэрлэг дотор сонсоод, нүцгэн байсан учир айж, өөрийгөө нуусан юм” гэж хэлэв. Тэгтэл Тэр “Чамайг нүцгэн байсныг хэн чамд хэлсэн бэ? Бүү ид гэж Миний чамд тушаасан тэр модны жимснээс чи идсэн үү?” гэж асуусанд хүн “Надтай хамт байлгахаар Таны надад өгсөн тэр эмэгтэй надад тэр модны жимснээс өгсөн. Тэгээд би идсэн” гэж хэлэв. ЭЗЭН Бурхан тэр эмэгтэйд “Чи яаж байгаа чинь энэ вэ?” гэсэнд тэр эмэгтэй “Тэр могой намайг мэхэлснээс болоод би идсэн гэв. ЭЗЭН Бурхан тэр могойд хандаж, “Чи ийм хэрэг хийсэн учир Хамаг мал адуус хийгээд хээр талын хамаг зэрлэг амьтдаас илүүгээр харагдсан болой. Чи хэвлийгээрээ мөхлөж, насан туршдаа тоос шороо идэх болно. Би чамайг тэр эмэгтэйтэй өс хонзонтой, бас чиний үр хүүхдийг тэр эмэгтэйн үр хүүхэдтэй өс хонзонтой болгох болно. Тэр эмэгтэйн үр хүүхэд чиний толгойг няцалж, чи түүний өсгийг няцлах болно” гээд бас эмэгтэйд “Би чиний жирэмсний зовлонг үлэмж ихэсгэж, чи их зовлонтойгоор хүүхэд төрүүлэх болно. Чи эр нөхрийг хүсэн мөрөөдөж, эр нөхөр чинь чамайг захирна” гэв. Адамд хандан “Чи

эхнэрийнхээ үгийг сонсож, “Бүү ид!” гэж Миний чамд тушаасан модноос идсэн учир чамаас болж газарт хараал хүрч, чи насан туршдаа зүтгэж байж ургацыг нь идэх болно. Газар чамд зангуу ба халгайг ургуулна. Чи тариалангийн талбайгаас ногоо идэх болно. Чи газар шороондоо эргэж очих хүртлээ духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ. Учир нь чамайг газар шорооноос авсан. Чи тоос шороо тул тоос шороондоо буцаж очих болно” гэжээ. Хүн эхнэрээ Ева гэж нэрлэжээ. Учир нь тэр амьд бүхний эх болсон ажээ. ЭЗЭН Бурхан Адам ба түүний эхнэрт зориулж, арьсан дээл хийж өмсгөжээ.

Тэгээд Бурхан тэр хүнийг хөөж гаргаад, амийн мод уруу хөтлөх замыг хамгаалуулахаар Еден

цэцэрлэгийн зүүн талд херубууд болон зүг бүрд эргэлддэг галт илдийг байрлуулан тавьжээ.



## Сатан бол Мэхлэгч

Нэгэн цагт Бурханы үзэсгэлэнтэй тэнгэр элч байсан Сатан Бурханаас урваж тэнгэрээс хөөгджээ. Евад үзэгдсэн могой нь Сатан байсныг бид мэднэ. **“Өнөөх агуу том луу буюу бүх ертөнцийг мэхлэгч диавол ба Сатан гэгддэг эртний могой доош хаягдав...”** (Илчлэлт 12:9а).

Сатан хэрхэн мэхлэхийг оролдсон билээ? Тэр Бурханы үгийг ашиглан Еваг мэхэлснийг бид харсан. Тийм учраас Бурханы Үгийг сайн мэддэг байх нь ямар чухал вэ!! Бурхан хүнд цэцэрлэгт байгаа бүх моддын нэгээс бусдынх нь жимснээс идэж болно хэмээн тушаасан. Гэвч Сатан Бурханы энэ тушаалыг нь маш хатуу боломжгүй мэт болгохыг оролдсон. Тэр Бурханд болон Бурханы хангамжинд дургүйцэх үр тарьсан юм.

Сатаны дараагийн алхам нь Бурханы үгийг үнэн биш гэж

итгүүлэх байв. Тэр Евад гэм үйлдэж, гэмтэйгээ явж болно гэж хэлсэн бөгөөд түүнийг мэргэн ухааны үндэс болох Бурханаас эмээх эмээлтээс холдуулах гэж оролджээ.

Дараа нь Сатан Бурханы зан чанарыг доромжлон, Бурхан өөрөөс нь сайныг холдуулж байна хэмээн Евад хэлснээрээ Түүнийг санаатайгаар буруутгажээ. Тэгээд ч зогсохгүй тэрээр Еваг Бурханы өмнө дуулгаваргүй байх юм бол Түүнтэй адилхан болно хэмээн ятгав. Эцэст нь түүний зүрх сэтгэлд Бурханд үл итгэх байдлын үр таригдсан байлаа! Хэрвээ тэр эмэгтэй Бурханд үнэхээр хайртай бөгөөд Түүнд бүрэн итгэдэг байсан бол Түүний өмнө дуулгаваргүй байхгүй байсан. Хүмүүс Бурханы хайр энэрлийг мэдэх хэрэгтэй! **“Дэлхий ЭЗЭНий хайр энэрлээр дүүрэн”** (Дуулал 33:5.6). **“Түүний тушаалууд нь хүнд дарамт биш билээ”** (1Иохан 5:3.6). **“Та нар Судрыг ч, Бурханы хүчийг ч мэдэхгүйгээс болж төөрөлдөж байна”** (Матай 22:29.6). **“Хэн ч та нарыг хоосон үгсээрээ бүү мэхлэг. Яагаад гэвэл эдгээрээс болж Бурханы уур хилэн дуулгаваргүй хөвгүүд дээр буудаг юм. Иймд тэдний хамсаатан байж болохгүй”** (Ефес 5:6-7).

## Гэмийн Үр дагавар

Бурханы анхааруулга үнэн байсан уу? Адам гэм хийсэн өдрөө үхсэн үү? Тийм ээ, тэр даруйдаа *сүнсээр* үхсэн. Энэ үхэл нь хүн Бурханаас тусгаарлагдаж, Түүнтэй мөнхөд хамт амьдарч чадахаа больсон гэсэн үг. Адамыг сүнсээр үхсэний дараа төрсөн бүх хүмүүс Бурханы төлөвлөгөөний дагуу Түүнтэй хамт мөнхөд амьдрахын тулд сүнсээр дахин төрөх ёстойн учир нь эндээ байгаа юм. Түүнчлэн Адам бие махбодын хувьд ч гэсэн үхэж эхэлсэн. **“Эзэний хувьд, нэг өдөр мянган жил мэт, мянган жил нь нэг өдөр мэт байдаг”** (1Петр 3:8.6). Хэн ч мянган жил амьдарсангүй. Адам 930 наслаад өөд болжээ. Энэ нь Бурханы харж байгаагаар бол тэрээр гэм хийсэн өдөртөө л бие махбодиороо үхсэн гэсэн үг.

**“Учир нь нүглийн хөлс бол үхэл”** (Ром 6:23а). Тийм ээ Сатаны хэлсний дагуу Адам, Ева хоёрын нүд нээгдсэн боловч Бурхан бүх сайн зүйлсээ тэдний оюун ухаанд илчилсэнгүй. Харин тэд нүцгэн байгаагаа ухаарсан бөгөөд Бурханы алдар тэднээс холдсон байлаа. Бүх ирээдүйн үеийнхэн тэдэнтэй адил төрөх болно. **“Бүх хүн гэмтэй учраас Бурханы алдарт хүрдэггүй”** (Ром 3:23).

Адам Ева хоёр нүцгэн байдлаа халхлахыг оролдсон төдийгүй Бурханы оршихуйгаас өөрсдийгөө нуужээ. Ямар их эмгэнэл вэ! Тэдний гэм нүглийн үр дүнд бүх бүтээл зовлон амссан юм. Харин бидний амьдралд ямар нэгэн гэм бий эсэхийг анхааран харцгаая. Учир нь гэм нь биднийг Бурханаас тусгаарладаг юм. Гэм нь ирээдүйн үеийнхэнд маань муу үр дагаврыг авчирдаг бөгөөд бидний эргэн тойрон дахь бүх зүйлд ч гэсэн муугаар нөлөөлдөг. Ердөө “өчүүхэн” гэмээр нэг л гэм энэ бүгдийг хийх чадвартай байдаг! Учир нь бүх гэм үнэхээр том юм. **“Учир нь бүх хуулийг сахивч нэг дээр бүдрэх хэн боловч бүх хуулийг зөрчсөн болно”** (Иаков 2:10).

Тиймд маш хурдан өөрсдийн амьдрал дахь гэрийн асуудлаа шийдэцгээе. **“Гэм нүглээ нуун далдлагч хэзээ ч амжилтанд хүрэхгүй. Харин гэм нүглээ хүлээн зөвшөөрч, тэдгээрийг хаягч хүн хайр энэрлийг хүртэнэ”** (Сургаалт үгс 28:13).

## **Авралын Амлалт**

Нэгэн эмэгтэйгээс төрөх Аврагч Сатаныг ялах болно гэж Эхлэл 3:15 дээр өгүүлсэн байдаг. Энэ нь Библи дэх хамгийн анхны Аврагч заавал ирнэ гэсэн дохио байсан юм. **“Харин цаг нь болоход Бурхан эмэгтэй хүнээс Хуулийн дор төрөх Өөрийн Хүүгээ илгээсэн юм”** (Галат 4:4-5). **“Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ”** (1Иохан 3:8.б). Бурхан бидэнд Өөртэйгөө эргүүлэн нөхөрлөх замыг тавьж өгсөнд та баярлахгүй байна гэж үү?

Адам Ева хоёр инжир модны навчаар өөрсдийнхөө нүцгэн байдлыг халхлахыг оролдсон. Бид нар өөрсдийн хүчээр Бурханд тааламжтай нэг ч зүйл хийж чадахгүй. **“... Бидний бүх зөв үйлс нь бохир хувцас мэт байдаг”** (Исаиа 64:6а). Гэвч Бурхан хүнд маш их хайртай! Тэр Өөрөө тэдэнд арьсаар хувцас хийж өгсөн юм. Арьсыг нь авахын тулд Тэрээр амьтан алсан бөгөөд анхны цус урсалт нь энэ байв. **“Учир нь махан биеийн амь нь цусанд байдаг ... Учир нь цус бол амийн төлөө эвлэрүүллийг хийдэг юм”** (Левит 17:11). “Цагаатгал” гэдэг үг нь бүрхэх гэсэн утгатай. Бурханы энэ үйлс нь амьтны цусаар биш, Есүс Христийн цус урсах ёстой гэдгийг бэлэгдэж байсан юм. Зөвхөн Бурханаас илгээгдсэн Хурга болох Есүс л биднийг мөнхийн авралд хүргэсэн юм. Бурханыг Магт!

Христ Адам болохоор ирээгүй. **“Учир нь ганц хүний дуулгаваргүй байдлаас болж олон хүн нүгэлтэн болгогдсоны адил түүнчлэн ганц Хүний дуулгавартай байдлаар олон хүн зөвт болгогдоно”** (Ром 5:19).

**“Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно”** (1Коринт 15:22). **“Тийнхүү “Анхны хүн Адам амьд сэтгэл болсон” гэж бичигджээ. Сүүлчийн Адам нь амь өгөгч сүнс болов.** (1Коринт 15:45). **“Та нар өөрсдийн нүгэл хилэнц дотор үхсэн байхад Тэрээр та нарыг амьдруулсан юм”** (Ефес 2:1).

Бид Бурханы Үгийг дуулгавартайгаар дагаж, Түүний зөвшөөрсөн нөхцөл байдал дотор Түүнд захирагдах үед бидний оюун ухаан шинэчлэгдэн бид өөрсдөө өөрчлөгддөг. Бид Бурханы оршихуйд цаг өнгөрөөх тусам Тэрээр биднийг Өөрийн төгс дүр болох Есүстэй улам бүр адил болгосоор байдаг. (Еврей 1:3). **“Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээр Эзэний алдрыг тусган харуулдаг. Сүнс болох Эзэн биднийг алдраас алдарт Өөртэйгөө ижил дүрээр өөрчилдөг билээ”** (2Коринт 3:18).

## Диаволыг Хэрхэн Эсэргүүцэх Вэ?

Сатан Еваг мэхлээд, түүгээр дамжуулан Адамыг гэм хийлгэх гэж сорьсон шиг тэр таныг ч мөн мэхэлж, сорих болно. **“Эрүүл ухаантай, сонор сэрэмжтэй бай! Та нарын өрсөлдөгч болох диавол нь хэн нэгнийг залгихаар хайж буй архирах арслан мэт гэтэн явдаг... түүнийг бат итгэлээрээ эсэргүүц”** (1Петр 5:8, 9.6). Гэвч тэр үргэлж архирах арслан мэт эсвэл могой шиг үзэгддэг. Тэр мөн **“гэрлийн элч”** шиг ч харагдаж чаддаг. (2Коринт 11:14).

Хэрэв сайн юм шиг харагдаж байгаа хэн нэгэн эсвэл тэнгэр элч ч юмуу танд Библийн дагуу бус үнэнийг ярьж болох юм. Тэгвэл түүнд бүү итгэ (Галат 1:8).

**“Тиймээс Бурханд захирагдагтун. Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна”**(Иаков 4:7). Бурхан бидэнд Сатаныг эсэргүүц гэж хэлж байна. Хэрхэн эсэргүүцэх вэ? Эхлээд бид Сатаныг эсэргүүцэхээсээ өмнө Бурханд өөрийгөө захируулах ёстой. Бид Бурханы хүслийг биелүүлснээрээ үүнийг гүйцэтгэдэг. **“Харин өөрийн хүсэл тачаалдаа автаж, уруу татагдах үедээ хүн бүр соригддог. Тэгээд хүсэл тачаал нь жирэмслээд нүглийг төрүүлдэг. Нүгэл нь биеллээ олохоороо үхлийг авчирдаг аж. Хайрт ах дүү нар минь бүү мэхлэгдэгтүн”** (Иаков 1:14-16). Хэрэв бид Бурханы хүслийг биелүүлэхийн тулд өөрсдийгөө бүрэн дүүрэн зориулахгүй бол Сатан биднийг махан биеийн хүслээ дагах хүртэл хуурч чадна. **“Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махан биеийн хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардам бахдал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм. Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал нь өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлддэг нэгэн нь мөнхөд оршдог”** (1Иохан 2:16-17). Сатан Еваг амттай жимс идэх хүсэл, тааламжтай зүйл харах хүсэл болон хэн нэгэн чухал хүн болох гэсэн хүслээр нь дамжуулан хуурчихдаг. Хэрэв Ева махан биеийн хүслүүдээ дагахын оронд Бурханы хүслийг биелүүлсэн бол мөнхөд амьдрах байсан юм. Тэрээр мөн жинхэнэ зүрх сэтгэлийнхээ хүслийг хүлээж авах байсан юм. **“ЭЗЭНД баярлагтун. Тэр чамд зүрхний чинь хүслийг өгнө”**(Дуулал 37:4). Гэмийн таашаал нь богинохон хугацаанд үргэлжилдэг бөгөөд

эцэстээ үхэл рүү хөтөлдөг.

Есүс гэмгүй хирнээ Сатанд соригддог байжээ. (Матай 4:1-11). Евагийн бүх хэрэгцээтэй зүйлс түүний эргэн тойронд байхад тэрээр соригдсон бол Есүс цөлд 40 хоног мацаг барьж явахдаа сатанд соригдсон. Сатан судрыг ашиглан Есүсийг өлсөж байхад нь хоол идүүлэхийн тулд Түүнийг сорьжээ. Мөн Тэрээр Түүнд дэлхийн хаанчлалуудыг амласан бөгөөд Есүс гэж үнэхээр хэн юм бэ гэдгээр нь бардамнуулахыг оролдсон юм. Хэрвээ Есүс өлсгөлөн байх тэр үедээ юм идээд, дэлхийн хаанчлалуудыг захирахаар сонгож, өөрийгөө үнэхээр хэн бэ гэдгээрээ бардамнасан бол одоо ямар байх байсан бол? Гэвч Есүс энэ бүх сорилтыг эсэргүүцэж чадсан юм. Түүний ирээдүйд энэ бүгдийг өгөх зорилго Бурханд байсан юм. Тийм байхад эдгээр зүйлсийг Сатанаас, Сатаны арга замаар авах гэж үү? ХЭЗЭЭ Ч ҮГҮЙ! Сатаныг эсэргүүцэх бидний үлгэр жишээ бол Есүс юм. Тэр Аавынхаа хүсэлд бүрэн захирагдаж байсан. Есүс соригдох бүрдээ Бурханы Үгнээс аван **“Сударт ингэж бичигдсэн байдаг... “ хэмээн өгүүлж Сатаныг зайл хэмээн шууд тушаахад тэрээр зайлж оддог байв.**


Бид нар ч гэсэн Есүс шиг Сатаныг эсэргүүцэх ёстой. Тэгвэл тэр биднийг орхино. Жишээ нь хэрэв Сатан биднийг гомдлуулах гэж сорих юм бол бид нар ингэж хэлэх ёстой. “Сатан аа Есүсийн нэр дээр зайл” Учир нь **“Бүхнийг гоморхолгүйгээр, маргалгүйгээр хийцгээ”** (Филиппой 2:14). Бурханы Үгийг сайн мэдэх нь маш чухал. Бурханы Үг бол Сүнсний зэвсэг юм. Үүнийг Сүнсний сэлэм (Ефес 6.17) гэж нэрлэдэг. Эхнээсээ л худалч байсан Сатан үнэнтэй тулгарах үед зугтаах ёстой. Энэ номыг судалж байхдаа ишлэлүүдийг цээжлэхийн тулд жагсаан бичиж ав. Тэгээд өдөр бүр цаг гарган ишлэлүүдээ цээжилж, оюун ухаандаа болон зүрхэндээ суулгахын тулд цээжилснээ өөртөө чангаар давтаж хэл. Та амьдралынхаа ямар нэгэн талбар дээр байнга соригддог бол дахиад сорилт ирэх үед нь эсэргүүцэж чадах ишлэлийг цээжил. Жишээ нь **“Ариун бай. Учир нь Би бол ариун”** (1Петр 1:16.6).

Бид нар өөрсдийнхөө хүчээр Сатаныг зайлуулж чадахгүй боловч Калвари дээр урссан цусаараа Сатаныг ялсан Есүсийн

нэр дээр тэрээр зайлуулагдсан.(Илчлэлт 12:11).

“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” (1Коринт 10:13).

## ТҮҮХ 4. АНХНЫ АЛУУРЧИН



Эхлэл 4:1-12, 16а, 25-26

Адам эхнэр Еватайгаа унтаж, Ева нь жирэмслэн, Каиныг төрүүлж, - ЭЗЭНий ерөөлөөр би хүүтэй боллоо гэж хэлэв. Дахиад тэрээр Каины дүү Абелиг төрүүлжээ. Тэгээд Абель нь хоньчин, Каин нь тариачин болжээ. Хожим нь Каин газраас авсан үр жимснээсээ ЭЗЭНд өргөл болгон барьжээ. Абель бас хонин сүргийнхээ анхны төл болон түүнийхээ өөх госноос өргөжээ. Эзэн Абелиг болон түүний өргөлийг ойшоон хүлээн авсан боловч, Каиныг болон түүний өргөлийг ойшоосонгүй. Каин ихэд уурлан, уруу царйлав. ЭЗЭН Каинд хандаж - Чи юунд уурлана вэ? Юуны учир уруу царйлаад байгаа юм бэ?

Хэрэв чи сайныг үйлдвэл тэргүүнээ өргөх биш үү? Хэрэв чи сайныг үйлдэхгүй бол гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсвэч чи түүнийг дийлэх ёстой. Каин дүү Абельтайгаа ярьжээ. Дараа нь хээр талд байхдаа Абель уруугаа дайрч, түүнийг алав. ЭЗЭН чиний дүү Абель хаана байна? гэж Каиннаас асуухад Каин – Би мэдэхгүй. Би дүүгийнхээ харгалзагч юм уу? гэж хариулав. ЭЗЭН - Чи юу хийчихэв ээ? Чиний дүүгийн цус газраас Над уруу хашхирч байна. Газар амаа ангайж, чиний гараас дүүгийн чинь цусыг авсан тул чамд газраас хараал хүрч, чамайг газар хагалахад газар чамд дахин үр жимсээ хайрлахгүй. Чи газар дэлхий дээр хэрэн тэнүүчлэгч болно гэв. Дараа нь Каин ЭЗЭНий оршихуйгаас явжээ.

Адам эхнэртэйгээ дахин унтаад, эхнэр нь хүү төрүүлж түүнийг Сет гэж нэрлэв.

-Бурхан надад Каины алсан Абелийн оронд өөр нэг үр хайрлалаа гэв. Сет бас нэг хүүтэй болж, түүнийг Енош гэж нэрлэв. Тэр цагаас эхлэн хүмүүс ЭЗЭНий нэрийг дуудах болжээ.

## Зөвт Байдлын Өргөл

**“Итгэлээр Абел Каиныхаас үлэмж дээр тахилыг Бурханд өргөв. Үүгээрээ тэр зөвт байсан гэсэн гэрчлэлийг хүлээн авав”** (Еврей 11:4а). Яагаад Абелийн өргөлийг хүлээн авсан бэ? Учир нь Абел хонин сүргийнхээ хамгийн сайн хониор тахил өргөсөн юм. **“...цус урсгахгүйгээр ямар ч уучлал байхгүй”** (Еврей 9:22.б). Харин Каин Бурхан өөрт нь хэлээгүй байхад өөрөө мэдэн анхных ч биш хамгийн сайн нь ч биш тийм өргөлийг Бурханд өргөхөөр авчиржээ. Түүний гэм нүгэл нь цус урсаагүй учир уучлагдаагүй юм.

**“Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг үйлддэггүй аливаа хүн Бурханых биш. Бид бие биеэ хайрлах ёстой гэдэг нь та нарын эхнээсээ сонссон мэдээ билээ. Каин шиг биш. Тэр бол муу нэгнийх байсан бөгөөд дүүгээ алсан билээ. Ямар шалтгаанаас болж түүнийг алав? Яагаад гэвэл өөрийнх нь ажил үйлс бузар муу, дүүгийнх нь ажил үйлс зөвт байсан аж. Ах дүү нараа, ертөнц та нарыг үзэн ядвал бүү гайх”** (1Иохан 3:10-13).

Хамгийн анх дэлхий дээр зөвт Абелийн цус урссан гэдгийг Есүс бидэнд хэлсэн. (Матай 25:35). Есүс дагалдагчиддаа хавчлагыг хүлээж авахыг сургадаг. Дэлхий Есүсийг үзэн ядаж үхэл рүү түлхсэн. **“Хэрэв та нар ертөнцийнх байсан бол, ертөнц өөрийнхнийгөө хайрлахсан. Харин та нар ертөнцийнх биш, гагцхүү Би та нарыг ертөнцөөс сонгосон. Тиймээс ертөнц та нарыг үзэн яддаг. “Боол эзнээсээ илүү агуу биш” гэж Би та нарт хэлснийг санагтун. Хэрэв тэд Намайг хавчсан бол, та нарыг бас хавчих болно.**

(1Иохан 15:19-20).

**“Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй еэ! Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас**

өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд тийнхүү хавчсан юм” (Матай 5:11-12).

## **Есүсийн Цусаар Дамжин Ирсэн Аврал.**

Христийг энэ дэлхийд ирэхээс өмнө хургаар тахил өргөдөг байсан нь Түүнийг ирнэ гэсний бэлэг тэмдэг байв. Есүс **“Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хурга байсан юм”** (Иохан 1:29.6). Тэрээр Бурханаас илгээгдсэн Төгс Хурга байсан тул Түүний урссан цусаар дамжуулан бидний бүх гэм нүгэл бүр мөсөн уучлагдсан юм. **“Учир нь бух, ямааны цусаар нүглийг авч хаях боломжгүй юм”** (Еврей 10:4). **“Ингэхдээ та нар эцэг өвгөдөөсөө өвлөсөн өөрсдийн утгагүй амьдралаас алт, мөнгө мэтийн устах зүйлсээр золигдсон бус, харин үнэт цусаар, Христийн цус болох гэм зэмгүй бөгөөд толбогүй хурганы цусаар золигдсон гэдгээ мэдэгтүн”** (1Петр 1:18-19). Хуучин Гэрээний үед бэлэг тэмдэг байсан цусан тахил нь одоо хэрэггүй юм.

## **Бид Ууртайгаа Ажиллах Хэрэгтэй**

Бурхан ямар ч шийтгэлийг хүсдэггүй. Тэр бидэнд тэвчээртэйгээр ханддаг. Абел, Каин хоёрын түүхээс үзэхэд ч гэсэн Бурхан Каинаас **“Чи юунд уурлана вэ?”** гэж асуусан нь гайхмаар байгаагүй гэж үү? Бурхан Каинд элэгсэгээр хэрэв тэр зөвийг үйлдсэн бол уурлахгүй байх байсан гэдгийг нь хэлдэг. Тэгээд ч зогсохгүй Тэрээр түүнд юуг зөв хийгээгүй болохыг ойлгоход нь тусалдаг. Учир нь гэм түүнийг хянахаар хаалган дээр нь зогсож байсан юм. Харин Бурхан Каиныг гэмээ захирахыг ятгадаг, гэвч тэр Түүний зөвлөгөөг аваагүй нь ямар харамсалтай вэ! Каин уурлахыг зөвшөөрч, өөрийгөө хянахыг хүсээгүй юм. Ингэснээрээ тэр Бурханыг хүлээж авах бус харин Түүгээр шүүгдэхийг сонгосон. Каин уурласнаараа тэр даруй Бурханы оршихуйгаас гарсан юм.

**“Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч**

шийтгүүлбэл зохино” гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай” (Матай 5:21-22а). “Бид ах дүүсээ хайрладаг учраас үхлээс амь уруу шилжсэнээ мэддэг. Үл хайрлагч нь үхлийн дотор байна. Ах дүүгээ үзэн яддаг нэг нь алуурчин мөн. Ямар ч алуурчны дотор мөнх амь байдаггүйг та нар мэднэ” (1Иохан 3:14-15). Бурханы тушаалыг биелүүлэхийн тулд бид хайраар хэрхэн дүүрэх вэ?

“Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг” (Ром 5:5.6). “Харин Түүний үгийг сахьдаг хэний ч дотор Бурханы хайр үнэхээр төгс болгогджээ. Үүгээрээ бид Түүний дотор байгаагаа мэднэ. (1Иохан 2:5)

“Хайртууд минь бие биеэ хайрлацгаая. Учир нь хайр бол Бурханаас ирдэг. Хайрладаг хүн бүр Бурханаас төрсөн бөгөөд Бурханыг мэддэг юм. Хайрладаггүй нэгэн нь Бурханыг мэддэггүй. Учир нь Бурхан бол хайр билээ (1Иохан 4:7-8).

Бурхан биднийг ууртайгаа хэрхэн ажиллахыг Ефес 4:23-32 дээр хэлсэн байдаг.

1. “Оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгд” (4:23). Бид Бурханы Сүнсээр дахин төрөх ёстой. Ингэснээр бид шинэ сүнстэй болж, шинэ замаар алхах чадвартай болно. Бид өөрсдийн оюун санаагаа Бурханы Үгээр дүүргэх ёстой. Тэгвэл бид Түүний зөв замуудыг мэдэж чадна.

2. “Зөвт байдал болон үнэний ариун байдал дотор Бурханы дагуу бүтээгдсэн шинэ хүнийг өөртөө өмс” (4:24). Бид Христ дотор шинэ бүтээл болон алхах ёстой. Энэ нь Сүнсээр үргэлж дүүрэн байхад өөрийгөө зориулах итгэлийн алхам юм.

3. “Хүн нэг бүр хөршдөө үнэнийг ярь” (4:25). Заримдаа хүмүүс буруу зүйлсийг зөв болгон ярих үед бидний уур хүрдэг. Яг энэ үед дуугүй байж болохгүй. “Би дуугүй байхад өдөржингөө ёолсноос болж яс минь яйрсан” (Дуулал 32:3). Бид үнэнийг дуртай нь аргагүй ярих хэрэгтэй бөгөөд дараа нь Бурханы гарт орхих хэрэгтэй. Бид үнэнийг хэлээгүйгээсээ болж

өөрсдийн сүнсээ шатааж, биеэ өвчтэй болгох хэрэггүй.

4. **“Уурласан ч, нүгэл бүү үйлд. Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг. Диаволд байр бүү өг”** (4:26-27). Бид уурлаж болно, гэвч гэм хийх ёсгүй. Уурлах нь заримдаа сайн, яагаад гэвэл уур юу нь буруу байсан, яаж зөв болгох ёстойг нь хэлээд өгдөг. Бид Бурхантай юм уу эсвэл хүмүүстэй хамт зөв зүйлсийг үргэлж хийх ёстой. Хэрэв үгүй бол бид өөрсдийгөө гэмд унагах боломжыг муу ёрын сүнсэнд тавьж өгдөг. Бид түүнийг эсэргүүцэх ёстой бөгөөд хэрхэвч түүгээр амьдралынхаа тулах цэгийг болгох ёсгүй.

5. **“Та нарын амнаас ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулахын тулд зөвхөн тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлслийг өгнө. Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо”** (4:29-30а). Хэрэв бид хүйтэн хөндий, ууртай үгээр ярих юм бол өөрсдийгөө болон эргэн тойронд байгаа бүх хүмүүсийг уурлахад хүргэнэ. **“Эелдэг хариулт уур хилэнг зайлуулна.**

**Харин хүйтэн цэвдэг үгс уур хилэнг хөдөлгөнө”** (Сургаалт үгс 15:1). Бурхан бидний хүйтэн цэвдэг үгсийг сонсоод хэрхэн гунигласан бол! Хир удаан бидэнд эелдэг зөөлнөөр хандах юм бол!

6. **“Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг”** (4:31). Бид Бурханы өмнө гэмшсэнээр эдгээр бузар зүйлсээс ариусгагдаж болно. Бид бусдад хандах хандлагаа тэдний төлөө залбирах залбирлаар болон бидний амьдралд Бурхан бүх нөхцөл байдлыг зөвшөөрдөг гэдгийг ойлгосноор өөрчилж чадна. Бурхан нөхцөл байдлыг Өөрийн хяналтандаа байлгадаг бөгөөд үүгээр дамжуулан сайн зүйлсийг хийдэг. Тиймд бид бусдыг буруутгах хэрэггүй.

7. **“Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнийгээ энэрэн, уян зөөлөн сэтгэлээр ханд”** (4:32). Бид санаандгүй сайхан сэтгэлээр хандах үед ямар өөрчлөлт болдог билээ дээ! Бусдын хэрэгцээ, асуудлыг хараад ойлгох үедээ л бид тэднийг өрөвдөх сэтгэлтэй болдог. Мөн бид Бурханаар уучлуулснаа хир их ойлгоно тэр хирээрээ даруу болдог бөгөөд Бурхан бидэнд нигүүлслээ өгч чаддаг. (1Петр 5:5).

“Хүмүүний зам ЭЗЭНий таалалд нийцэх цагт Тэрээр түүний дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлгадаг” (Сургаалт үгс 16:7).

## ТҮҮХ 5. БУРХАНЛАГ НЭГЭН ГЭР БҮЛ

Эхлэл 5:21-29.

Енох жаран таван настайдаа Метуселаг төрүүлжээ. Метуселаг төрүүлснээс хойш Енох гурван зуун жил Бурхантай хамт явж, үр хүүхдүүдтэй болжээ. Енох гурван зуун жаран тав наслав. Енох Бурхантай хамт явж байсан ба Бурхан түүнийг авч явсан учир тэрээр дэлхийд байсангүй. Метусела зуун наян долоон настайдаа Ламехыг

төрүүлжээ. Ламехыг төрүүлснээс хойш Метусела долоон зуун наян хоёр жил амьдарч, үр хүүхдүүдтэй болжээ. Метусела есөн зуун жаран ес наслаад үхэв. Ламех зуун наян хоёр настайдаа хүү төрүүлжээ. Ламех түүнийг Ноа гэж нэрлээд “ЭЗЭНий хараасан газар шороог хагалах хүнд хүчир ажил болон гарын маань хүнд хөдөлмөрөөс энэ хүү биднийг амраана” гэж хэлжээ.

### Бурхантай хамт Алхах

“Итгэлээр Енох үхлийг үзэлгүй дээш аваачигдсан. Бурхан түүнийг дээш аваачсан учраас тэр олдсонгүй. Тэр аваачигдахынхаа өмнө Бурханд таалагдсан тул гэрчлэл хүлээн авчээ. Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:5-6).

Енох Бурханд таалагдсан. Ямар гайхамшигтай гэрчлэл вэ! Тэр өөрийн мэргэн ухаан, хүч юм уу эсвэл юу хийснээрээ Бурханд таалагдсан юм биш, харин тэр Бурханд итгэдэг байсан учраас Түүнд таалагдсан ажээ. Тэрээр Бурхантай хамт алхдаг байсан бөгөөд Бурханыг сайн гэдэгт итгэдэг байсан юм.

Тэгвэл өнөөдөр бид хэрхэн Бурхантай хамт алхах вэ? “**Хоёр хүн тохиролцоогүй байж алхах уу?**” (Амос 3:3). Бурхантай хамт алхахын тулд бид өөрсдийн гэмээ Бурханы өмнө хүлээж, Түүний зам нь хамгийн сайн гэдгийг ч хүлээн зөвшөөрөх ёстой.

**“Харин Тэр Өөрөө гэрлийн дотор байдагчлан бид гэрлийн дотор явбал, бид бие биетэйгээ нөхөрлөж, Түүний Хүү Есүсийн цус биднийг бүх нүглээс ангижруулдаг ажээ” (1Иохан 1:7).** Бид Бурхантай залбирал дотор болон Түүний Үг буюу Библиэр дамжуулан ярих хэрэгтэй. Бурхантай хамт алхаж байхад, мөн Түүнийг хүлээж байхад ч гэсэн Түүний оршихуйг бид мөч бүхэнд мэдэрч байдаг. Ямар гайхамшигтай амьдрал вэ!

Енох Өөрийг нь хичээнгүйлэн хайсных нь төлөө Бурхан түүнийг шагнав. Тэрээр Өөрийнхөө ирээдүйн төлөвлөгөөг Енохтой хуваалцсан юм. Бурхан Енохт Их Үер болох тухай хэлсэн учир тэр өөрийн хүүгээ Метусела гэж нэрлэжээ. Энэ нэр нь Библи судлаачдын үзсэнээр бол “Түүнийг үхэнгүүт, энэ нь болно” гэсэн утгатай. Гэвч Метусела шиг хамгийн урт буюу 969 жил насалсан хүн түүхэнд байдаггүй ажээ. Тэрээр Их Үер болох жил нас барсан байна.

Бурхан мөн Енохтой Христийн хоёр дахь ирэлтийн талаарх төлөвлөгөөгөө хуваалцжээ. **“Адамын долоо дахь үе Енох тэдний тухай мөн эш үзүүлэн, “Харагтун. Эзэн мянга мянган ариун нэгэнтэйгээ ирэв. Энэ нь бүгдийн дээр шүүх ажиллагаа явуулж, бүх бурханлаг бусчуудыг бурханлаг бус замаар үйлдсэн бүх бурханлаг бус үйлсээр нь болон бурханлаг бус нүгэлтнүүдийн Түүний эсрэг ярьсан бүх хатуу үгсээр нь буруутгахын тулд юм” гэжээ” (Иуда 14-15).** Бурхан Өөрийнхөө замуудыг болон Өөрийнхөө төлөвлөгөөг Өөртэй нь хамт алхдаг хүмүүстэй хуваалцдаг. **“Үнэхээр Эзэн БУРХАН зарц нар, эш үзүүлэгчиддээ Өөрийн нууцыг илчлэхээс нааш Тэр юуг ч хийхгүй” (Амос 3:7а).** Бид цочролд орох хэрэггүй. **“Гэвч ах дүү нар аа, та нар харанхуй дотор байдаггүй учраас тэр өдөр нь та нарыг хулгайч мэт бариад авахгүй” (1Тесаллоник 5:4).**

Хэрвээ бид Бурханыг эргэж ирэх үед нь амьд байх юм бол Енох шиг үхлийг үзэлгүй шууд тэнгэр рүү аваачигдана. **“Учир нь Эзэн Өөрийн тушаалын үгтэй, тэргүүн тэнгэр элчийн дуу ба Бурханы бүрээн дуунаар тэнгэрээс бууж ирнэ. Тэгээд Христийн дотор үхэгсэд эхлээд амилах болно. Дараа нь**

амьд хийгээд үлдсэн бид тэдэнтэй хамт агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөж, тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно”(1Тесалоник 4:16-17). Тиймд одоо Бурхантай хамт алхах тэрхүү өдөрт бэлэн байцгаая.

## ТҮҮХ 6. БУРХАН НЭГЭН ЗӨВТ ХҮНИЙГ ОЛОВ



Эхлэл 6:5-9, 13-14, 22.

Эзэн дэлхий дээрх хүмүүсийн бузар гэм нь үлэмж их, бас тэдний сэтгэл санаа, хүсэл бодол бүхэн нь ямагт муухай болсныг хараад, Өөрөө

хүнийг газар дээр бүтээсэндээ харамсан, сэтгэл зүрхэндээ гашуудав. ЭЗЭН “Би тэднийг бүтээсэндээ харамсаж байгаа учир Өөрийн бүтээсэн хүнийг газрын хөрснөөс арчин зайлуулахдаа хүнээс авахуулаад мал адгуус, мөлхөгчид, жигүүртэн шувуудыг ч хүртэл үлдээхгүй” гэж хэлэв. Харин Ноа Эзэний мэлмийд тааллыг олжээ. Ноагийн удам угсаа ийм болой. Ноа бол зөв шударга, өөрийн үеийнхний дунд гэм зэмгүй хүн байв.

Бурхан Ноад хандан “Газар дэлхий мах цустай бүхнээс болж хүчирхийллээр дүүрч байгаа учир эцсийнх нь өдөр Миний өмнө болж, Би тэднийг газартай нь хамт устгана. Чи хуш модоор өөртөө хөвөгч авдар хийж түүн дотроо тасалгаанууд гаргаж, дотор гадаргүй давирхай түрх” гэжээ.

Ноа тийнхүү үйлдэж, Бурханы өөрт нь тушаасан бүхнийг ёсоор гүйцэтгэжээ.

### Хийх Зүйлс

Хоосон зайнд зөв үгсийг нөхөж бич.

1. Эзэн дэлхий дээрх хүмүүсийн бузар \_\_\_\_\_ нь үлэмж их, бас тэдний сэтгэл санаа, \_\_\_\_\_ бодол бүхэн нь \_\_\_\_\_ муухай болсныг харжээ (5-р ишлэл). Газар дэлхий \_\_\_\_\_

дүүрсэн байв (13).

[Бурхан сайн муу бүх зүйлсийг хардаг бөгөөд хүчирхийллийг үзэн яддаг. Харин Тэрээр биднийг уян зөөлөн, сайхан сэтгэлтэй бузар муу зүйлсийг бодож төсөөлдөггүй хүмүүс байгаасай хэмээн хүсдэг. Тийм учраас Бурхан бас бидэнд Түүний эсрэг ямар нэгэн бузар бодол байвал түүнийг өөрсдөөсөө зайлуулж, харин Түүний Үгийг өдөр шөнийн туршид бясалгадаг байгаасай хэмээн биднээс хүсдэг юм. (2Коринт 10:5, Иошуа 1:8).]

2. Бурхан хүнийг бүтээсэндээ \_\_\_\_\_, сэтгэл зүрхэндээ \_\_\_\_\_ (6).

[Эхний хоосон зайд байгаа Еврей хэлнээс орчуулагдсан энэ үг нь үгчилбэл “санаа алдах” эсвэл “уртаар амьсгаа авах” гэсэн утгатай ажээ. Харин энд буруу утгыг илэрхийлэн орчуулагдсан байна. Ноаг төрөхөд гэр бүлийнхэн түүнийг нь Ноа гэж нэрлэсэн нь “Амралт” гэсэн утгыг илэрхийлсэн нэр ажээ. Тэд Ноа хүүгээ энэ хэцүү дэлхийд өөрсдийг нь *тайвшруулна* хэмээн ийнхүү нэрийджээ. “*Тайвшрал*” гэдэг үгийг Еврей хэлнээс үгчлэн орчуулбал мөн “санаа алдах” эсвэл “уртаар амьсгаа авах” гэсэн зөв утгыг илэрхийлсэн үг ажээ. Ноа энэ бузар дэлхийд амралт, тайвшралыг авчрах ёстой байсан юм.]

3. Харин Ноа Эзэний \_\_\_\_\_ тааллыг олжээ. (8). Ноа бол \_\_\_\_\_, өөрийн үеийнхний дунд \_\_\_\_\_, Енох шиг Бурхантай хамт \_\_\_\_\_ байв (9).

**[“Учир нь Өөрт нь бүрэн зориулсан зүрх сэтгэлтэй хүмүүст хүчтэй дэмжлэг болохоор ЭЗЭНий мэлмий дэлхий даяар хойш урагшаа хэрэн явдаг” (Шастирын Дэд 16:9а). ]**

4. Ноа Бурханы тушаасан \_\_\_\_\_ ёсоор нь гүйцэтгэжээ (22).

## Шүүлт Айсуй

Бурхан үргэлж хүмүүст өөрсдийн гэмээсээ эргэж Өөрийг нь дагах хугацааг өгдөг. Тэр хүмүүсийн хорон мууг хараад тэдэнд хандан “**Миний Сүнс хүнтэй үүрд хамт оршихгүй болно. Учир нь хүн бол махан бие юм. Харин тэдний өдрүүд нь нэг зуун хорин жил болно**” гэжээ (Эхлэл 6:3). Бурхан хүн төрөлхтөн

гэмээ гэмшихийг хүлээж чадахгүйгээ мэдсэн тул Тэрээр газар дэлхийг үерт автуулж 120 жилийн дотор устгахаар шийджээ. Гэвч Бурхан шударга юм. Тэрээр Өөрийн уур хилэнд өртөхгүй байх арга замыг Ноа болон түүний гэр бүлийнхэнд зааж өгчээ. **“Итгэлээр Ноа хараахан харагдаагүй байсан зүйлсийн талаар сэрэмжлүүлэл аваад гэр бүлийнхээ авралын төлөө хөвөгч авдрыг сүсэглэн бэлдсэн бөгөөд тэр түүгээр дэлхийг яллаж, итгэлийн дагуу зөвт байдлыг өвлөгч болжээ”** (Еврей 11:7).

Бидний амьдарч буй дэлхий маань улам бүр бузар болсоор байгааг бид мэддэг. Есүс хэлэхдээ: **“Учир нь Хүний Хүүгийн залран ирэх нь Ноагийн өдрүүдтэй адил байх юм. Үерийн өмнөх өдрүүдэд буюу Ноаг хөвөгч авдарт орох өдөр хүртэл тэд идэж, ууж, гэрлэж, нөхөрт гарцгааж байлаа. Үер бууж бүгдийг хаман одох хүртэл тэд ойлгоогүй юм. Хүний Хүүгийн залран ирэх нь түүнчлэн байх болно”** (Матай 24:37-39). Ноагийн өдрүүдэд дэлхий бүхэлдээ үерт автаж сүйрсэн билээ. **“Харин өнөөгийн тэнгэр болоод газар нь Түүний үгээр байгаа бөгөөд галд зориулагдан, бурханлаг бус хүмүүсийн шүүлт ба сүйрлийн өдрийн төлөө хадгалагдаж байна... Гэвч Эзэний өдөр нь хулгайч мэт ирэх болно. Тэгэхэд тэнгэр нүргэлээд өнгөрнө. Аливаа бодисууд нь галд устгагдах бөгөөд газар болоод түүн дээрх ажлууд нь шатаагдана. Хэрэв энэ бүхэн тийн устгагдах аваас ариун байдал ба бурханлаг байдал дотор та нар ямар төрлийн хүмүүс байх ёстой вэ?**

**Харин Түүний амлалтын дагуу бид зөвт байдал оршдог шинэ тэнгэр, шинэ газрыг хүлээн байна.Тиймээс хайртууд минь,та нар эдгээрийг хүлээж буй учраас амар амгалан дотор болон толбогүй бөгөөд гэм зэмгүйгээр Түүнд олдохыг хичээгтүн.** (2Петр 3:7, 10-11, 13-14).

Хүмүүсийг гэмших байх хэмээн Бурхан Өөрийн ирэх хугацаагаа хойшлуулж байгаа боловч шүүлт айсуу гэдгийг мэдсэн бид юу хийх хэрэгтэй вэ? Нэгдүгээрт бид Бурхантай хамт алхаж, Түүнд таалагдан, өөрсдийгөө болон гэр бүлийнхнийгээ аврахын тулд Христийн авралаар дамжуулан

бидэнд өгсөн Түүний бүх тушаалыг биелүүлэх ёстой. Бид өөрсдийн анхаарлаа энэ дэлхийн зүйлс дээр тавих бус харин Сүнсний зүйлс уруу хандуулах ёстой. “Харин эхлээд Түүний хаанчлал болон зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” (Матай 6:33). “Учир нь Бурханы хаанчлал бол идэх болон уух явдал нь биш, харин Ариун Сүнс доторх зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан нь юм” (Ром 14:17). Дараа нь Ноа “зөвт байдлыг тунхаглагч” гэдгээрээ танигдсан юм. (2Петр 2:5), тиймд бид ч гэсэн энэ дэлхийд шүүлт ирж буйг анхааруулах ёстой бөгөөд тэрхүү Бурханы уур хилэнгээс хэрхэн аврагдаж болохыг ч гэсэн хүмүүст хэлэх ёстой. “Иймээс бид Эзэнээс эмээхүйг мэдэж, хүмүүсийг ятгадаг” (2Коринт 5:11а).

## ТҮҮХ 7. БУРХАН ДЭЛХИЙГ ҮЕРЭЭР ШИЙТГЭСЭН



Эхлэл 7:1-7, 11-17, 22-24

Эзэн Ноад хандаж “Энэ үеийнхний дотроос чи Миний өмнө зөв шударга байгааг Би харсан учраас чи болон чиний гэр бүлийнхэн энэ хөвөгч авдарт ор. Чи бүх цэвэр амьтны төрөл бүрээс долоо долоог

эр эмээр нь, бузар амьтны төрөл бүрээс хоёр хоёрыг эр эмээр нь өөртөө ав. Бас бүх газар дэлхий дээр үр удмыг нь амьд үлдээхийн тулд тэнгэр огторгуйн жигүүртэн шувуудын төрөл бүрээс долоо долоог эр эмээр нь ав. Одоогоос долоо хоногийн дараа Би дөчин өдөр, дөчин шөнийн турш бороо оруулж, өөрийнхөө бүтээсэн амьтай бүхнийг газрын хөрснөөс арчина гэв. Ноа өөрт нь Эзэний тусаасан ёсоор бүхнийг хийжээ. Дэлхий дээр үер болоход Ноа зургаан зуун настай байлаа. Ноа нь хөвгүүд, эхнэр, бэрүүдтэйгээ хамт үерийн усны улмаас хөвөгч авдартаа оржээ.

Ноаг зургаан зуун нас хүрсэн тэр жилийн хоёр дахь сарын арван долооны өдөр газрын гүний бүх

булаг асар ихээр оргилж, тэнгэрийн усны хаалт нээгджээ. Дөчин өдөр, дөчин шөнийн турш дэлхий дээр бороо асгарав. Яг тэр өдөртөө Ноа, түүний хөвгүүд Шем, Хам, Иафет, Ноагийн эхнэр болон гурван бэр нь хөвөгч авдартаа оров. Мөн тэд болон бүх араатан амьтад төрөл төрлөөрөө, бүх мал адгуус төрөл төрлөөрөө, бүх газраар мөлхөгч төрөл төрлөөрөө, бүх жигүүртэн шувууд төрөл төрлөөрөө, амин амьсгаатай хамаг биетэн хос хосоороо Ноад очиж, хөвөгч авдарт нь оржээ. Орсон болгон нь бүх махан биетний эр эм байв. Бурханы Ноад тушаасан ёсоор хөвөгч авдарт орсонд Эзэн түүний араас хаажээ. Газар дэлхий дээр дөчин хоног үер бууж, ус нэмэгдэхэд, хөвөгч авдар газраас дээш хөвөн гарч ирэв.

Хуурай газар дээрх хамартаа амьин сүнсний амьсгаатай бүхэн үхэв. Ингээд Тэрээр хүн төрөлхтнөөс авахуулалд араатан амьтад, газраар мөлхөгч, тэнгэр огторгуйн жигүүртэн шувууд хүртэл газар дээрх хамаг амьтныг арчин зайлуулсан бөгөөд тэд бүгд газрын хөрснөөс арчигджээ. Гагцхүү Ноа болон түүнтэй хамт хөвөгч авдарт байгсад л үлджээ. Ус зуун тавин хоногийн турш дэлхий дээр хальж байв.

Эхлэл 8:1-13, 20-21

Бурхан Ноа болон түүнтэй хамт хөвөгч авдарт байсан бүх араатан амьтад хийгээд мал адгуусыг санав. Бурхан газар дэлхий дээр салхи салхилуулсанд ус татарчээ. Газрын



гүний булаг хийгээд тэнгэрийн усны хаалт хаагдаж, тэнгэрээс орж байсан бороо

зогслоо. Ус нь газар дэлхийгээс татран татарсаар зуун тавин хоног болоод багасжээ. Долдугаар сарын арван долооны өдөр онгон Араат ууланд тогтов. Ус аравдугаар сар хүртэл татран татарсаар аравдугаар сарын нэгний өдөр уулсын оргил харагдах боллоо. Дөч хоногийн дараа Ноа хөвөгч авдарт хийсэн гэгээвчээ нээн, нэгэн хэрээг галагш гаргаж тавихад тэр хэрээ газар дэлхийг хуурай болтол нааш цааш ниссээр байжээ. Тэрээр газрын хөрснөөс ус татарсан эсэхийг мэдэхийн тулд бас нэгэн тагтааг гаргаж нисгэжээ. Гэтэл газрын гадарга бүхлээрээ устай байсан тул тэр тагтаа хөл тавих газар ололгүй түүн уруу хөвөгч авдартаа буцаж ирэв. Ноа гараа сунган, түүнийг тосож аваад, хөвөгч авдартаа оруулжээ. Тэрээр бас нэг долоо хоног хүлээгээд, нөгөөх тагтаагаа хөвөгч авдраас дахин гаргалаа. Тагтаа нь үлэн түүн дээр буцаж ирэхдээ аманлаа чидун модны шинэхэн нахиа зуусан байжээ. Ингээд Ноа газрын ус татарсныг мэджээ. Тэгээд бас нэг долоо хоног хүлээгээд, мөнөөх тагтааг гаргаж тавьсанд ахин түүн уруу эргэж ирсэнгүй. Зургаан зуун нэг дэх жилийн нэгдүгээр сарын нэгний өдөр газрын гадарга дээрх ус татарсан байв. Тэгээд Ноаг хөвөгч авдрынхаа

дээврийг аваад харахад газрын гадарга хэдийнэ хуурай болсон байлаа.

Ноа Эзэнд зориулан тахилын ширээ босгож, бүх цэвэр амьтад, бүх цэвэр шувуудаас аваад, тахилын ширээн дээр шатаалт тахил өргөв. Тэгэхэд ЭЗЭН тааламжиг анхилуун үнэрийг таашаан соёрхож, дотроо айлдсан нь “Би хүн төрөлхтнөөс болж газрыг дахин хэзээ ч хараахгүй. Хүний зүрхний хандлага нь бүр багаас нь бузар муу байдаг. Би хамаг амьтныг урьдных шигээ дахин хэзээ

ч устгахгүй.

Эхлэл 9:11-13

“Би та нартай гэрээ байгуулна. Хамаг амьтныг дахин хэзээ ч үерийн усанд устгахгүй. Газар дэлхийг сүйрүүлэх үер дахин хэзээ ч болохгүй”. Бурхан “Энэ бол та нартай болон та нартай хамт байгаа бүх амьтантай үеийн үед байгуулах Миний гэрээний тэмдэг болой. Би үүлэнд солонгоо татуулж, тэр нь Миний дэлхийтэй байгуулсан гэрээний тэмдэг болно” гэв.

## Есүс бол Биднийг Аврах Завь

Бурхан хаалгаа хаах тэр цагт хэн ч аврагдахгүй. Бурханы уур хилэн энэ дэлхийд гал болон ирнэ гэдгийг бид мэддэг. Гэвч Бурхан Өөртэй нь хамт алхагч хүмүүст энэ шийтгэлд өртөхгүй байх замыг тавьж өгсөн. “Учир нь Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16). “Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүст өгөгдсөнгүй гэв” (Үйлс 4:12). “Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм. Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно” (Ром 5:8-9). “Бид ийм агуу авралыг үл хайхраад хэрхэн зугтах билээ” (Еврей 2:3а). Ямар гайхамшигтай авралын завь бэ?

Бурхан Ноад хайрцагны гадуур дотуур нь *давирхай* түрх гэсэн нь хачирхалтай. (Эхлэл 6:14). Давирхай гэдэг үг нь Еврей хэл дээрээ “цагаатгал” гэдэг үгээр ч гэсэн орчуулагддаг. Энэ хоёр үг нь хоёулаа “бүрхэх” гэсэн утгыг агуулдаг. Есүсийн цус бидний төлөө урсаж, бидний гэм нүглийг бүрхсэн. Түүний цус биднийг

гэм нүглээс ариусган цэвэрлэдэг.


Ноа гэр бүлийнхээ хамт хайрцганд орон аврагдсан шиг бүх гэр бүлийг аврах нь Бурханы зорилго юм. “**Эзэн Есүст итгэгтүн. Чи болон гэрийнхэн чинь аврагдана гэлээ**” (Үйлс 16:31). Гэвч бид Ноа шиг Бурханы бүх тушаалыг биелүүлэх ёстой. Мөн хүүхдүүдээ ч гэсэн үүнд сургаж, тэднийг хайрлан, уурын мунхгаар тэдэнд ерөөсөө хандаж болохгүй. Бурхан бол бидний тэнгэрлэг Эцэг юм. Тэр Өөрийн Хүүдээ ханддаг шиг хэрхэн танд ханддаг вэ? Тэр танд тэвчээртэй байна уу? Тэр таныг буруутгадаг уу эсвэл урамшуулдаг уу? Тэр таныг баярлуулахын тулд сайн зүйлсийг танд өгдөг үү? Тэр таны бүх жижиг зүйлсийг сонирхож байна уу? Тэр тантай хамт цагийг өнгөрөөдөг үү? Бурхан Өөрийн хүүхдүүдээ халамжилдаг шиг бид ч бас тийнхүү халамжлах хэрэгтэй.

Бурхан гэр бүлийн талаар ямар гүнзгий мэдрэмжтэй явдгаа харуулсан. “**Харагтун, ЭЗЭНий аугаа, аймшигт өдөр ирэхээс өмнө Би эш үзүүлэгч Елиаг та нар уруу илгээнэ. Тэрээр эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлнэ**” (Малахи 4:5-6). Тиймд гэр бүлийнхээ хариуцлагадаа нухацтайгаар хандацгаая.

## ТҮҮХ 8. БАБЕЛИЙН ЦАМХАГ

Эхлэл 11:1-9

Бүх дэлхий нэг хэлтэй, нэг аялуутай байлаа. Тэд дорно зүг уруу нүүж, Шинарын хөндий тал газрыг олж, тэндээ нутагшин суурьшжээ. Тэд бие биедээ “Тоосго цохиж, түүнийгээ бүрэн гүйцэд болтол нь шатаацгаая” гэж хэлээд, чулууны оронд тоосго, шаврын оронд давирхай хэрэглэжээ. Тэгээд тэд “За, бид хот болон тэнгэрт тулам оройтой өндөр цамхаг барьж байгуулан, нэрээ алларшуулсгаая. Эс тэгвээс бид бүх дэлхий дээр тарж бутрах болно” гэж хэлэлцжээ. ЭЗЭН



хүний хөвгүүдийн барьж байгуулсан хот ба цамхгийг үзэхээр бууж иржээ. ЭЗЭН айлдсан нь “Эдгээр хүмүүс нь нэг үндэстэн, нэг хэлтэн учир тэд үүнийг хийж эхэлсэн бөгөөд хойшид тэдний хийхээр төлөвлөсөн ямар ч зүйл тэдний хувьд боломжтой болно. Бид бууцгааж, тэдний хэлийг тэнд нь хутгалдуулан самууруу.гья. Ингэснээр

тэд бие биенийхээ яриаг ойлгохгүй болно” гэжээ. Тэгээд ЭЗЭН тэднийг тэндээс бүх дэлхийгээр тараасанд тэд хот байгуулахаа зогсоожээ. Эзэн тэнд бүх газар дэлхийн хэлийг хутгалдуулан самууруулсан учир түүнийг Бабел гэж нэрлэв. ЭЗЭН тэндээс тэднийг бүх дэлхий даяар тараалаа.

## **Бурхан Хүний Бардам занг хугалдаг.**

Ноагийн ач хүүгийн хүү Нимрод дэлхий дээр хүчирхэг эр болжээ. Тэр ЭЗЭНий эсрэг тэрсэлсэн ба, түүний хаанчлалын зарим хэсэг нь сүүлд Бабелон болсон Бабелийг тойрон төвлөрч байсан юм. (Эхлэл 10:8-10-ыг хар). Энэ түүхэнд Бабелоны хүмүүс тэнгэрт тулам өндөр цамхаг барьж өөрсдийнхөө нэрийг алдаршуулахыг хүссэн тухай гардаг. Тэд Бурханы тушаасны дагуу хаа сайгүй тархахыг хүсээгүй юм. Тэд өөрсдийн бардамнал дотор Сатаны хуурамч шүтээнийг бий болгож Бурханаас холджээ. Түүнчлэн тэд юу хийх гэж буйгаа бардан ярьцгаасан билээ. Бурхан тэднийг Өөрийнх нь эсрэг нэгдэн хөдлөхийг нь зөвшөөрөөгүй тул тэднийг өөр өөр олон хэлээр ярьдаг болгон, үйл ажиллагааг нь зогсоожээ.

Есүс айлдан, “Учир нь надаас салангид байвал та нар юу ч хийж чадахгүй” (Иохан 15:5). “Та бүгд бие биендээ даруу хандах байдлаар өөрсдийгөө хувцасла. Учир нь Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлслээ өгдөг. Иймд Бурханы хүчирхэг мутарын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө” (1Петр 5:5б - 6).

Бурхан Өөрийн хүмүүсээ эв нэгдэлтэй байгаасай гэж хүсдэг. Есүсийг загалмайд цовдлогдсоны дараа буюу Дээгүүр Өнгөрөх баяраас тавин өдрийн дараа болсон Пентекост өдөр Түүний дагалдагчид бүгд “нэг дор хамтдаа” цуглахад Ариун Сүнс тэдний дээр буув. Тэр өдөр “үй олон хүмүүс цугларч, өөрсдийнх нь

**төрөлх хэлээр тэдний ярихыг сонсоод”** ихэд гайхжээ. (Үйлс 2:6).

Христийн жинхэнэ дагалдагчид бусадтайгаа тэр бүү хэл өөр үндэстэн, өөр хэлтэй байлаа ч нэгдлийн сүнсээр дүүрдэг. Учир нь бид бүгдээрээ Христ дотор нэг юм.

Бурханаас салангид, нэгдэхийг хүссэн хүмүүсийн оролдлого нь эцэстээ бүтэлгүйтдэг. Тиймд өөрсдийнхөө төлөө нэр алдрыг олж авах гэсэн юм уу аль эсвэл нэгнээ өргөмжлөх, ид шидийн зүйл хийх гэсэн ямар ч бүлгийн нэг хэсэг болохгүй байцгаая. **“Би тэнгэрээс өөр нэг дуу гарахыг сонсов. “Миний ард түмэн, та нар тэр эмийн нүглүүдэд нь хамтрагч болохгүйн тулд болон түүний гамшгийг хүлээж авахгүйн тулд түүнээс гаратун”** (Илчлэлт 18:4).

## ТҮҮХ 9. БУРХАН АБРАМЫГ ДУУДСАН НЬ



Эхлэл 12:1-5, 7

ЭЗЭН Абрамд айлдсан нь “Чи төрсөн нутгаа, төрөл салангаа, эцгийнхээ гэрийг орхиж, Миний чамд зааж өгөх газар уруу яв. Би чамайг аугаа их үндэстэн болгож, чамайг ерөөн, алдар нэрийг чинь

аугаа их болгоно. Тэгээд чи ерөөлийн үндэс болно. Чамайг ерөөгчдийг би ерөөж, чамайг хараагч нэгнийг Би хараана. Газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан ерөөгдөнө” гэв. Тэгээд Абрам ЭЗЭНий хэлсэн ёсоор явжээ. Лот ч бас хамт явав. Абрам Хараанаас гарч явахдаа далан таван настай байжээ. Абрам өөрийн эхнэр Саран, ач дүү Лот болон Хараанд байхдаа цуглуулсан бүх эд юмс, олж авсан хүмүүсээ аваад явжээ. Тэгээд тэд Канаан нутгийг зорин гараад, тэр газартаа орж ирэв.

ЭЗЭН Абрамд үзэгдэн “Би чиний үр хүүхдүүдэд энэ нутгийг өгье” гэж айлдав. Тэгээд Абрам өөрт нь үзэгдсэн ЭЗЭНд зориулан тэнд тахилын ширээ босгожээ.

## **Бурхан Итгэлийн Хүнийг Сонгодог.**

Энэхүү бидний Эхлэл номын судлал дээр Бурхан дэлхий нийттэй харилцаатай байсан тухай гардаг. Одоо үлдсэн бүлгүүдээс бид Бурхан, дөрвөн агуу эрчүүдтэй хэрхэн харилцаж байсныг харах болно. Тэд бол Абрахам (Бурхан нэрийг нь өөрчлөх хүртэл түүнийг Абрам гэдэг байсан), Исаак, Иаков болон Иосеф нар юм. Тэд бүгдээрээ төгс хүмүүс байгаагүй боловч Бурханд хайртай, Түүгээр ашиглагдсан хүмүүс байсан юм. Та тэдний амьдралаас судалж байхдаа Бурхан тэдний амьдралын жишээнээс юу суралцуулахыг хүсэж байгааг Ариун Сүнснээс асуугаарай. **“Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг энэ үеийн эцэст амьдарч буй бидэнд сануулга болгон бичжээ”**(1Коринт 10:11).

**“Итгэлээр, Абрахам дуудагдахдаа өв болгон хүлээн авах гэж байсан нутаг уруу явснаар дуулгавартай дагав. Тэр хаашаа явж байгаагаа ч мэдэлгүй гарч явав”** (Еврей 11:8). Итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг. (Ром 10:17). Гэвч итгэлийн баталгаа нь дуулгавартай байдал юм. **“Учир нь сүнсгүй бие үхмэл байдгийн адил түүнчлэн үйлсгүй итгэл ч бас үхмэл болой”** (Иаков 2:26). Хүмүүс таны жинхэнэ итгэлийг Бурханы Үгийг дуулгавартай дагаж байгаагаас чинь харж чадах уу?

## **Бурхан Биднийг Сонгосон**

Есүс айлдан, **“Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон. Та нарыг явж жимс ургуулж, та нарын жимс үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон. Ингэснээр Миний нэрээр та нар Эцэгээс юуг ч гуйсан Тэр та нарт өгөх юм”** (Иохан 15:16). **“Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ гэв”** (Иохан 20:216).

Танд утгагүй тэнэг юм шиг санагдаж болох юм. Гэвч Бурхан таныг аврахаар сонгосон юм шүү. **“Миний хайрт ах дүү нараа сонсогтун. Бурхан энэ ертөнцийн ядуусыг Өөрийг нь хайрлагсад амласан хаанчлалын өвлөгчид болгож,**

тэднийг итгэл дотор баян байлгахын тулд сонгоогүй гэж үү?” (Иаков 2:5) Бурхан Абрамд өв амласан шиг танд ч мөн Өөрийн хаанчлалын өвийг амлаж байна. Абрам Бурханыг дагаж Түүний хэлсэн бүхнийг биелүүлэхийн тулд бүх зүйлсээ орхисон. Харин Бурхан *таныг* юу хийлгэхээр дуудаж байна? Тэр таныг Өөрийнхөө төлөө юу хийлгэхээр дуудсан бэ? “Христ Есүсийн сайн цэрэг адил надтай хамт зов. Ямар ч цэрэг цэрэг татагчдаа таалагдахын тулд өдөр тутмын амьдралын хэрэгт хутгалддаггүй” (2Тимот 2:3-4).

### Хийх Зүйлс

Бурхан Абрахамд долоон зүйлийг амласан. Эдгээр нь юу байв?

1. Би чамайг аугаа их \_\_\_\_\_ болгоно (2).
2. Чамайг \_\_\_\_\_ (2).
3. \_\_\_\_\_ чинь аугаа их болгоно (2).
4. Чи \_\_\_\_\_ үндэс болно (2).
5. Чамайг \_\_\_\_\_ Би \_\_\_\_\_ (3).
6. Чамайг \_\_\_\_\_ нэгнийг Би \_\_\_\_\_ (3).
7. Газар дэлхий дээрх бүх \_\_\_\_\_ чамаар дамжуулан \_\_\_\_\_ (3).

## ТҮҮХ 10. АБРАМ ЕГИПЕТ УРУУ ЯВАВ

Эхлэл 12:10-20

Тэр газарт ган болсон учир Абрам Египетэд түр суухаар тийшээ очив. Тэр нутаг маш их гантай байжээ. Тэрээр Египетэд ойртож ирэх үедээ эхнэр Сараидаа өгүүллрүүн “Чи бол үзэсгэлэнтэй сайхан бүсгүй гэдгийг би мэднэ. Египетчүүд чамайг хараад. “Энэ бол түүний эхнэр байна” гэж хэлээд намайг алж, чамайг амьд үлдээнэ. Чи өөрийгөө миний дүү охин гэж хэлнэ үү. Тэгвэл чамаас болж



налад аюул учрахгүй. Миний амь чиний ачаар аврагдана гэжээ. Абрамыг Египетэд очиход нь египетчүүд тэр бүсгүйн маш их үзэсгэлэнтэй сайхныг харжээ. Фараоны түшмэд ч түүнийг хараад, Фараонд магтсанд тэр бүсгүйг Фараоны ордонд хүргэжээ. Фараон Абрамыг тэр бүсгүйн төлөөнөө сайхан байлгаж, Абрамд хонь, үхэр, эр эм илжиг, эрэгтэй, эмэгтэй боол, шивэгчин тэмээ өгчээ. ЭЗЭН Абрамын эхнэр Сарангаас болж

Фараон хийгээд түүний гэр бүлийнхэнд хүнд гай зовлон учруулав. Тэгээд Фараон Абрамыг дуудаж “Чи яагаад налад ингэж хандав аа? Чи яагаад түүнийг эхнэрээ гэж налад хэлсэнгүй вэ? Чи яагаад түүнийг миний дүү охин гэж хэлсэн юм бэ? Тиймээс түүнийг би эхнэрээ болгож авсан юм. Эхнэр чинь энэ байна, одоо аваад яв” гэв. Фараон энэ тухай хүмүүстээ тушаасанд тэд Абрамыг болон эхнэрийг нь хамаг эд юмсынх нь хамт явуулав.

## Бодох Зүйлс

Ган гачигаас болж Абрам өөрийн амьдарч байсан газраа орхиж Египет уруу явжээ. Египетийг судар дээр үргэлж энэ дэлхийн зүйлстэй зүйрлүүлж, боолчлолыг төлөөлүүлсэн байдаг. Тэрээр явахдаа Бурхантай зөвлөөгүй байна. Дараа нь айснаасаа болж худлаа хэлдэг. Саран үнэхээр Абрахамын хойт эцгийн охин мөн байсан боловч тэрээр түүнийг өөрийн эхнэрээ биш гэж ойлгуулахын тулд хүмүүсийг санаатайгаар мэхэлсэн юм. Бурханы хүмүүс ийм үйлдлээсээ болж Бурханд итгэдэггүй хүмүүсээс зэмлэл хүртэж байгаа нь ямар харамсалтай хэрэг вэ! Тэд нар биднээс зан чанарын хувьд өндөр үзүүлэлтийг хүлээж байдаг.

Абрам өөрийгөө *алуулчих* байх гэж бодсон. Буруу бодол нь үргэлж гэм хийх үйлдлийн эхний алхам болдог. “Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг” (2Коринт 10:5). Айдас нь Бурханаас ирдэггүй. Тиймд итгэлтэй бай! “Учир нь Бурхан бидэнд айдсын сүнснийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнснийг өгсөн” (2Тимот 1:7).

Хэдий жижигхэн ч гэлээ нэг удаа гэм хийх л юм бол дараа нь тэр гэмээ дахин үйлдэхэд амархан болчихдог. Эхлэл номын 20-р бүлэг дээр Абрам дахиад гэм хийчихдэг. Магадгүй түүний гэр Египетэд байхад нь Хагар хэмээх бүсгүй тэдний шивэгчин болсноор Абрахамыг ийн үйлдэхэд хүргэсэн байж болох юм. (Түүх 14).

Бурхан эцгүүдийн гэм бурууг гурав, дөрөв дэх үеийг хүртэл үр хүүхэд, ач нарт нь буулгахыг зөвшөөрдөг (Египетээс гарсан нь 34:7). Бид нар эцэг эхийнхээ хувьд өөрсдийн гэм нүглээсээ эргэж, түүнийгээ уучлуулахгүй юм бол яг адилхан гэм нүгэл бидний хүүхдүүдийн амьдралд илрэн гарах болно. Абрахамын мэхлэлт Исаакийн амьдралд ч гэсэн давтагддаг. Түүний эхнэр Ребека нь хойт эцгийн охин байгаагүй боловч тэрээр эхнэрийнхээ тухай яг адилхан худлаа ярьдаг. (Эхлэл 26:1-11). Дараа нь Исаакийн хүү Иаков маш том мэхлэлтэнд оролцдог. (24, 30-р түүхүүд). Иаковын хүүхдүүд мэхлэлтийн тойргийг үргэлжлүүлдэг (Түүх 35).

Тиймд бидний гэм нүгэл үр хүүхдүүдийн маань амьдралд гинжин хэлхээ болохоос өмнө өөрсдийн гэм нүгэлтэйгээ тулж ажиллах нь ямар чухал вэ! Хямралд орох үедээ бид Бурханыг хайх нь ямар чухал вэ! Ингэснээр бид Түүний хүслээс гажихгүй юм. **“Бүх зүрхээрээ ЭЗЭНд итгэ. Өөрийн ойлголтонд бүү түшиглэ. Өөрийн бүх замаараа Түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно”** (Сургаалт үгс 3:5-6).

## **Сараи бол Эхнэрүүдийн Үлгэр Жишээ юм**

Сараи энэ нөхцөл байдалд ихэд айж болох байсан боловч Бурхан, түүний нөхөр нь зөвийг үйлдээгүй ч гэлээ түүнийг хамгаалсан юм. Бурхан эхнэр хүнийг нөхөртөө үглэдэг бус харин үлгэр жишээ болдог байгаасай гэж хүсдэг. Бурхан эхнэр хүний чимэглэл нь **“Бурханы өмнө асар үнэтэй болох дөлгөөн болон даруу”** зан чанар байгаасай гэж хүсдэг. (1Петр 3:4.а). **“Учир нь түүнчлэн урьд цагт Бурханд найдвараа тавьсан ариун эмэгтэйчүүд ч нөхрүүддээ захирагдан өөрсдийгөө**

гоёдог байв” Түүнчлэн Сара Абрахамыг эзэн гэж дуудан дуулгавартай дагасан юм. Хэрэв та нар ямар ч аюулаас айхгүйгээр зөвийг үйлдвэл, тэр эмэгтэйн хүүхдүүд болно” (1Петр 3:5-6). Хэрэв Бурхан эхнэрээс нь нөхрийнхөө бурууг хэлээсэй гэж хүсэх юм бол тэрээр зөв сүнсээр нөхөртэйгөө харьцах хэрэгтэй бөгөөд дараа нь Бурхан нөхрийнх нь зүрх сэтгэлд ажлаа хийхийг зөвшөөрч түүнийг Бурханд даатган орхи. “Сэтгэл минь, Бурханыг л чимээгүй хүлээ, учир нь миний найдвар Түүнээс юм” (Дуулал 62:5).

## ТҮҮХ 11. АБРАМ ЛОТ ХОЁР САЛЖ НҮҮВ



Абрам эхнэр болон хамаг эд юмсаа аваад, Лоттой хамт Египетээс гарч, Негев уруу хөдөлжээ. Абрам мал адгуус, алт мөнгө ихтэй маш баян байжээ. Тэрээр Нигевээс гараад Бетел хүртэл аялж, Бетел, Аи хоёрын хооронд урьд өмнө майхнаа босгож байсан газартаа хүрч ирэв. Тэр нь түүний анх тахилын ширээ босгосон газар байжээ. Тэнд Абрам ЭЗЭНийг дуудав. Абрамтай хамт явсан Лот бас мал сүрэг, майхантай байсан учир тэр газар нь тэднийг хамт

амьдрахад хүрэлцэхгүй байв. Тэдний эд хөрөнгө үлэмж арвин байсан учир нэг дор хамтран амьдрах аргагүй болжээ. Тиймээс Абрамын малчид, Лотын малчид хоорондоо маргалджээ. Бас тэр нутагт канаанчууд болон перезчүүд нутаглан суудаг байлаа. Абрам Лотод “Бид бол ахан дүүс. Чи бид хоёрын хооронд, бас танай, манай малчдын хооронд маргаан бүү гараг! Чиний өмнө энэ бүх газар байгаа биш үү? Чи надаас салж яваач. Хэрэв чамайг зүүн тийшээ явбал, би баруун тийшээ явъя. Хэрэв чамайг баруун тийшээ явбал би зүүн тийшээ явъя гэв. Лот хараагаа өргөн, Иорданы тал хөндийг бүх газартаа ус элбэгтэй, ЭЗЭНий цэцэрлэг шиг мөн Зоар хүртэлх Египетийн нутаг шиг байхыг харав. Учир нь энэ нь Содом, Гоморра хоёрыг ЭЗЭН устгахаас өмнө байв. Тиймээс Лот Иорданы тал хөндийг бүхлээр нь өөртөө сонгож, зүүн тийш нүүжээ. Тэд бие биеэсээ

салцгаав. Абрам Канаан нутагт амьдран сууж, Лот талын хотуудын дунд сууж, майхнаа нүүлгэн, Содомын ойролцоо босгожээ. Содомын хүмүүс хэт хорон муухай, ЭЗЭНий өмнө их нүгэлтэй байв. Лотыг Абрамаас салж

явсны дараа ЭЗЭН Абрамд “Чи хараагаа өргөн, одоо байгаа газраасаа хойд, урд, баруун зүүн зүг уруу харагтун. Чамд харагдаж байгаа тэр бүх газар нутгийг Би чамд болон чиний үр хүүхдүүдэд үүрд өгнө” гэв.

## Абрам Бурханы Хүсэл уруу Эргэж Орсон.

Абрам өөрийн замаар цаашаа явахгүй байхаар шийдсэн юм. Тэрээр дуулгавартай байдлын газар буюу тахилын ширээнд ойртон ирж ЭЗЭНий нэрийг дууджээ. Ингэснээр Тэр эргээд Бурхантай нэгдэж чадсан юм. **“ЭЗЭН унасан бүхнийг өндийлгөж, сөхөрсөн бүхнийг босгодог”** (Дуулал 145:14). “Учир нь тэнгэр газрын дээгүүр өндөрт байдаг шиг Түүнээс эмээгчдэд Түүний хайр энэрэл агуу их юм. Өрнө дорноос хол байдаг шиг Тэр бидний алдаа зөрчлийг биднээс тийн холдуулсан. Эцэг хүн үр хүүхдээ өрөвддөгийн адил ЭЗЭН Өөрөөс нь эмээгчдийг өрөвддөг. Учир нь Тэр Өөрөө биднийг хэрхэн бүтсэнийг мэддэг Бид бол тоос шороо юм гэдгийг Тэр санаж байдаг” (Дуулал 103:11-14). Тэр Өөр рүүгээ эргүүлэхийн тулд биднийг хайрладаг.

Энэ удаа Абрам зөв зүйлийг хийснээр хямрал алга болсон юм. Учир нь тэр амар тайвныг авахын тулд зөв байсан зүйлд бууж өгөхийг хүссэн юм. **“Зүй бусаар олох үлэмж их орлогоос зөв шударгаар олох бага нь дээр”** (Сургаалт үгс 16:8). Лот өөрийн нүдэнд хамгийн сайхнаар харагдсан зүйлээ сонгосон боловч энэ нь түүний сүнсний занга болсон юм. Харин Абрам хувиа хичээгээгүй тул Бурхан түүнд үр хүүхэд нь ч хүртэл амьдрах асар том газар нутгийг өгөхөөр амлаж, түүнийг шагнажээ. Бид Бурханы хүссэн сайн зүйлсийг үйлдэх үед Тэрээр бидний хэрэгцээг хангадаг юм. **“Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно”** (Матай 6:33).

## ТҮҮХ 12. АБРАМ ЛОТЫГ АВАРСАН НЬ

Содомын хаан, Гоморрагийн хаан, Адмагийн хаан Зебойимын хаан, Белагийн (Зоар) хаан хөдөлцгөөж, Сиддимийн хөндийд дайтсан бөгөөд Еламын хаан Хедорлаомер, Гойимын хаан Тидал, Шинарын хаан Амбрафел, Елласарын хаан Ариох нарын эсрэг жагссан буюу таван хааны эсрэг дөрвөн хаан гарчээ. Сиддимийн хөндий давирхайт нүхээр дүүрэн байсан бөгөөд Содом, Гоморрагийн хаадыг зугтахад нэргүүд нь түүнд унаж, үлдсэн нь уул уруу зугтацгаав. Дөрвөн хаан нь Содом, Гоморрагийн хамаг эд юмс, хоол хүнсийг булааж аваад явцгаав. Тэд бас Содомд сууж байсан Абрамын ач дүү Лотыг эд юмстай нь хамт булаан авч оджээ.

Тэгээд Абрам ач дүүгээ баригдсаныг сонсоод, гэрт нь төрсөн бэлтгэгдсэн гурван зуун арван найман хүнийг удирдан, Дан хүртэл нэхэн хөөжээ. Абрам өөрийнхөө хүмүүсийг

тэдний эсрэг хувааж, шөнө дүлээр тэднийг бут цохиод, Дамаскийн зүүн тал дахь Хоба хүртэл элдэн хөөж, булаагдсан эд юмс, ач дүү Лот болон түүний эд юмс, эмэгтэйчүүд, ардууд бүгдийг нь эргүүлэн авчирчээ.

Салемын хаан Мелхизедек талх, дарс аваад гарч иржээ. Тэрээр Хамгийн Дээд Бурханы тахилч байсан бөгөөд Абрамыг ерөөж өгүүлдүүн “Тэнгэр газрын Эзэн, Хамгийн дээд Бурхан Абрахамыг ерөөх болтугай! Та нарын дайсныг гарт чинь тушаасан Хамгийн Дээд Бурхан магтагдах болтугай!” гэв. Абрам түүнд бүх юмны аравны нэгийг өгчээ. Содомын хаанд “Би тэнгэр газрын Эзэн, Хамгийн Дээд Бурхан ЭЗЭНД би чиний гэгдэх юмнаас юу ч авахгүй, ширхэг утас ч юм уу, эсвэл улавчны уяа ч авахгүй гэж тагарагласан юм. Чи “Би Абрамыг баян болгосон” гэж хэлэх вий.

### Бодох Зүйлс

Лот хорон муугаар дүүрсэн газар амьдарч байсан учир тэндхийн хүмүүсийн амьдралынх нь хэв маягаас гарах үр дагаврыг нь амсжээ. Харин та бузар муу замаар амьдарснаас болж гарах ийм шаардлагагүй зөрчилдөөнд өөрийгөө оруулах хэрэг байгаа гэж үү?

Лот хамгийн сайн газрыг сонгож авсных нь төлөө Абрам түүнд өширхөөгүй нь ямар гайхалтай вэ! Түүгээр ч зогсохгүй түүний сүнс Лотыг хэцүү байдалд ороод байхад нь ч туслахад бэлэн байсан юм.

Тэрээр аль хэдийнэ дайнд бэлтгэж, стратеги боловсруулчихсан байсан бөгөөд ялахын тулд хичнээн хол явдаг байлаа ч бүх арга замуудыг хэрэглэхэд бэлэн байв. Бид ч гэсэн хэн Сатанд олзлуулсан байна, хэн Христ дотор ялж чадсан байна гэдгийг хараад мэддэг. Тэгвэл хэрхэн бид сүнсний тулаанд өөрсдийгөө бэлтгэх вэ?

**“Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэр дэх бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ. Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. Тэгээд бат зогс. Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөөд амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс. Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбай, авралын дуулгыг болон Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг ав. Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийн төлөөх цөхрөлтгүй бүх оролдлого гуйлтаараа сэргэг бай” (Ефес 6:12-18).**

Есүс Тахилч-Хаан Мелхизедектэй Адил Юм.

Абрам Содомын бузар, гэмтэй хаанаас нь шагнал авахаас татгалздаг. Тэрээр Бурхан тэнгэр газрын Эзэн тул өөрт нь хэрэгтэй байгаа бүх зүйлийг өгч чадна гэдгийг мэдэж байв. Учир нь Абрам хүнээс бус, Бурханаас хүндэтгэл авахыг хүссэн юм.

Харин Абрам Салемын (магадгүй Иерусалимын) хаан Мелхизедек аравны нэгээ өгдөг. Салем нь “амар тайван” гэсэн утгатай. Харин Мелхизедек нь “зөвт байдлын хаан” гэсэн утгатай үг юм. Өөрт байгаа бүх юмныхаа аравны нэгийг өгснөөр Абрам ерөөгдсөн юм. “Миний өргөөнд хоол хүнс байхын тулд бүхий л аравны нэгээ агуулахад авчир. Би та нарын төлөө тэнгэрийн цонхыг нээж, та нарын төлөө ивээлийг хальтал асгах эсэхийн талаар Намайг одоо үүгээр шалга” гэж Түмэн

Цэргийн Эзэн айлдаж байна” (Малахи 3:10).

Есүс мөн Амар тайвны болон Зөвт байдлын Хаан юм. Түүнчлэн Тэрээр бас Мелхизедекийн дараа үүрд тэргүүн тахилч болохоор ирсэн Нэгэн юм. (Еврейгийн 7-р бүлэг). Тэр бидний аравны нэгийг хүлээж аваад биднийг ивээдэг. Тэр өөрийн няцарсан бие, урссан цус болох талх, дарсыг бидэнд барьдаг ба мөн бидэнд үйлчлэх амийг болон хүчийг өгдөг. Есүс бидний тэргүүн тахилчынхаа хувьд Өөрийгөө бидний төлөө өргөсөн бөгөөд одоо Тэрээр Хамгийн Дээд Нэгэний хажууд бидний төлөө зуучлан залбирахын тулд амьд байгаа билээ. Бид Есүсээр дамжин Бурхан уруу зоригтойгоор очиж болно. Бидний Эзэн Есүс маань ямар гайхамшигтай Хаан-Тахилч вэ!




## ТҮҮХ 13. АБРАМТАЙ БАЙГУУЛСАН БУРХАНЫ ГЭРЭЭ

Түүний дараа ЭЗЭНий үг Абрамд үзэгдлээр ирж, “Абрам аа, бүү ай! Би бол чиний бамбай, чиний шагнал агуу их болно” гэжээ.

ЭЗЭН түүнийг гадагш дагуулан гараад “Чи тэнгэр өөд хар, хэрэв

оддыг тоолж чадваас тоол” гэв. Тэр бас дахин түүнд “Чиний үр удам ийм олон болно гэв. Тэгээд Абрам ЭЗЭНд итгэсэнд ЭЗЭН түүнийг зөвт байдалд тооцуулав. Тэрээр түүнд “Би бол чамд энэ газар нутгийг өгч, өвлүүлэхээр чамайг Халдейн Ураас авчирсан ЭЗЭН байна гэхэд, Абрам “Эзэн БУРХАН минь! Би энэ газрыг өвлөн авахаа хэрхэн мэдэх вэ?” гэсэнд ЭЗЭН Түүнд “Надал зориулж гунжин үнээ, хязаалан эм ямаа, шүдлэн эр хонь, хүүрэлзгэнэ, тагтааны ангаахай ав” гэв. Абрам Тэр бүхнийг авч, тэднийг хоёр таллан хувааж, тал бүрийг өөд өөдөөс нь харуулан тавьжээ. Харин шувууг хуваасангүй. Махчин шувууд тэдгээр сэгэн дээр бууж ирэхэд Абрам тэднийг хөөв. Нар



шингэх үеэр Абрамыг гүн нойрондоо унтаж байтал тунэр харанхуй болон аймшигт айдас түүнийг нөмрөв. ЭЗЭН Абрамд “Чиний үр удмынхан өөрсдийнх нь бүс нутагт харь хүмүүс болж, болоод, дөрвөн зуун жилийн турш зарилгагдаж, дарлагдах болно гэдгийг баттай мэдэж ав. Би тэднийг зарлах үндэстэнт нь шүүнэ. Түүний дараа чиний үр удам, их эд юмстай гарч ирнэ. Харин чи урт наслаад, өвөг дээдэс уруугаа амар тайвнаар очиж,

ясаа тавих болно. Дөрөв дэх үедээ чиний үр удам энэ нутаг уруугаа эргэж ирнэ. Учир нь Аморичуудын гэм нүгэл нь арай дүүрээгүйгээс тэр болой. Нар шингэж харанхуй болох үед утаат зуух болон нөгөө хуваагдсан махнуудыг дайран гарсан галт бамбар үзэгджээ. Тэр өдөр ЭЗЭН Абрамтай гэрээ байгуулж “Би энэ газрыг Египет мөрнөөс их мөрөн Евфрат хүртэл чиний үр удмынханд өгсөн билээ” гэв.

## **Бурхан бол Бидний Бамбай ба Халхавч юм**

Абрам өөрт нь ялагдсан хаадууд эргээд түүн уруу дайрахаас айж болох байсан боловч Бурхан түүнд бамбай нь болохыг амласан юм. Мөн Абрам бузар хаанаас шагнал аваагүй учраас Бурхан түүнийг шагнахаар амласан юм. Тиймд Абрам хүүтэй болохыг Түүнээс хүссэн бөгөөд Бурхан түүнд үнэхээр хүү өгнө гэж амлажээ. Бид ч гэсэн ямар нэгэн хэцүү байдалд орсон үедээ Бурханыг өөрийнхөө бамбай болооч хэмээн гуйж болно. “ЭЗЭН бол миний хүч чадал, миний бамбай юм. Зүрх минь Түүнд итгэдэг бөгөөд би тусыг нь хүртсэн. Тиймээс зүрх сэтгэл минь баярладаг бөгөөд өөрийн дуугаар би Түүнд талархах болой” (Дуулал 28:7). “Харин та нар тууштай байж, бүү зүрх алд. Та нарын ажил шагналтай юм гэв” (Шастирын дэд 15:7). “Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” (Еврей 11:6.6).

## **Цусан Гэрээ**

Эртний үеүдэд хүмүүс НЭГ болохын тулд “цус гаргах” хэрэгтэй болдог байлаа. Хоёр талууд:

1. Хувцсаа солих ёстой. “Өөрт байгаа бүх зүйлээ чамд өгч байна” гэсэн утгатай аж.

2. Сэлэм, бүс, сумаа солилцох ёстой. “Миний бүх хүч чадал чинийх” гэсэн утгатай.

3. Нэрээ солилцох ёстой. “Би бол чи” гэсэн утгатай.

4. Цусаа солих ёстой. “Миний бүх амьдрал чинийх” гэсэн утгатай.

Үүнээс бид Бурхан Абрамтай ийм цусан гэрээг байгуулсныг харж болно. Тэрээр эхлээд Абрамд “**Би бол чиний бамбай**” гэж хэлжээ. Энэ нь Бурханы бүх хүч чадал Абрамын талд байгаа гэсэн утгыг илэрхийлж байна. Дараа нь Бурхан түүнд “**Би чамайг агуу ихээр шагнах болно**” гэж айлдав. Энэ нь Бурхан Абрамд хэрэгтэй бүхнийг өгнө гэсэн утгатай. Эхлэл 17-р бүлэг дээр (Түүх 15) Бурхан Абрамд Абрахам гэдэг шинэ нэрийг өгөв. Тэрээр “Би бол агуу” гэсэн утгатай ЯАВЭЭ (Иохава) нэрнийхээ зарим хэсгээс Абрахамын нэрэнд оруулжээ. Бурхан сүүлд нь Абрахамын нэрийг авч, Өөрийгөө “Абрахамын Бурхан” гэж нэрлэжээ. Эцэст нь өргөлийн амьтад хуваагдсан бөгөөд гэрээ хийж буй хоёр тал зураг 8-д үзүүлсний дагуу хоёр хэсгийг тойрон мөнхийн гэрээний заншил ёсоор явжээ. Бурхан ба дэлхийн гэрэл Есүс Абрахамын газар “гэрээг тасалж” байхад Абрахамыг гүн нойронд автуулсан байлаа.

Бурханд итгэх итгэл нь Түүнийг дуулгавартай дагаснаар батлагддаг. Абрам дуулгавартайгаар амьтдыг авчирч олзны шувуудыг тавьж явуулснаараа Бурханд итгэх итгэлээ харуулсан юм. Сүүлд нь тэрээр цусан гэрээнд орсны тэмдэг болгож хөвч хөндүүлснээрээ Бурханыг дуулгавартай дагасан. Ийнхүү Бурхан Абрамд амлаж байсан бүх зүйлс нь хэлснийх нь дагуу биелсэн юм.

Есүс биднийг мөн Бурхантай харилцах гэрээнд оруулахын тулд ирсэн юм. Тэр бидний гэмийг Өөртөө үүрч, бидэнд зөвт байдлын хувцсыг өмсгөсөн. Бидний сул дорой байдал Түүний хүч чадал дотор төгс болдог. Тэр бидэнд Сүнсний сэлэм ба дайснаудаа ялах бүх эрх мэдлийг өгсөн. Тэр биднийг үргэлж Өөрийнх нь байгаасай хэмээн хүсдэг бөгөөд Өөрөө бидэнтэй үүрд хамт байна гэж амласан. Тэр бидний төлөө цусаа урсгаж, Өөрийн амьдралаа бидэнд дэвсэж өгсөн бөгөөд биднийг Өөрийн найзаа хэмээн

дуудсан! Бид энэхүү гайхамшигтай өөрчлөлт рүү Абрахам шиг итгэлээрээ ордог. “Хэрэв та нар Христийнх юм бол та нар **Абрахамын үр бөгөөд амлалтын дагуу өв залгамжлагчид мөн**” (Галат 3:29). Бурханы *бидэнд* амласан бүх зүйлс биелэх болно. “Тиймээс итгэлийн хүмүүс нь **Абрахамын хөвгүүд юм гэдгийг мэдэж ав**” (Галат 3:7). “Тиймээс итгэлийн хүмүүс итгэгч **Абрахамын хамт ерөөгдсөн ажээ**” (Галат 3:9).

*Бидний* итгэлийн хариуцлага нь юу байх хэрэгтэй вэ? “Иймд **ах дүү нар аа, өөрсдийн биеэ Бурханд тааламжит амьд, ариун тахил болгон өргөхийг Бурханы өршөөлөөр та нараас хичээнгүйлэн гуйя. Энэ нь та нарын сүнслэг мөргөл мөн**” (Ром 12:1).

Ямар өндөр дуудлага вэ! Абрахам шиг, бидэнд төлөвлөсөн Бурханы зорилгод саад болж буй “олзны шувуудыг” тавьж нисгэхийн тулд бид өөрсдөөс шалтгаалах бүх зүйлсийг хийх хэрэгтэй. “Тиймээс Бурханд захирагдагтун. Дяаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна. Бурханд ойртогтун. Тэгвэл Тэр та нарт ойртоно. Гараа цэвэрлэ... зүрхээ ариусга. (Иаков 4:7-8а).

## **ТҮҮХ 14. ХАГАР БА ИШМАЕЛИЙН ТҮҮХ**

Абрамын эхнэр Сарай түүнд ямар ч хүүхэд төрүүлээгүй ажээ. Тэрээр Хагар нэртэй нэгэн Египет зарц бүсгүйтэй байв. Сарай Абрамд “**ЭЗЭН** намайг төрөхийг зөвшөөрсөнгүй. Тийм учраас та миний зарц бүсгүйтэй унтана уу? Би түүгээр дамжуулан хүүхэдтэй болж магадгүй гэсэнд Абрам Сарайг үгэнд оржээ. Абрамыг Канаанд арван жил суусны дараа Абрамын эхнэр Сарай Хагар гэдэг Египет зарц бүсгүйгээ авчирч, өөрийн нөхөр Абрамд татвар эм болгон өгчээ.

Тэгээд Абрам Хагартай унтсанд, Хагар жирэмслэв. Хагар өөрийн жирэмсэн болсноо мэдээд, өөрийн эзэгтэйг доромжлох болов. Сарай Абрамд “Миний хийсэн алдаа ган дээр буух болтугай! Би зарц бүсгүйгээ таны гарт өгсөн. Одоо Тэрээр жирэмсэн болсноо мэдээд, намайг доромжилж байна. Та бид хоёрын хоорондохыг **ЭЗЭН** шүүг гэв. Абрам Сарайд “Чиний зарц бүсгүй чиний л гарт байна. Чи түүнийг яамаар байна, түүнийгээ л хий гэв. Тэгээд Сарай Хагартай ширүүн харьцсанд

Хагар түүнээс зуггаажээ. ЭЗЭНий тэнгэр элч цөлийн нэгэн булгийн дэргэдээс Шур хүрэх зам дахь булгийн дэргэдээс, Хагарыг олж “Сараигийн зарц бүсгүй Хагар аа! Чи хаанаас ирээд хаашаа явж байна вэ?” гэсэнд тэрээр “Би Өөрийн эзэгтэй Сараигаас зугтаж явна гэж хариулжээ. ЭЗЭНий тэнгэр элч түүнд “Чи эзэгтэйдээ буцаж очоод, гарын дор нь дуулгавартай бай” гээд, ЭЗЭНий тэнгэр элч түүнд бас “Би чиний үр хүүхлүүдийг ихэл өнөр өтгөн,

тоолж баршгүй болгоё” гэв.

Хагар өөртэйгөө ярьсан ЭЗЭНийг “Та бол хардаг Бурхан” гэж нэрлэжээ. Учир нь Хагар “Түүнийг харсаны дараа би энд амьд үлдлээ гэж үү?” хэмээв.

Тэгээд Хагар Абрамд хүү төрүүлсэн ба Хагарын төрүүлсэн тэр хүүд Абрам Ишмаел гэдэг нэр өгөв. Хагар Ишмаелыг Абрамд төрүүлж өгөхөд Абрам наян зургаан настай байжээ.

## Бодох Зүйлс

Хагар өөрийгөө харамсмаар нөхцөл байдалд орсноо мэдсэн бөгөөд зугтжээ. Асуудлын зарим нь түүний бурууд байгаагүй юм. Бурхан Өөрийн амлалтаа Өөрийн арга замаар Өөрийн зөв цагт биелүүлнэ гэдэгт Абрам Сараи хоёр итгээгүйн улмаас Хагар зовлон амссан юм. Гэвч зарим нь Хагарын буруу байсан. Тэрээр бардамнаж, Сараиг үл хүндэтгэжээ. Харин Бурхан түүн дээр ирж түүнийг тайвшруулсан нь ямар гайхалтай вэ! Тэр түүнд зарим гайхамшигтай зүйлсийг амлаж, мөн түүнд тушаал өгөв. Хагар эргээд өөрийн эзэгтэйн гар дор захирагдаж эхэлжээ. **“Христээс эмээн нэг нэгэндээ захирагд”** (Ефес 5:21). Бурхан биднээс үүнийг хэрэгжүүлэхийг хүсдэг. Захирагдаж байна гэдэг нь үнэ цэнэгүй эсвэл чухал ач холбогдолгүй болж байна гэсэн утгатай биш юм. Санагтун, Есүс Өөрийн Аавтайгаа эн тэнцүү атал Тэрээр Бурханд захирагдаж байсан. Өөрийн нөхцөл байдалд хүлцэнгүй (Бурханы таны амьдралд бий болгохыг хүсэж буй зүйлсийг хүлээн зөвшөөрч түүн дотор баярлах) байснаараа бид өөрсдийн жинхэнэ итгэлийг Бурханы мэргэн ухаан хийгээд Түүний захиргаан дотор харуулдаг.

## ТҮҮХ 15. ХӨВЧ ХӨНДӨЛТ НЬ БУРХАНЫ ГЭРЭЭНИЙ БЭЛЭГ ТЭМДЭГ ЮМ

Эхлэл 17:1-5,10, 15-16, 23

Абрамыг ерэн есөн настай байхад ЭЗЭН Абрамд үзэгдэж “Би бол Төгс Хүчит Бурхан. Чи Миний өмнө явж, гэм зэмгүй байгтун. Би чи, бид хоёрын хооронд гэрээ байгуулж, чамайг ман их өнөр өтгөн болгоно” гэв. Абрам нүүрээрээ газарт унасанд Бурхан түүнд “Миний хувьд гэвэл, Би чамтай гэрээ байгуулна. Чи тоо томшгүй олон үндэстний өвөг болно. Би чамайг олон үндэстний өвөг болгосон учир үүнээс хойш чамайг Абрам гэхгүй, харин Абрахам гэх болно”

Та нарын доторх эр хүйстэн болгон хөвч хөндөх ёслолыг үйлдэх

ёстой. Энэ бол чи болон чамаас хойших чиний үр удмынхан сахих ёстой Миний гэрээ.

Бурхан Абрахамд “Чи эхнэрээ Сараи гэж дуудахгүй, түүний нэрийг Сара гэнэ. Би түүнийг ерөөж, түүгээр чамд хүү өгөх болно. Би түүнийг ерөөж, үндэстнүүдийн эх болгон, улсын хаад түүнээс гарна” гэв.

Абрахам Ишмаел хүүгээ, бас гэртээ төрсөн бүхнээ, мөнгөөрөө худалдаж авсан бүх хүн, гэрийнхний бүх эр хүйстэнг аваад, Бурханы хэлсэн ёсоор яг тэр өдөртөө хөвч хөндөх ёслол үйлджээ.

### Бодох Зүйлс

Абрам Бурханаас амласан хүүгээ өөрийн хүчээр авах гэж оролдсоноос хойш арван гурван жилийн дараа Бурхан түүнтэй дахин ярив. Тэрээр Өөрийн амласан бүх зүйлээ биелүүлэх төгс чадвартай “Бүхнийг Чадагч” гэдгээ түүнд сануулжээ. Дараа нь Абрамд Өөрийнх нь өмнө явж төгс байхыг хүссэн юм. Бид Бурханы өмнө явж байхад бидний нэг алхам ч гэсэн Түүний нүдэнд гүйцэд, бүрэн төгс харагддаг. “Бүхнийг Чадагч” Бурханы гараар хөтлүүлэх ямар нэгэн зүйлс таны амьдралд байна уу? Та өөрийнхөө хүчээр хийх гэж бүү оролд. Та болж өгөхгүй байгаа бүх асуудлаа жагсаан бичээд Түүний гарт өг. “Өөрийн замыг ЭЗЭНд даатга, мөн Түүнд итгэж найд. Тэгвэл Тэр биелүүлж өгнө” (Дуулал 37:5).

Абрам шинэ нэрээ Бурханаас хүлээж авсан итгэлийн алхам нь юу байв! Абрам гэдэг нь “олны эцэг” гэсэн утгатай нэр юм. Өөрийн арга замаар олж авсан ганц хүүтэй Абрамын хувьд

энэ нэр нь түүнд ичгэвтэр байгаагүй гэж үү? Тэрээр одоо Абрахам буюу “өсөн үржилтийн эцэг” гэсэн утгатай нэртэй болсон юм. Харин бид боломжгүй мэт харагдах зүйлстэй тулгарах үед Бурхан бидний итгэлийг хэрхэн сунгах бол!

Абрахам Бурхантай байгуулсан гэрээгээ сахих үед Бурхан түүнд эр хүн бүр хөвч хөндүүлэх ёстой гэж айлдахад тэрээр Түүнийг тэр даруй дуулгавартайгаар дагав.

Хөвч хөндөлт нь сүнсний хувьд ач холбогдолтой хирнээ махан биеийг огтлох үйлдэл юм. Харин Сүнсний хөвч хөндөлт нь бид өөрсдөө бус Бурханаар, гэм хийх хүслээ болон махан биеийн дагуух амьдралаа таслуулж буй хэрэг юм. **“ЭЗЭН Бурхан чинь чамайг өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэлээрээ хайрладаг болгохын тулд чиний зүрхэнд, чиний үр хүүхдүүдийн зүрхэнд хөвч хөндөх ёслол хийнэ”** (Дэд хууль 30:6). Энэ бол таныг Бурханы хүн гэдгийг батлан харуулах *гадаад* хөвч хөндөлтийн талаар яриагүй, харин дотоод - **“Сүнсээр хийлгэсэн зүрх сэтгэлийн”** (Ром 2:29) хөвч хөндөлтийн тухай өгүүлж буй юм. Бид *Христ* дотор бүрэн төгс болгогдсон. **“Христийн хөвч хөндөх ёслолоор махбодын биеийг тайлан, Түүн дотор та нар бас хүний гараар үйлдэгдээгүй хөвч хөндөх ёслолыг хийлгэсэн. Ингэхдээ та нар баптисм дотор Түүнтэй хамт оршуулагдсан. Түүнийг үхэгсдээс амилуулсан Бурханы үйлсэд итгэсэн итгэлээр баптисм дотор та нар бас түүнтэй хамт амилуулагдав”**(Колоссой 2:11-12) Хэрэв бид загалмай дээр бидний төлөө үхсэн Христийн үхлийг өөртөө хүлээн авах юм бол тэр үхэл нь бидний хуучин, гэмтэй биесийг үхүүлэх боломжтой болгоно. Харин Христийн дахин амилалт нь бидэнд шинэ амьдралаар амьдрах хүчийг өгдөг. Бид ямар нэгэн гэмд хүлээтэй байх ёсгүй.

**“Тиймд та нар садар самуун, бузар байдал, тачаал, муу хүсэл, шунахайрал болох шүтээн шүтэх явдал зэрэг газар дээрх эрхтнүүдийг үхүүл... Харин эдүгээ та нар бас уур, хилэн, хорон санаа, гүтгэлэг болон амнаас гарах жигшүүрт үгс бүгдийг нь зайлуулж хаягтун. Бие биедээ бүү худал ярь. Яагаад гэвэл та нар хуучин хүнээ бузар муу зуршилтай нь**

хажуу тийш тавьж, өөрийг нь бүтээсэн Түүний дүр төрхийн дагуу үнэн мэдлэгт шинэчлэгдэж буй шинэ хүнийг өмссөн” (Колоссой 3:5, 8-10).

Харин ариун хүмүүст үл нийцэх садар самуун, аливаа бузар булай, шунал нь та нарын дунд бүү дурсагдаг. Бузар булай болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. Харин оронд нь талархлаа өргө. Садар самуун, бузар булайг үйлдэгч, шүтээнийг шүтэгч шунахай ямар ч хүнд Христийн болон Бурханы хаанчлалд өв байхгүй гэдгийг та нар ойлго” (Ефес 5:3-5).

Давид хэлэхдээ “Хууль бус явдал нь уучлагдаж, Нүглүүд нь далдлагдсан хүмүүс нь ерөөлтэй” (Ром 4:7). Тэрээр зөвт бус амьдраагүй хирнээ Бурханд зөвт хэмээн тооцогдсон хүний ивээлийг ингэж тодорхойлжээ. Абрахам хөвч хөндүүлсний улмаас биш харин итгэлээрээ зөвтгөгдсөн гэдгийг бид харж байна. Хөвч хөндөлт нь Бурханд аль хэдийнэ зөвт хэмээн тооцогдож тамгалуулсны дараа ирдэг. “Абрахам хөвч хөндүүлээгүй үедээ итгэлийн зөвийн тамгаар хөвч хөндөх ёслолын тэмдгийг хүлээн авчээ. Тэр хөвч хөндүүлэлгүй итгэх бүх хүмүүсийн эцэг нь болж, тэднийг зөвд тооцуулахын тулд ингэжээ” (Ром 4:11). Бид энд ч тэнд ч тэр муу зуршлаа хийхээ больсноороо өөрсдийгөө зөвт болгож чадахгүй юм. Бид гэмтэй хүмүүс учир Христ рүү ирж Түүнд итгэх итгэлээрээ зөвт байдлын бэлгийг хүлээж авах хэрэгтэй. Христ бидний гэмийг Өөртөө үүрч бидний төлөө үхсэн гэсэн энэхүү үнэнийг бид хүлээн зөвшөөрөх үед итгэлээрээ бүх гэм нүглүүд маань Христтэй хамт цовдлогдож уучлагдсан гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Хэрэв бид амьдралдаа ямар нэг гэм юм уу эсвэл Бурханы өмнө тааламжгүй ямар нэгэн зүйл байгааг олж харах юм бол түүнийгээ загалмай дээр авчирч үхүүлж болно. Ингэснээрээ бид өөрсдийнхөө дотор Христийн хүчирхэг дахин амилалтыг чөлөөлж, зөвт байдал дотор Түүнд үйлчлэхэд бэлэн болдог. “Тиймд эдүгээ Христ Есүс дотор байгаа хүмүүст ямар ч ял байхгүй. Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн

ажээ.

Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно” (Ром 8:1-2, 13). Христийн зөвт байдал нь итгэлээр дамжуулан аль хэдийнэ бидний төлөө бэлэн байдаг боловч бид Түүнтэй байгуулсан гэрээний тэмдэг болох өөрсдийнхөө дотор оршдог Сүнсний хүч чадлаар, Түүний тушаасан бүхнийг амьдралаасаа хөөн зайлуулах ёстой.

## ТҮҮХ 16. АБРАХАМ ГУРВАН ГИЙЧНИЙГ ЗОЧЛОВ



ЭЗЭН Мамрегийн царс модны дэргэд Абрахамд үзэгдэв. Өдрийн халуул Абрахам майхныхаа үүдэнд сууж байгаад, хараагаа өргөн харгал дэргэд нь гурван хүн зогсож байлаа. Тэрээр тэднийг харангуугаа угтан тосохоор майхныхаа үүднээс яаран гүйж хүрээд, газарт бөхийн сөглөж, “Эзэн мишэ ээ! Хэрэв би таны таалалд нийцсэн бол, өчүүхэн зарц намайгаа битгий орхин өнгөрөөрэй хэмээн би гүйж байна. Жаахан ус авчруулж, та нар хөлөө угааж, энэ модны доор амарна уу? Би жаахан талх авчирья, тэгээд та нар түр амсхийгээд тэнхээ

орж, аян замдаа гараарай. Та нар зарцынхаараа дайрч ирсэн учир ийм болой гэв. Тэд “Чиний хэлсэн ёсоор болог” гэв. Абрахам гэртээ санд мэнд гүйж ороод, Сарад “Түргэлээрэй! Гурван сеа дээд зэргийн гурил аваад зуурч, бин хий гээд Абрахам хот уруугаа гүйн очоод, нэгэн тарган сайн бяруу барьж авчраад, зарцдаа өгсөнд зарц түүгээр нь хоол бэлтгэх гэж яаравчлав. Абрахам эздем, сүү болон зарцынхаа болгосон махыг тэдний өмнө авчирч тавиал, тэднийг хооллох зуур өөрөө модны доор зогсож байв. Тэд Абрахамаас “Чиний эхнэр Сара хаана байна вэ?” гэж асуусанд “Майхандаа байна” гэж хариулав. Тэр “Би дараа жилийн энэ үед чамд заавал эргэж ирнэ. Тэгээд чиний эхнэр Сара хүүтэй болох болно” гэжээ. Сара ард нь, майхны үүдэнд зогсоод сонсож байжээ. Абрахам, Сара хоёр өндөр наслан өтөлж, Сара хүүхэд гаргах наснаасаа хэдийнээ хэтэрчээ. Сара дотроо инээж, өгүүдрүүн, “Би хөгширчихөөд

байхад, мөн эзэн маань ч бас өгөлчихөөд байхад би яаж жаргалтай болох юм бэ?” гэв. ЭЗЭН Абрахамд “Яагаад Сара инээгээд “Хөгшин болсон би үнэхээр хүүхэдтэй болж чадна гэж үү” гэж хэлээд байна вэ? ЭЗЭНд дэндүү хэцүү юм байдаг гэж

үү? Би тогтоогдсон цагт чамд эргэж ирнэ. Дараа жилийн энэ үед Сара хүүтэй болсон байна” гэв. Сара айсандаа “Би инээгээгүй” гэж мэлзсэнд “Үгүй чи инээсэн шүү дээ” гэж Тэр хэлэв.

## Эзэнд Дэндүү Хэцүү Юм Байдаг Гэж үү?

Эхлээд Сара Бурханы амлалтыг сонсоод, өөрийн итгэлгүй байдлаасаа болж инээдэг. Гэвч дараа нь тэрээр Бурхан түүнд хүү өгч чадна гэдэгт итгэснийг бид мэдэж байгаа. Бурхан итгэлгүй байхад ажлаа хийдэггүй. “Итгэлээр, Сара хүртэл хэдийгээр нас нь хэтэрсэн боловч үртэй болох хүчийг авсан байна. Учир нь Тэр Амлагчийг итгэмжит гэж үзсэн юм” (Еврей 11:11). Бурхан Сарагийн инээхийг мэдэж байсан шигээ бидний бүх бодлуудыг болон Өөрийнх нь амлалтыг эсэргүүцэж байгаа бүх дотоод эсэргүүцлийг мэдэж байдаг.

Есүсийн эх Мариаг нөхөрт гараагүй байхад нь тэнгэр элч түүнд хандан “Чамаас Месиа Аврагч мэндлэх болно гэж айлдаад “Учир нь Бурханд боломжгүй юм гэж нэг ч байхгүй” гэж түүнд хэлэв. (Лук 1:37). Дараа нь түүний садан Елизабет түүний тухайд “Эзэнээс өөрт нь айлдсан зүйл биелнэ гэдэгт итгэсэн тэр эмэгтэй ерөөлтэй ээ!” хэмээв. (Лук 1:45). Бурханд итгэхийн тулд өртөг төлдөг.

## ТҮҮХ 17. АБРАХАМ ЛОТЫН ТӨЛӨӨ ЗУУЧЛАН ГҮЙВ

### Эхлэл 18:16-33

Тэдгээр хүмүүс тэндээс босоцгоож, Содомын зүг харж, Абрахам тэднийг үдэхээр хамт гарчээ. ЭЗЭН Би хийх гэж байгаа юмаа Абрахамаас нууна гэж үү? Абрахам агуу их, хүчирхэг үндэстэн

болж, дэлхийн бүх үндэстэн түүгээр дамжуулан срөөгдөх биш үү? Би түүгээр, түүний хүүхдүүд болон гэр бүлийнхэнд тушаалгаж ЭЗЭНий замаар дагуулан, зөв ба шударга ёсыг үйлдүүлэхээр Би түүнийг сонгож авсан юм. Энэ нь ЭЗЭН түүний

тухай хэлснээ Абрахамд биелүүлэхийн тулд болой гэв. Тэгээд ЭЗЭН “Содом, Гоморра хоёрын хашхираан үлэмж их болсон бөгөөд тэдний гэм нүгэл маш хүнд ажээ. Би одоо доош бууж, тэдний хийсэн бүхэн нь надад сонсогдсон хашхираан шигээ эсэхийг Би үзэж мэдье гэв. Тэр хүмүүс тэндээс явж, Содомын зүг одоход, Абрахам ЭЗЭНий өмнө зогссоор хоцорчээ. Абрахам ойртон ирж, “Та зөв шударга хүнийг бузар муу хүнтэй нь хамт устгах уу? Тэр хотод хэрэв зөв шударга хүн тавь байсан ч, Та тэр газрыг устгах уу? Тэрхүү тавин зөв шударга хүний төлөө тэр газрыг өршөөхгүй юу? Зөв шударга хүнийг бузар муу хүнтэй адилтган тэднийг хамтад нь алах ийм зүйл хийх нь Танаас хол байг! Газар дэлхийн Шүүгч Та үнэн шударгыг баримтлахгүй гэж үү? гэв. ЭЗЭН “Хэрэв би Содом хотынхны дотроос зөв шударга хүн тавийг олбол тэдний төлөө бүх газрыг өршөөнө” гэсэнд Абрахам “Би өөрөө тоос шороо мэт өчүүхэн амьтан боловч Эзэнд үг

хэлэхээр зүрхэллээ. Хэрэв тавин зөв шударга хүнд таван хүн дутвал та тэр таван хүнийг дутсаны учир бүх хотыг устгах уу? гэв. ЭЗЭН “Хэрэв Би тэндээс дөчин таван хүнийг олбол хотыг устгахгүй” гэсэнд Абрахам дахин “Тэндээс дөчин хүн олбол Та яах вэ?” гэсэнд “Дөчин хүний төлөө Би түүнийг устгахгүй” гэв. Абрахам “ЭЗЭН минь, Та битгий уурлаарай. Би бас нэг үг хэлье. Хэрэв тэндээс гучин хүн олдвол Та яах вэ?” гэсэнд “Хэрэв Би тэндээс гучин хүнийг олбол устгахгүй” гэж хариулжээ. Абрахам “Би Эзэнд үг хэлэхээр зүрхэлье. Хэрэв тэндээс хорин хүн олдвол, Та яахсан бол?” гэсэнд “Хорин хүний төлөө Би устгахгүй” гэжээ. Абрахам дахин “Эзэн Та битгий уурлаарай. Би одоо ганцхан удаа нэмж хэлье. Хэрэв тэндээс арван хүн олдвол, яах вэ?” гэсэнд “Би арван хүний төлөө түүнийг устгахгүй” гэж хариулжээ. ЭЗЭН Абрахамтай яриагаа дуусгангуутаа одоход, Абрахам ч бас өөрийн газар уруу харьжээ.

## Абрахам Бурханы Найз Байсан

“Абрахам Бурханд итгэсэн. Энэ нь түүнийг зөвт байдалд тооцогдуулсан юм” гэж өгүүлдэг. Абрахам Бурханы анд нөхөр гэж дуудагдах болсон” (Иаков 2:23). Есүс айлдан: “Хэрэв та нар Миний тушаасныг хийвэл, та нар Миний нөхөд мөн. Би та нарыг боолууд хэмээн дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол мэддэггүй юм. Харин Би та нарыг анд нөхөд хэмээн дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ. (Иохан 15:14-15).

Абрахам Бурханд итгэсэн бөгөөд Түүнийг дуулгавартай дагасан юм. Бурхан Абрахамыг найзаа хэмээн үзсэн учраас түүнтэй Содом, Гоморра хотуудыг устгах гэж байгаа төлөвлөгөөгөө хуваалцав. Үүнийг сонсоод тэрээр Содомд амьдарч байгаа Лот үеэлийнхээ төлөө зориглон Бурханаас өршөөл эрж эхлэв.

Бурхан Өөрийн найз Абрахамыг сонссон бөгөөд хэдийгээр Содомыг устгасан ч гэлээ Лотыг эсэн мэнд үлдээсэн юм. Бид хэрхэн залбирах ёстойгоо мэддэггүй. Тэглээ гээд бид залбирахаа больж болохгүй. Хэдийгээр Бурханы зорилго биелэх ёстой байсан ч бидний залбирал Түүний төлөвлөгөөнд өөрчлөлтийг авчирдаг.

Лотын төлөөх Абрахамын зуучлан залбирал нь онцгой байсан. Тэр маш даруу **(Би өөрөө тоос шороо мэт өчүүхэн амьтан боловч)** хирнээ итгэлтэйгээр залбирч байсан. (Тэрээр бүх дэлхийн Шүүгч зөвийг үйлдэнэ гэдгийг мэдэж байв). Тиймд бид ч гэсэн эргэн тойрондоо байгаа Бурханы шүүлтэнд бэлэн бус байгаа хүмүүсийн төлөө онцгойгоор зуучлан залбирах хэрэгтэй. Бурхан дэлхийг галаар шүүх гэж байгаа гэдгээ бидэнтэй хуваалцсан. Бурхан шударга хийгээд зөв шүүлтийг хийнэ гэдэгт бид бүрэн итгэж болно.

## ТҮҮХ 18. БУРХАН СОДОМ ГОМОРРА ХОТУУДЫГ УСТГАВ.



Эхлэл 19:1-17, 24-26

Хоёр тэнгэр элч Содомд үднээр иржээ. Лот Содомын дааман хаалган дээр сууж байгаад, тэднийг харж, босон утгаад, толгой гудайлган газарт бөхийн сөгдөв. Эзэнтнүүд минь ээ! Зарцыхаа гэрээр орж, хөлөө угааж, хоноод, маргааш өглөө эрт босож аян замдаа гарна уу? гэсэнд тэд “Үгүй, бид гадаа талбайд хононо” гэв. Тэгээд Лот тэлээс хүчлэн гуйсанд тэд гэрт нь оржээ. Лот тэдэнд хоол

унд бэлтгэн, исгээгүй талх барьж өгсөнд тэд идэцгээв. Тэднийг хэвтэхийн өмнө тэр хотынхон буюу Содомынхон хөгшин залуугүй бүгдээрээ дөрвөн зүгээсээ цугларч, гэрийг нь бүсэлж, Лотыг дуудан “Энэ шөнө танайд ирсэн хүмүүс хаана байна вэ?” Тэднийг гаргаж ир, бид тэдэнтэй хурьцаагаая!” гэв. Лот тэдэнтэй уулзахаар гарч ирээд, хаалгаа араасаа хааж “Ах дүү нар минь ээ! Ийм муухай зүйл битгий хийгээрэй! Надад эр хүнтэй хавьтаагүй хоёр охин бий. Би тэднийг та нарт авчирья. Та нар хүссэнээрээ тэднийг эдэл! Харин энэ хүмүүс миний гэрт ирсэн учир тэдэнтэй юу ч битгий хийгээрэй” гэв. Тэд “Зам тавьж өг!” гээд “Манай энд ирсэн энэ цагаач бидний шүүгч болох гэж үү? Одоо бид тэднээс илүү чамайг хорлоно” гээд Лотыг хүчээр түлхэж, хаалгыг нь эвдэхээр дөхөж очив. Нөгөө хүмүүс нь гараа сунган, Лотыг гэрт татан оруулаад, хаалгыг нь хааж, гэрийн гадаа байсан хүмүүсийг хөгшин залуугүй бүгдийг юу ч харахгүй болгосонд, тэд гэрийн хаалгыг нь олох гэсээр ядрав. Нөгөө хүмүүс Лотод хандаж, “Танайхнаас өөр хэн хэн байна вэ? Чи хүргэнүүдээ, хүүхдүүдээ, хотод байгаа харьяатуудаа бүгдийг хотоос гадагш

гарга. Тэдний хашхираан ЭЗЭНий өмнө үлэмж их болсноос энэ газрыг устгуулахаар ЭЗЭН биднийг илгээсэн тул бид энэ газрыг устгах гэж байна” гэв. Тэгээд Лот гадагш гарч, охидтой нь сүй тавьсан хүргэддээ ЭЗЭН энэ хотыг устгах гэж байна. Босооцоо! Эндээс гарцгаа!” гэв. Гэвч хүргэд нь түүнийг тоглоом хийж байна гэж боджээ. Үүр пайх үеэр элч нар Лотыг ятган, “Түргэл! Энд байгаа эхнэр болон хоёр охиноо авчир. Эс тэгвэл та нар энэ хотын гэм нүглийн дунд хамтдаа устгагдах болно” гэжээ. Харин Лотыг тээнэгэлзэхэд тэр хүмүүс түүний гараас болон эхнэрийнх нь, мөн хоёр охиных нь гараас зууран авав. Учир нь ЭЗЭН түүнд өршөөнгүй ханджээ. Тэгээд тэд түүнийг гадагш гарган, хотын гадна аваачив. Нөгөө хүмүүс тэднийг хотоос гадагш гаргаад, “Зугтаа, амиа хамгаалагтун! Бүү эргэж хар! Энэ хээр талд бүү үлд! Уул уруу зугт! Эс тэгвэл та нар устгагдах болно” гэв. ЭЗЭН Содом, Гоморра дээр хүхэр болон галыг тэнгэрээс буюу ЭЗЭНээс бороо мэт буулгажээ. Тэгээд Тэрээр тэдгээр хот, тал хөндийг бүхлээр нь бас хотод амьдарч байсан хамаг амьтан, газрын ургамал бүгдийг хөмрөн сүйрүүджээ.

## Гэмтэй Ойрхон Амьдарсны Гашуун Үр жимсүүд

Лот Абрахамтай хамт амласан газар уруу явах үедээ сайн газрыг сонгосон боловч тэрээр зөрүүдлэн эд хөрөнгийг хайрласан тул энэ нь түүний буруу сонголт болсон юм. Содом

нь үнэхээр аймшигтай гэмтэй хот байв. Ижил хүйстэнтэйгээ явалдагчид нь хотоор нэг тархсан байсан бөгөөд оршин суугчид нь зөвт амьдрахыг хүсдэггүй байв. Лот энэ бузар газар хэрхэн ирж суурьшсаныг бид хараахан мэдээгүй байгаа.

**Эхлэл 13:11** Лот Иорданы тал хөндийг сонгожээ.

**Эхлэл 13:12** Тэр Содомын ойролцоо майхнаа босгожээ.

**Эхлэл 14:12** Тэр Содомд амьдарч байв.

**Эхлэл 19:1** Тэр Содомын дааман хаалган дээр сууж байлаа. Энэ нь тэр газартаа эрх мэдэл бүхий байр суурьтай байсан гэсэн утгатай. Тэрээр шүүгдэх хүмүүсийн нэг нь болчихсон байв.

Абрахам Лотыг аврахын тулд түүнд Содомд амьдарсны улмаас гарах муу үр дагаваруудын талаар сануулсан. (Түүх 12). Гэвч Лот итгэлийн амьдралдаа бууж өгснөөрөө тухайн хотдоо болон өөрийн гэр бүлдээ нэр хүндгүй болсон байв. Түүний нөлөө нь ( тэр хотын эрчүүдэд өөрийн охидыг санал болгосон!) охидуудынхаас нь ч илүү дор байлаа. (Тэд сүүлд нь аавыгаа согтсоны дараа түүнтэй хурьцал үйлдэж цус ойртуулсан юм. Үүний үр дүнд Абрахамын бурханлаг үрийн эсрэг Лотын эцэглэл болох Аммон Моаб зэрэг үхлийн дайснууд гарч ирсэн юм). Лотын өөрийнх нь эхнэр Содомд үнэхээр дасчихсан байсан тул хот уруу эргэж хараад давсан багана болон хувирчээ. Лот хэзээ ч Абрахам шиг Бурханд зориулж тахилын ширээ босгож байгаагүйг библи өгүүлдэг. Гэрийн эзэн Бурхантай ойр харилцаатай байхыг эрмэлздэггүй бол ямар харамсалтай вэ!

Бурхан бурханлаг бус амьдралаар амьдарч байгаа хүмүүс дээр ямар шийтгэл буулгах тухайгаа Содом Гоморрагаар жишээ болгон харуулсан юм. **"Учир нь хэрэв Бурхан... ёс зарчимгүй хүмүүсийн садар самуун явдлаар дарамтлагдсан зөвт Лотыг аварсан юм бол (учир нь тэрхүү зөвт хүн тэдний дунд амьдрах зуураа өөрийн харж, сонссон тэдний ёс бус явдлаас болж зөвт сэтгэл нь өдрөөс өдөрт шаналан зовж байлаа) бурханлаг хүмүүсийг сорилтоос яаж ангижруулахыг**

**болон зөвт бус хүмүүсийг шүүлтийн өдрийг хүртэл шийтгэлийн доор яаж барьж байгаа Эзэн мэддэг”** (2Петр 2:4а, 7-9).

Бурхан Өөрийн хүмүүсээ бузар үйлээсээ эргэ хэмээн дуудаж байна. “Би тэнгэрээс өөр нэг дуу гарахыг сонсов. “Миний ард түмэн, та нар тэр эмийн нүглүүдэд нь хамтрагч болохгүйн тулд болон түүний гамшгийг хүлээж авахгүйн тулд түүнээс гарагтун” (Илчлэлт 18:4).

Тиймээ, Лот Бурханаар зөвт хэмээн тооцогдсон юм. Хэдийгээр тэр өөрөө аврагдсан ч гэлээ түүний насан туршийн ажил болон эд хөрөнгө нь бүгд шатаагдаж үгүй болсон юм. “Хэрэв хэн нэгний ажил шатвал тэр хүн хохирол амсана. Тэр өөрөө гал дундуур гарсан мэт боловч аврагдана. (1Коринт 3:15). Лотын амьдрал бидэнд ямар их сургамж болно вэ!

Есүс “Лотын эхнэрийг санагтун. Хэн өөрийн амийг хадгалахыг хичээнэ, тэр хүн түүнийгээ алдана. Хэн амиа алдана, тэр хүн түүнийгээ аварна” (Лук 17:32-33).

“Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла. Хэрэв хэн нэгэн нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцэгийн хайр байхгүй” (1Иохан 2:15). “Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал нь өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлддэг нэгэн нь мөнхөд оршдог” (1Иохан 2:17).

## **ТҮҮХ 19. ИСААК ТӨРСӨН НЬ**

Эхлэл 21:1-7

ЭЗЭН хэлсэн ёсоороо Сарагийн д айлчилж, мөн ЭЗЭН амласан ёсоороо Сарагийн төлөө үйлджээ. Сара жирэмсэлж, Бурханы түүнд хэлж тогтоосон пагт нь нас өтөлсөн Абрахамд хүү төрүүлж өгөв. Абрахам өөрт нь төрсөн хүүдээ буюу Сарагийн төрүүлж өгсөн хүүд Исаак гэдэг нэр өгөв. Исаакийг найман хоногтой байхад нь Абрахам Бурханы

тушааснаар түүнд хөвч хөндөх ёслолыг үйлджээ. Абрахам өөрийн хүү Исаакийг төрөхөд зуун настай байлаа. Сара “Бурхан надад инээмсэглэл авчирлаа. Сонсогч хэн бүхэн надтай хамт инээх болно” гэв. Сара “Сара хүүхдүүдээ хөхүүлж гэж Абрахамд хэн хэлэх байсан юм бэ? Гэлээ ч би Абрахамыг нас өтөлсөн үед нь хүү төрүүллээ” гэв.

## Итгэл нь Шагнагддаг

“Исаак” гэдэг нэр нь “инээгч” гэсэн утгатай. Сара нэгэн итгэлгүй байдал дотроо инээж байсан бол одоо тэрээр баяр хөөрийнхөө улмаас инээж байна. Шинэ амьдрал бий болж байхад тэнд ямар их баяр хөөр байх бол оо! Тэгвэл гэмт хүн гэмээ гэмшиж Сүнсээр төрөх үед тэнд ямар агуу баяр хөөр байх бол оо! Тэнгэрт тэр чигээрээ баяр хөөр болдог.

Та Бурхан доторх авралынхаа төлөө болон шинэ амьдралынхаа гайхамшгийн төлөө Түүнд талархдаг уу?

Амлалтын хүү нь Абрахам, Сара хоёрын оролдлогоор бус Бурханы ер бусын ажлын улмаас төрсөн юм. “Харин Бурханы амлалтын талаар тэр үл итгэн тээнэгэлзэлгүй, харин ч итгэлээр хүчирхэгжихдээ Бурханд алдрыг нь өргөн, Бурхан амласнаа биелүүлэх чадвартай гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. Тиймээс энэ нь түүнийг зөвт байдалд тооцуулсан ажээ” (Ром 4:20-22). Исаакаар дамжуулан дэлхий ерөөгдсөн. Исаакаар дамжуулан Израиль үндэстэн бий болсон юм. Исаакийн үр удмаас бидний Аврагч Есүс Христ мэндэлсэн юм. Баярлагтун!

### ТҮҮХ 20.

Эхлэл 21:8-20



Хүү өсөж, хөхнөөсөө гарчээ. Исаакийн хөхнөөсөө гарсан өдөр Абрахам том найр хийжээ. Египет бүсгүй Хагарын Абрахамд төрүүлсэн хүү нь Исаакийг дооглож байгааг Сара хараад, Абрахамд хандаж “Энэ зарц бүсгүй, түүний хүү хоёрыг зайлуул. Энэ зарц бүсгүйн хүү миний хүү Исаактай хамт өв залгамжлахгүй” гэжээ. Хүүгийнх нь талаарх энэ зүйл Абрахамыг ихэд зовоов. Бурхан Абрахамд “Чи тэр хүү, зарц бүсгүй хоёроос болж сэтгэл бүү зов. Сарагийн чамд хэлсэн

бүгдийг сонс. Учир нь Исаакаас төрсөн нь л чиний үр улам гэж дуудагдах болно. Харин зарц бүсгүйн хүү ч чиний үр учир Би түүгээр нэгэн үндэстэн бий болгоно гэв. Абрахам өглөө эртлэн босож, талх болон туламтай ус авч, Хагарын мөрөнд үүрүүлээд, хүүтэй нь хамт явуулжээ. Хагар тэндээс гарч, Бершибагийн зэлүүд талаар тэнүүчлэн явав. Туламтай ус нь дуусаж, Хагар хүүтээ нэгэн бутны доор тавьж орхиод “Би хүүгийнхээ үхэхийг харж байж чадахгүй” гээд харвасан сумны тусгалын газар очиж, хүүгийнхээ

эсрэг харж суугаад, дуугаа өндөрсгөн уйлав. Бурхан хүүгийн уйлахыг сонсоод, Бурханы тэнгэр элч тэнгэрээс Хагарыг дуудаж “Хагар аа! Юу болсон бэ? Бүү ай. Учир нь Бурхан тэнд байгаа хөвгүүний дууг сонсжээ. Бос, хөвгүүнийг босгож гар дээрээ ав! Учир нь Би түүгээр том үндэстэн бий болгож өгье” гэв. Бурхан Хагарын нүдийг нээсэнд, тэр усны ундарга олж хараад, очиж тулмаа усаар дүүргэн, хөвгүүндээ уулгалаа. Бурхан тэр хөвгүүнтэй хамт байж, хөвгүүн өсөж том болжээ. Тэр зэлүүд талд амьдран сууж, харваач болов”

## Ишмаел Исаакийг Шоолов

Ишмаелын амьдрал бидэнд өөрийнхөө хүчээр зүтгэдэг хүний дүр төрхийг харуулдаг. Бидний хуучин хүн, махан бие маань аливаа зүйлсийг өөрийнхөө арга замаар хийхийг хүсдэг. Харин Исаак бол Бурханы гайхамшиг буюу Сүнсээрээ Бурханыг дагахыг хүсэж буй шинэ хүний дүр төрх юм. “Ах дүү нараа та нар, Исаакийн адил амлалтын хүүхдүүд билээ. Харин тэр үед махан биеэр төрсөн нь Сүнсээр төрснийгөө хавчсантай адил түүнчлэн эдүгээ мөн тэгж байна. Гэтэл Судар юу гэж хэлдэг вэ? “Шивэгчний хүү эрх чөлөөт эмэгтэйн хүүтэй хамт өв залгамжлах ёсгүй учраас шивэгчин болон түүний хүүг хөөж явуул” гэдэг. Тиймээс ах дүү нараа, бид шивэгчнийх биш, харин эрх чөлөөт эмэгтэйн хүүхдүүд билээ” (Галат 4:28-31).

Анхны төрсөн хүүгээ явуулж байгаа нь Абрахамд үнэхээр хэцүү байсан. Гэвч Бурхан түүнд эхнэрийнхээ дуу хоолойг сонсож хүүгээ хол явуулахыг айлдсан юм.

Пууль хуучин хүний тэмцэл болон бидний дотор байдаг шинэ хүний тухай дүрслэн харуулсан байдаг. “Би доторх хүнийхээ хувьд Бурханы хуульд баярладаг. Гэвч миний эрхтнүүдэд өөр хууль байдаг бөгөөд тэр нь миний оюун ухааны

хуультай дайтаж, намайг өөрийн минь эрхтнүүдэд байдаг нүглийн хуулийн хоригдол болгодог юм байна гэдгийг би харж байна. Би юутай хөөрхийлөлтэй хүн бэ! Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ?” (Ром 7:22-24). Пууль хариултыг нь мэдэж байсан юм. “Бидний Эзэн Есүс Христээр Бурханд талархал нь байх болтугай!” (Ром 7:25а).

Бид махан биеийн дагуу бус Сүнсний араас алхахыг сонгох ёстой. “Махан биеийн бодол санаа бол үхэл, Сүнсний бодол санаа бол амь ба амар тайван болой. Яагаад гэвэл махан биеийн бодол санаа бол Бурханы эсрэг дайсагнал юм. Учир нь энэ нь Бурханы хуульд захирагддаггүй бөгөөд тэгж чадах ч үгүй. Махан бие дотор байгсад Бурханд таашаагдаж чадахгүй. Хэрэв Бурханы Сүнс үнэхээр та нарын дотор оршиж байвал, та нар махан бие дотор бус, харин Сүнс дотор байна. Хэрэв хэн нэгэнд Христийн Сүнс байхгүй бол тэр Түүнийх биш” (Ром 8:6-9).

Бидний хуучин хүн Христтэй хамт цовдлогдсон. Тэгвэл яагаад бид нар өөрсдийгөө хянахаа үргэлжлүүлэх ёстой гэж? “Тиймд ах дүү нараа бид махан биеийн дагуу амьдрахын тулд махан биед өртөнгүүд биш. Учир нь хэрэв та нар махан биеийн дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно” (Ром 8:12-13).

Та зүрх сэтгэлийнхээ аль нэгэн хэсэгт хуучин хүн “Ишмаел”-ыг хүлээн зөвшөөрсөн байна уу? “Ингэхдээ хойшид биднийг нүгэлд боолчлуулалгүй, нүглийн биеийг маань хүчингүй болгохын тулд бидний хуучин хүн нь Түүнтэй хамт цовдлогдсоныг бид мэддэг. Түүнчлэн та нар өөрсдийгөө нүгэлд үхсэн боловч Бурханд Христ Есүсээр амьд байгаа гэж тооц. Тиймээс биеийнхээ тачаангуй хүслүүдэд дуулгавартай байх ёстой хэмээдэг үхлийн биед чинь нүгэл бүү ноёрхог. Тэгэхэд та нар одоо ичиж байгаа зүйлсээс ямар үр жимс авсан бэ? Учир нь тэдгээр зүйлсийн төгсгөл бол үхэл болой. Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрэх үр жимс

авдаг. Төгсгөл нь мөнх амь болой” (Ром 6:6, 11-12, 21-22). Бид нар шинэ бүтээлүүд бөгөөд Бурханы Сүнс дотор алхах Түүний хүч чадал бидэнд өгөгдсөн. Тиймд таны зүрх сэтгэл амар тайван байж чадна.

## Бурхан Хагарыг Халамжлав

Хэдийгээр бидний дуулгавартай байдал бусдад зовлон авчрах байсан ч гэсэн бид Бурханыг үргэлж дуулгавартай дагах ёстой. Абрахам Бурханыг дуулгавартай дагах үед Тэрээр Хагарыг гайхамшигтайгаар халамжилсныг бид харсан.

## ТҮҮХ 21. БУРХАН АБРАХАМЫН ИТГЭЛИЙГ ШАЛГАВ



Эхлэл 22:1-18

Үүний дараа Бурхан Абрахамыг шалгаж туршихаар түүнийг дуудаж, “Абрахам аа! гэсэнд Абрахам “Би энд байна” гэжээ. Бурхан “Чи өөрийн хүү, порын ганц хайртай хүү Исаакаа аваад Мориа гэдэг газар уруу яв. Миний зааж өгөх нэг уулан дээр, тэндээ түүнийг шатаалт тахил болгон өргө” гэв. Абрахам өглөө эртлэн

босоод илжгээ эмээлэж, хоёр зарц залууг өөрийн хүү Исаакийн хамт дагуулж, шатаалт тахилын модыг огтлон аваад хөдөлж, Бурханы өөрт нь зааж өгсөн тэр газар уруу явжээ. Гурав дахь өдөр нь Абрахам хараагаа өргөн, тэр нутгийг алсаас харав. Тэгээд Абрахам зарц залуустаа “Та хоёр илжигтэйгээ энд хүлээж бай. Хүү бид хоёр тийшээ явж, мөргөөд, та нар уруу эргэж ирнэ” гэв. Абрахам шатаалт тахилын модыг авч, хүү Исаактаа үүрүүлж, өөрөө гал, хутга хоёроо гартаа бариад хоёулаа хамт явжээ. Исаак эцэг Абрахамдаа хандан, “Аав минь ээ!” гэж дуудахад тэрээр, “Хүү минь, би энд байна” гэсэнд Исаак “Хараач, гал ба мод энд байна. Харин шатаалт тахилын хурга нь хаана байна вэ? гэхэд Абрахам “Хүү минь шатаалт тахилд зориулж Бурхан Өөрийгөө хургаар хангана” гээд хоёул цааш явжээ.

Бурханы түүнд зааж өгсөн газарт тэд хүрч ирээд, Абрахам тэнд тахилын ширээ босгож, модоо бэлтгэжээ. Тэрээр хүү Исаагаа хүлж, тахилын модон дээр тавив. Тэгээд гараа сунган, хүүгээ алахаар хутгаа авав. ЭЗЭНий тэнгэр элч тэнгэрээс түүнийг “Абрахам аа, Абрахам аа!” гэж дуудсанд тэрээр “Би энд байна” гэв. Тэнгэр элч өгүүллүүн “Хөвгүүнд гар бүү хүр! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ надаас харамлаагүй тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ” гэв. Абрахам хараагаа өргөн ажиглахад, нэгэн эр хонь өтгөн бутанд эврээрээ тээглэснийг харав. Абрахам очиж, тэр эр хонийг барьж аваад, хүүгийнхээ оронд түүнийг шатаалт

тахил болгон өргөжээ. Тэгээд Абрахам тэр газрыг “ЭЗЭН хангана” гэж нэрлэсэн учир хүмүүс өнөөг хүртэл “ЭЗЭНий ууланд хангагдах болно” гэж хэлдэг болжээ. ЭЗЭНий тэнгэр элч Абрахамыг хоёр дахь удаагаа тэнгэрээс дуудаж, “ЭЗЭН ийн айлдаж байна. “Чи ийнхүү үйлдэж, хүүгээ цорын ганц хүүгээ Илаас харамлаагүй учир Би Өөрийн нэрийг барьж тангараглах нь, Би үнэхээр чамайг ерөөж, чиний үрсийг тэнгэрийн одод, далайн эргийн элс мэт асар олон болгоно. Чиний үрс дайснуудынхаа үүд хаалгыг эзлэн авах болно. Бас чи Миний үгийг дуулгавартай дагасан учир газар дэлхийн бүх үндэстэн чиний үрсээр дамжуулан ерөөгдөх болно” гэв.

## **Жинхэнэ Итгэл нь Дуулгавартай Байдал уруу хөтөлдөг**

Абрахам Бурханд үнэхээр итгэлтэй байсан тул тэрээр Бурхан Өөрийнхөө амлалтуудыг Исаагаар дамжуулан биелүүлнэ гэдэгт бат итгэж, хүүгээ Бурханд өргөх гэж байсан. Тэрээр Бурхан өөр тахилын хургаар хангаж чадна гэдгийг болон хэрэв хүсвэл Тэрээр Исаакийг үхэгсдээс дахин амилуулж чадна гэдгийг ч мэдэж байсан юм. (Еврей 11:17-19). Абрахам Бурхан бол үнэхээр сайн гэдгийг мэдэж байсан учраас бат итгэлтэй байсан. Тэрээр янз бүрийн зүйлд итгэлээ дасгалжуулан Бурхан итгэмжтэй гэдгийг харсан учраас түүний итгэл ийнхүү хүчирхэгжсэн юм. Абрахам өөртэйгөө явж байсан эрчүүдэд хандан хүү Исаактайгаа хамт явж, мөргөчихөөд хоёул буцаж ирнэ гэж хэлсэн байна.

Исаак Есүс хоёр хоёулаа үхлийн ирмэгт ирчихээд байхдаа ч аавдаа захирагдаж байсан юм. Исаак том болчихсон байсан тул аавынхаа хүслийг эсэргүүцэж болох байсан боловч тэгээгүй.

Мөн Есүс хүн төрхийг олоод “үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов” (Филиппой 2:8). Исаак тахилд хэрэглэх модоо авчирсан бол Есүс загалмайд үүрч иржээ. (Иохан 19:17). Энэ утгаараа энэ хоёр маань хоёулаа модон дээр хэвтсэн гэсэн үг. Исаакийн оронд Бурхан өөр тахил өргөх хургыг өгсөн бол харин Есүс *бидний* нүглийн төлөө үхэхээр Бурханаас илгээгдсэн Хурга байсан юм.

Абрахам Бурханд итгэж Исаакийг тахил болгон өргөхөөр шийдэх үед Исаак үхсэнээс өөрцгүй болсон юм. Гэвч Абрахам шийдвэр гаргаснаас хойш *гурав* дахь өдөртөө хүүгээ үхлээс “эргүүлэн авчээ”. Яг үүнтэй адил Есүс загалмайд цовдлогдсоноосоо хойш гурав дахь өдрөө дахин амилсан юм. Есүсээр ч тэр, Исаакар ч тэр газар дэлхийн бүх үндэстэн ерөөгдсөн билээ.

## ТҮҮХ 22. АБРАХАМ ИСААКТ ЭХНЭР АВЧ ӨГӨХӨӨР ЭРЭЛД ГАРАВ



Хэрвээ танд Библи байгаа бол Эхлэл 24-р бүлэг дээр байдаг гайхамшигтай түүхийг уншихыг хүсэж байна. Сара нас барсан байв. Абрахам Исаак хүүдээ бурханлаг бус Канаанчуудаас биш харин Месопотамид байдаг өөрийнхнөөсөө эхнэр сонгож авч өгөхийг хүсчээ. Тийнхүү тэрээр итгэлт зарц Елиезерийг явуулав.

Елиезер өөрийнх нь аян замыг удирдаж, ивээж өгөхийг Бурханаас чин сэтгэлээсээ залбирчээ. Ийнхүү тэрээр үдшийн үеэр буюу эмэгтэйчүүдийн ус авахаар гардаг үеэр хотын гаднах худгийн дэргэд иржээ. Тэр Бурханд хандан ингэж залбирав. “Би

нэгэн охинд “Чи ваараа тонгойлгож, уснаасаа надад уулгана уу?” гэхэд тэр бүсгүй “Уу! уу! Би бас таны тэмээг ч усалж өгье” гэж хэлбэл тэр нь таны зарц Исаакт Танаас заяасан хүн мөн болно. Түүгээр та миний эзэнд хайр энэрэл үзүүлснийг би мэднэ” гэв. (Эхлэл 24:14).



Түүнийг залбирч дуусаагүй байхад Абрахамын дүүгийн ач охин Ребека гарч ирээд Елиезерт ус уухыг зөвшөөрч, дараа нь тэмээг нь усалж өгье гэж хэлжээ.

Елиезер түүнийг хэн болохыг нь асууж мэдээд Бурханыг магтаж, өөрийг нь Өөрийнхөө замаар удирдсанд нь талархав. Тийнхүү тэрээр Ребекагийн гэр бүлийнхэнд болсон явдлыг баяртайгаар өгүүлэхэд тэд Бурхан үүнийг хийж буйг мэдэрчээ. Тэд Ребекагаас “**Чи энэ хүнтэй хамт явах уу?**” гэж асуусанд тэрээр “**Би явна**” хэмээн хариулжээ. (Эхлэл 24:58).

Тэд явсаар аян замынхаа төгсгөлд ирэхэд Ребека Исаагийг хээр талд явж байхыг харжээ.

Үдэш болсон байсан тул тэр бясалгал хийхээр гарсан байжээ. “**Исаак Ребекаг эх Сарагийнхаа майханд дагуулан ороод, түүнийг эхнэрээ болгон авч, хайрлан дурлажээ. Эхийгээ нас барснаас хойших Исаакийн уй гашуудал нь ингэж тайлагдав**” (Эхлэл 24:67).

### **Удирдлагын Тухай Хичээл**

Абрахамын зарц Бурханы илчилсэн зарчим дээр тулгуурласан удирдлагыг эрэлхийлсэн. Эхлээд тэр Бурханы хүмүүсийн дундаас Исаакт эхнэр олж өгөх гэж хайсан. Дараа нь тэр сонголтыг нь баталж өгөх нөхцөл байдалтай учруулж өгөхийг

Бурханаас гуйжээ. Тиймээс Ребека тэмээг нь усалж өгөхийг хүсэж байсан, түүний гэр бүлийнхэн нь түүнийг явахыг зөвшөөрсөн, мөн тэр өөрөө явна гэж хэлж байжээ. Гуравдугаарт зарц Бурханы хүсэл мөн болохын бүрэн баталгааг дотроо мэдэрчээ. **“Христийн амар тайван нь та нарын зүрхэнд ноёрхох болтугай”** (Колоссой 3:15a). Бид өөрсөддөө Бурханы удирдлагыг баталгаажуулахын тулд дээрх гурван алхмуудыг хийх хэрэгтэй.

## **Гэрлэлтийн Тухай Хичээл**

Абрахам Исаакт эхнэр сонгож авч өгөхийн төлөө маш их залбирчээ. Бид ч гэсэн хүүхдүүдийнхээ хань болох хүнийг тохирсон гэж бодож байлаа ч залбирах хэрэгтэй бөгөөд Бурханы сонголтонд итгэх нь чухал. Бурхан хүүхдүүдээ Өөрийнхөө гэр бүлийн хэн нэгэнтэй нь гэрлээсэй гэж хүсдэг. **“Үл итгэгчдийн хамт нэг буулганд бүү орогтун. Зөвт байдал ба ёс бус нь яаж хамтрах билээ? Гэрэл ба харанхуйн хооронд ямар нөхөрлөл байдаг билээ?**

**Бурханы сүм ба шүтээнүүдийн хооронд ямар зөвшилцөл байх билээ? Учир нь бид амьд Бурханы сүм мөн. Бурхан айлдахдаа “Би тэдний дотор оршино, Би тэдний дунд алхана. Би тэдний Бурхан болно.Тэд миний ард түмэн болно.Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай” гэж ЭЗЭН айлддаг. “Бузар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, та нарын Эцэг чинь болно. Та нар ч Миний хөвгүүд, охид болно” гэж Төгс хүчит Эзэн айлддаг”(2Коринт 6:14,16-18) гэжээ.**

## **Христийн Дүр ба Түүний Сүйт Бүсгүй**

**“Тиймээс эр хүн эцэг эхээ орхиж, эхнэртэйгээ нийлдэг. Тэр хоёр нэг махан бие болно”. Энэ нууц бол агуу билээ. Гэвч би Христ болон чуулганы тухай хэлж байна”** (Ефес 5:31-32).

Эхлэл номын түүхэнд гардаг баатрууд бүгд өнөөдөртэй холбоотой шинж тэмдгүүдийг илэрхийлсэн байдаг.

**АБРАХАМ** бол Тэнгэрлэг Эцэгийн гайхамшигтай дүр зураг. Абрахам болон Тэнгэрлэг Эцэг хоёр хоёулаа гайхамшгаар төрсөн ганц хүүхдүүдтэй. Хоёр хүү хоёулаа өргөл болохыг хүсэж байсан ба хоёулаа нэг газар өргөл болон өргөгджээ. (Мория Уул бол сүүлд Иерусалимд баригдсан дуганы газар юм) Дараа нь хоёр хүүгээ хоёуланг нь баяр хөөртэйгөөр хүлээн авчээ. Мөн хоёулаа хүүгийнхээ хуриманд маш анхаарч бэлджээ.

**ИСААК** бол Есүс Эзэний дүр төрх. Исаак Есүс хоёр хоёулаа тахил болон өргөгдсөн. Мөн хоёулаа сүйт бүсгүйгээ хайдаг. Есүс Исаак шиг сүйт бүсгүйгээ эрхэмлэн хайрлажээ. **“Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла”** (Ефес 5:25).

**ЕЛИЕЗЕР** бол Хүүдээ сүйт бүсгүй олж өгөхөөр Эцэгээс илгээгдсэн Ариун Сүнсийг төлөөлж байгаа юм. Ариун Сүнс Бурханы Хүү Есүс Христэд сүйт бүсгүйг олж өгөх цорын ганц шалтгааны улмаас Пентекост өдөр (Үйлс 2:1-41) бууж ирсэн. Елиезер Месопотамид байхдаа байнга Абрахам болон Исаакийг хүндэлж байсан. Харин Ариун Сүнс Христийг үргэлж гэрчилдэг. (Иохан 15:26).

**РЕБЕКА** бол Есүс Христийн Сүмийн дүр зураг юм. Хэн нэгэн хүн Христийн сүйт бүсгүйн нэгэн хэсэг болохоосоо өмнө тэр эрэгтэй /эмэгтэй/ хүн хуучин амьдралаа орхиж, Христийг дагах шийдвэрийг өөрөө гаргах ёстой. Та Христтэй нүүр нүүрээрээ учрах үеийг хүртэл бүх амьдралынхаа турш Ариун Сүнсний удирдлага дор амьдрахаар шийдвэр гаргасан уу?

**“Хурсан олон түмний дуу хоолой шиг, их усны дуу шуугиан шиг, хүчит аянгын нүргээн шиг дуу гарахыг би сонсов. “Халлелуяа! Төгс хүчит Эзэн [бидний] Бурхан хаанчилдаг. Баярлан хөөрч, баясан цэнгэж, Түүнд алдрыг нь өргөцгөөе. Учир нь Хурганы хурим болж, Түүний сүйт бүсгүй өөрийгөө бэлдэв. Тэрээр гялалзсан, цэвэрхэн нарийн маалингаар хувцаслах болжээ. Учир нь тэрхүү нарийн маалинг бол ариун хүмүүсийн зөвт үйлс юм”** (Илчлэлт 19:6-8).

## ТҮҮХ 23. ИАКОВ БА ЕСАВ ХОЁРЫН ТҮҮХ

Эхлэл 25:19-34.

Абрахамын хүү Исаакийн үр удам нь ийм болой. Абрахам Исаакийг төрүүлж, Исаак дөчин настайдаа Паллан-арамын арам хүн Бетуелийн охин, арам хүн Лабаны охин дүү Ребекаг эхнэр болгон авчээ. Исаак эхнэрээ жирэмслэхгүй болохоор нь түүний төлөө ЭЗЭНд залбирсанд ЭЗЭН гуйлтыг нь сонсож, эхнэр Ребека нь жирэмсэлжээ. Хүүхдүүд нь эхийнхээ хэвлий дотор тэмцэлдсэнд “Надад юунд ийм зүйл тохиолдоно вэ?” гэж хэлээд, Ребека ЭЗЭНээс асуухаар одов. ЭЗЭН түүнд “Чиний хэвлий дотор хоёр үндэстэн байна. Чиний биенээс хоёр үндэстэн салах бөгөөд нэг үндэстэн нь нөгөөгөөс хүчтэй ба том нь багадаа зарглагдах болно” гэлээ. Түүний төрөх болоход хэвлийд нь ихэр хүүхэд байжээ. Түрүүлж гарсан хүүхэд нь улаан, бүх бие нь үстэй арьс шиг байсан учир түүнд “Есав” гэдэг нэр өгчээ. Дараа гарсан дүү нь Есавын өсгийнөөс гараараа зуурч гарсан учир түүнд “Иаков” гэдэг нэр өгчээ. Ребека

тэднийг төрүүлэхэд жаран настай байлаа. Хөвгүүд нь өсөж, Есав нь гарамгай анчин болж, хээр талын хүн болсон атал, Иаков нь номхон дөлгөөн хүн болж, майхандаа суудаг байлаа. Исаак Есавын агнасан ангийн маханд дуртай учир Есавдаа хайртай, харин Ребека нь хүү Иаковдаа хайртай байв. Иаковыг шөл буцалгаж байтал, Есав хээрээс өлсөж ядран эргэж иржээ. Есав Иаковд хандаж “Би өлсөж ядарсан учир чи улаан шөлнөөсөө надад идүүлнэ үү?” гэжээ. Иймээс Есавыг Елом гэж дуулах болжээ. Иаков “Ууган хүү байх эрхээ өнөөдөр надад худалдаач” гэсэнд Есав “Би үхэх гэж байна. Ууган хүү байх эрх надад ямар ашигтай юм бэ?” гэжээ. Иаков “Өнөөдөр надад тангарагла!” гэсэнд Есав тангараглаж, ууган хүү байх эрхээ Иаковд худалджээ. Иаков түүнд эрс буурцагтай шөл талхтай өгсөнд тэрээр идэж уугаад, босож явав. Есав ууган хүү байх эрхээ илгэж үл тоомсорлов.

### Хийх Зүйлс

1. Исаак эхнэрээ \_\_\_\_\_ болохоор нь \_\_\_\_\_ төлөө. ЭЗЭНд залбирсанд ЭЗЭН гуйлтыг нь сонсож, эхнэр Ребека нь \_\_\_\_\_. (21-р ишлэл).
2. Исаак \_\_\_\_\_ настайдаа Ребекаг эхнэр болгон авчээ. (20). Ребека тэднийг төрүүлэхэд Исаак \_\_\_\_\_ настай байлаа (26). Тэгэхээр Исаак \_\_\_\_\_ жил хүлээжээ.
3. Ребекад нэгэн асуудал тулгарчээ. Хүүхдүүд эхийнхээ хэвлий

дотор \_\_\_\_\_ тул Ребека ЭЗЭНээс асуухаар одов (22).  
ЭЗЭН түүнд “Чиний хэвлий дотор хоёр \_\_\_\_\_ байна. (23).  
\_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ зарцлагдах болно (23). [Бурхан Есав, Иаковын  
удам болох Едом, Изриалийн тухай өгүүлж байжээ.]

Таны болон таны дотны хэн нэгний чинь амьдралд залбирах хэрэгтэй ямар нэгэн утга учиргүй зүйл байна уу? Мөн сэтгэл ханамж өгч чадах итгэлийг Бурханаас гуйх хэрэгтэй ямар зөрчил танд байна вэ? **“Өөрийн зовлонгийн өдөр би Таныг дуудна. Учир нь Та надад хариулна”** (Дуулал 86:7).

4. Исаак Есавын агнасан \_\_\_\_\_ дуртай учир \_\_\_\_\_ хайртай байжээ (28).

5. Ребека нь \_\_\_\_\_ хайртай байв (28). Иаков нь \_\_\_\_\_ хүн болж, \_\_\_\_\_ суудаг байлаа (27). Есав гарамгай \_\_\_\_\_ болж, \_\_\_\_\_ хүн болжээ (27).

[Абрахам хоол хүнс дутмаг байсан учраас өөрийнхөө төлөө Бурханы газрыг орхижээ (Түүх 10); Абрахамын хүү Исаак ангийн маханд дуртай байсан учир нэг хүүгээ (тэр хүү нь үнэнийг үл тоомсорлодог байсан ч гэсэн) нөгөөгөөс нь илүү хайрлажээ; Исаакийн хүү Есав ууган хүүгийн эрхээ нэг аяга хоолоор худалджээ. Тэгэхээр бид эндээс нэг үед байсан сул дорой байдал хоёр дахь, гурав дахь үедээ улам бүр доройтож байгааг харж байна.]

Та хүүхдүүдээсээ өөрийнхөө ямар сул талыг олж харсан бэ? Та өөрийнхөө амьдралд ямар муу зүйлсийг хийсэн бэ? **“Эхлээд нүднээсээ дүнзээ авч хая, тэгвэл чи ах дүүгийнхээ нүднээс үртсийг авч хаяхдаа сайн харах болно”** (Матай 7:5).

## **Есав Ууган Хүүгийн Эрхээ Худалдав.**

Ууган хүүгийн эрхэнд дараах гурван зүйл агуулагддаг.

1. Тэр гэр бүлийнхээ толгой нь болох байсан.
2. Тэр сүнслэг удирдлагыг гартаа авах байсан.
3. Тэр хоёр дахин илүү өв залгамжлалыг хүлээн авах байсан.

Есав ганц аяга хоолны төлөө энэ бүгдийгээ яагаад өгчихөв өө? Еврей 12:16 дээр Есавыг нүгэлт (бурханлаг бус) хүн гэж тодорхойлсон байдаг. Тэрээр сүнсний болон гэр бүлийн тухай

зүйлсийг сонирходоггүй байсан. Бурхан “**Би Иаковыг хайрласан, харин Есавыг үзэн ядсан**” гэж хэлэхдээ үүнийг мэдэж байсан. Хөвгүүдийг төрөхөөс өмнө Бурхан Ребекад том нь багадаа үйлчлэх болно хэмээн айлдаж байсан.

Хэдийгээр Иаков ууган хүүгийн эрхийг олж авахдаа буруу арга зам хэрэглэсэн ч гэлээ тэрээр түүнийгээ үнэлснийг бид харсан. Тэрээр Бурханы хүсэл, Бурханы зорилго, Бурханы амлалтууд, Бурханы оршихуй, Бурханы гэр бүл, Бурханы ивээл, Бурханы үг, Бурханы замууд болон Бурханы мэргэн ухааныг үнэлсэн. Харин Есавын бурхан нь түүний гэдэс байсан юм.

**“Миний та нарт үргэлж ярьж байсан олон хүмүүс Христийн загалмайн дайснууд мэт явдаг гэж би одоо уйлан байж хэлж байна. Тэдний төгсгөл бол сүйрэл. Тэдний бурхан бол ходоод бөгөөд тэд гутамшигт зүйлсээр сайрхдаг. Тэд дэлхийн юмыг л бодож сэтгэдэг”** (Филиппой 3:18-19).

Таны хувьд Бурханы зүйлсээс илүү чухалд үзсэн дэлхийлэг зүйл танд бий юу? Та Бурханы нүүр царайг хайдаг уу? Та Түүний хүслийг эрэлхийлж, Түүний амлалтыг хүсэж тэмүүлдэг үү?

## **ТҮҮХ 24. ИАКОВ ААВЫГАА МЭХЛЭВ**

Эхлэл 27:1-23, 30-36а, 38, 41-43

Исаак хөгширч, хараа нь муудан харж чадахаа больсон үедээ уутан хүү Есаваа “Хүү минь!” гэж дуудсанд хүү нь “Би энд байна” гэхэд Исаак “Би хөгширч, үхэх өдрөө мэдэхгүй байна. Тийм болохоор чи одоо зэвсэг, нум саалгаа авч, хээр талд гараад, миний төлөө ан хийж, миний дуртай амтат хоолыг хийж, надад авчирч идүүлэн, үхэхээс минь өмнө өөрийгөө ерөөлгө” гэв. Исаакийг хүү Есавдаа үг хэлж байхад нь Ребека түүнийг нь сонсож байжээ. Есав ан хийхээр хээр тал уруу одов. Ребека өөрийн хүү Иаковд “Чиний ах Есавд аавын чинь хэлсэн

үгийг би сонслоо. Надад ангийн мах авчирч амттай хоол хийж, надад идүүлэн, үхэхээс минь урд ЭЗЭШий өмнө өөрийгөө ерөөлгө” гэж байна. Тиймээс хүү минь, одоо миний чамд тушааж хэлэх үгийг сонс! Чи мал дээрээ очоод хоёр сайн ишиг надад авчирвал би түүгээр аавын чинь дуртай сайхан хоолыг хийж өгье. Чи түүнийг аавлаа өгч идүүлэн, үхэхийнх нь өмнө түүгээр ерөөлгө” гэв. Иаков эх Ребекадаа “Миний ах Есав бол үсэрхэг хүн, би гөлгөр арьстай хүн. Аав минь намайг тэмтэрч үзвэл би түүний нүдэнд мэхлэгч гэж үзэгдэн, ерөөгдөх нь байтугай хараагдах



болно” гэв. Эх нь түүнд “Хүү минь, чамд ирэх чиний хараалыг надад оноог. Харин чи зөвхөн миний үгэнд орж, яваад ишигнүүдийг авчирч өг” гэсэнд, Тэр одож, түүнийг авч, ээжлээ авчирч өгөв. Тэгээд ээж нь эцгийнх нь дуртай сайхан хоолыг хийжээ. Ребека гэртээ байсан ууган хүү Есавынхаа хамгийн сайхан хувцсыг нь авч, бага хүү Иаковдаа өмсгөж, ишигний арьсаар гар болон хүзүүний нь гөлгөр хэсгийг ороожээ. Өөрийн хийсэн амтат хоол, талхыг хүү Иаковд өгөв. Иаков эцэг дээрээ очиж, “Аав минь ээ!” гэж дуудсанд аав нь “Би энд байна. Хүү минь чи хэн бэ?” гэж хэлэхэд Иаков эцэгтээ хандан “Би таны ууган хүү Есав байна. Би таны надад хэлсэн ёсоор хийлээ. Та өндийж суугаад, миний агнасан ангийн махнаас зооглож, зүрх сэтгэлээсээ намайг ерөөж өгнө үү?” гэсэнд Исаак өөрийн хүүдээ “Хүү минь чи яасан хурдан агнасан юм бэ?” гэхэд тэр “Учир нь таны Бурхан ЭЗЭН түүнийг надтай саадгүй учруулсан юм” гэж хармулав. Исаак Иаковд хандаж “Хүү минь, наашаа

ойртож ир! Үнэхээр чи миний ууган хүү Есав мөн үү, биш үү гэдгийг чинь би тэмтэрч үзье” гэжээ. Иаков эцэг Исаактай ойртон очиход Исаак түүнийг тэмтэрч “Дуу чинь Иаковын дуу атал, гар чинь Есавын гар байна” гээд түүний гар ах Есавынх шиг байсан учир түүнийг ялгаж таньсангүй ерөөжээ.

Исаак Иаковыг ивээн адислаж дуусмагц, Иаков эцэг Исаакийн өмнөөс босоод гарч явсны дараа, түүний ах Есав ангаасаа буцаж ирээд, амтат хоол хийж, түүнийгээ эцэгтээ аваачаад, “Эцэг минь ээ, өндийж суугаад, хүүгийнхээ агнасан ангийн махнаас идэж, зүрх сэтгэлээрээ ерөөн адислана уу?” гэжээ. Эцэг Исаак нь “Чи хэн бэ?” гэж түүнээс асуухад “Би таны хүү, таны ууган хүү Есав байна” гэжээ. Исаак ихэд почирдон “Тэгвэл надад ангийн мах авчирч өгсөн тэр хүн хэн бэ? Би чамайг ирэхээс өмнө бүгдийг нь идээд, түүнийг ерөөсөн билээ. Тэр л гарцаагүй ерөөгдөх болно” гэв. Есав эцгийнхээ үгийг сонсоод, бархиран уйлж, эцэгтээ “Эцэг минь, намайг ерөөн адислаач! Намайг ч бас тэгээч!” гэсэнд Исаак “Чиний дүү залилан ирж, чиний ерөөлийг авчихжээ” гэж хэлсэнд Есав “Түүнийг Иаков гэж нэрлэдэг нь оносон бус уу? Түүний намайг мэхэлсэн нь хоёр дахь удаагаа боллоо. Тэрээр ууган хүү байх миний эрхийг авчихаад, одоо бас надад оногдох ерөөлийг авчихлаа” гэж хэлэв.

Есав эцэгтээ хандаж “Эцэг минь

ээ! Танд ганцхан л ерөөл адис байдаг юм уу? Эцэг минь ээ, намайг ерөөн адислаач. Намайг ч бас тэгээч!” гэж хэлээд чангаар уйлав.

Эцэг нь Иаковыг ерөөсөн тэр ерөөлөөс болж, Есав Иаковыг үзэн ядаж, өөрөө өөртөө “Эцгийнхээ төлөө эмгэнэх өдөр ойрхон байгаа учир би дүү Иаковаа ална” гэж

хэлжээ. Ууган хүү Есавын нь энэ үг Ребекад хүрэхэд бага хүү Иаковдаа хэл явуулж, дуудан ирүүлээд, “Есав ах чинь чамайг ална” гэж төлөвлөн өөрийгөө тайтгаруулж байна. Тийм учраас одоо хүү минь, чи миний үгийг даган босож, Харанд байгаа миний ах Лабан уруу зугтан оч” гэв.

## **Бурханы Ажлыг Бурханы Арга Замаар Хийх нь**

Бурхан Ребекад Өөрийнхөө ивээлийг Есав дээр биш, Иаков дээр буулгах гэж байгаагаа айлдсан ажээ. Учир нь Исаак үхэх өдөр нь ирэх үед түүний бодол санаа Бурханы хүслээс илүү ходоодондоо захирагдаж байв. Хэдийгээр муу нь хэзээ ч зөв биш боловч үүнээс сайн зүйл гарах нь бий. (Ром 3:8). Ребека, Иаков хоёрын мэхлэлт гэр бүлийг хагаруулсан бөгөөд Ребека хамгийн их хайрладаг хүүгээ дахиж хараагүй билээ.

Нөхрүүд нь Бурханы хүсэлд дуулгаваргүй байвал эхнэрүүд юу хийх хэрэгтэй вэ? **“Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд үггүйгээр, эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана. Тэд та нарын журамт байдал болоод эелдэг зан байдлыг чинь ажиглана шүү дээ”** (1Петер 3:1-2). Ребекагийн үйлдэл нь Бурхан амлалтаа биелүүлнэ гэдэгт төдий л итгэлтэй байгаагүйг харуулж байна. Харин бид Бурханы амлалтыг өөрсдийн арга замаар гүйцэлдүүлэхийг оролдож, Түүний гэр бүлийн амьдралд зөрчил бий болгодог уу? Бурхан биднээс Өөрийг нь тэвчээртэй хүлээгээсэй гэж хүсдэг.

Исаак Бурханаас эхнэрт нь түүний хэвлийд байгаа хөвгүүдийнх нь талаар хэлж байсан зүйлсийг хүндэтгээгүй юм (23). **“Нөхрүүд ээ, эхнэр чинь эмэгтэй хүн тул түүнийг өөрөөсөө сул дорой сав мэт үзэн та нар ч мөн адил эхнэртэйгээ ойлголцож амьдар. Амийн нигүүлслийн**

хамтран өвлөгчийнх нь хувьд түүнийг хүндэтгэ. Ингэвэл та нарын залбиралд саад тотгор учрахгүй” (1Петр 3:7). Хэдийгээр эмэгтэйчүүд бие махбодын болон сэтгэл санааны хувьд эрчүүдээс сул дорой боловч хоёулаа Бурханы нигүүлслийн хамтран өв залгамжлагчид юм. Эхнэр нөхөр хоёр нэгдэхгүй байх үед залбиралд саад бий болдог.

Бурханы ивээл орж ирэх үүд хаалга нь гэмшил юм. Гэвч Есав гэмшихийг хүсээгүй. Харин ч тэрээр аль хэдийнэ ууган хүүгийн эрхээ худалдаж, шүтлэггүй эхнэрүүдтэй болжээ. Энэ нь түүнийг Бурханы зорилгыг сонирхдоггүй байсныг харуулж байна. Тэр эцгийнхээ ивээлийг алдсаны дараа түүний зүрх сэтгэл дэх өшөө хорсол нь дүүгээ алах хүртлээ өсөж томорчээ. “Тэр дараа нь ерөөлийг өвлөхийг хүссэн боловч гологдсон билээ. Учир нь тэр нулимс унаган ерөөлийг хайсан хэдий ч гэмшлийн төлөөх зайг олоогүй гэдгийг та нар мэднэ” (Еврей 12:17). Тэр нулимс унаган байж ивээлийг хайсан боловч зүрх сэтгэлдээ ивээлийг алдах болсондоо гэмших бодол түүнд орж ирсэнгүй.”Бурханы хүслийн дагуух гашуудал нь үл харамсах гэмшлийг бий болгон авралд хүргэдэг ажээ” (2Коринт 7:10).

## ТҮҮХ 25. ИАКОВ БЕТЕЛД ЗҮҮД ЗҮҮДЛЭВ

Эхлэл 28:10-19а

Иаков Беершебагаас гараад, Харан уруу явав. Тэгэхэд нар шилгэсэн байсан учраас тэрээр нэгэн газар ирж, тэндээ хонохоор тэнлхийн нэг чулууг авч, толгой дороо тавиад унтжээ. Зүүдэндээ үзвэл, газар дээр нэгэн шат босож, түүний орой нь тэнгэрт тулан, бас дахин харвал, түүгээр Бурханы тэнгэр элч нар өгсөн уруудан байлаа. Үзгэл, ЭЗЭН түүний дээр зогсоод, “Би бол ЭЗЭН, чиний эцэг Абрахамын Бурхан, Исаакийн Бурхан байна. Чиний хэвтэж байгаа



газрыг Би чамд болон чиний үр удамд өгнө. Чиний үр удам газрын шороо шиг болж, баруун, зүүн, урд, хойд зүгт тархан, дэлхийн бүх үндэстэн чамаас болон чиний үр хүүхдээс ерөөл хүртэх болно. Би чамтай хамт байж, хаана ч явсан чамайг хамгаалан, чамайг дагуулж, энэ нутаг уруу буцааж авчирна. Би чамд амалсан зүйлээ биелүүлэх хүртэл чамайг орхихгүй”

гэж айлджээ. Иаков зүүднээсээ сэрээд, “ЭЗЭН үнэхээр энд байна, харин би мэдсэнгүй” гэв. Тэрээр айгаад, “Энэ яасан сүрдмээр газар вэ? “ Энэ бол гарцаагүй Бурханы өргөө, энэ бол тэнгэрийн хаалга байна” гэж өгүүлэв. Тэгээд Иаков өглөө эрт босож, дэрлэсэн чулуугаа авч багана болгон босгоод, дээр нь тос асган, тэр газраа Бетел хэмээн нэрлэжээ.

## Есүс Бол Мөнхийн Улсад Хүрэх Зам

Энэ зүүд нутгаасаа зугтаж, алс хол яваа залуу хүүгийн хувьд ямар их тайвшрал болсон бол оо! Хэдийгээр Иаков гэмтэй байсан боловч Бурхан түүн дээр ирж Өөр уруу нь ирэх зам түүнд нээлттэй байна гэдгийг харуулжээ. Тэрээр Абрахамтай байгуулсан гэрээгээ түүнд сануулж, хаа явсан газар нь түүнтэй хамт байх болно хэмээн амлажээ. Бид ч гэсэн өнөөдөр Есүсээр дамжин Бурхан дээр очих бүрэн боломжтой гэдгээ мэднэ. “Есүс “Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” гэлээ. (Иохан 14:6).

Есүс нэгэн удаа Иаковын зүүдэнд үзэгдсэн шатаар Өөрийгөө дүрсэлсэн байдаг. “Тэр “Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Тэнгэр нээгдэн, Бурханы тэнгэр элч нар Хүний Хүүгийн дээр өгсөх ба уруудахыг та нар үзэх болно” гэж айлдав” (Иохан 1:51). Тэнгэр элч нар сүнснүүдэд үйлчилдэг. (Еврей 1:14). Түүнчлэн Есүс Өөрийн сүнсээрээ бидэнтэй хамт байна гэж амласан. “Харагтун, үеийн төгсгөл хүртэл Би та нартай үргэлж хамт байх болно” (Матай 28:20.6).

Иаков Бурханы оршихуйд шинэ ухаарлыг олон сэрэв. Тэр даруй тэрээр Бурханд зориулан тахилын ширээ босгов. Энэ нь магтаалыг илэрхийлж байгаа юм. Тэгээд өөрийнхөө байгаа газрыг “Бурханы өргөө” буюу Бетел хэмээн нэрлэжээ. Бид ч гэсэн Христээр дамжин Бурхан дээр ирэх үед Түүний оршихуйд ухаарлыг олж, Түүний амлалт, амар тайван дотор сэрдэг. “Иймд ах дүү нар аа, бид Есүсийн цусаар бузар мөс чанараасаа цэвэрлэгдэхийн тулд өөрсдийн зүрхэндээ цацуулж, биеэ ариун усаар угаалган, үнэн зүрхээрээ ойртон очигцооё” (Еврей 10:19,22).

## ТҮҮХ 26. ИАКОВ РАХЕЛЫН ТӨЛӨӨ ЗАРЦЛАГДАВ

Эхлэл 29:1-2, 10-13, 16-20

Иаков цааш хөдлөн, дорнын хүмүүсийн нутагт хүрчээ. Тэрээр харвал, талд нэгэн худаг байх ба дэргэд нь гурван хэсэг хонин сүрэг хэвтэж байв. Учир нь хоньчид тэр худгаас хонио усалдаг ажээ. Худгийнхаа амыг чулуугаар дарсан байлаа.

Иаков нагац ах Лабаны охин Рахел болон нагац ах Лабаны хонийг хараад ойртон очиж, худгийн амнаас чулууг өнхрүүлэн зайлуулж, нагац ах Лабаны хонин сүргийг услав. Тэгээд Иаков Рахелийг үнсээд, чанга дуугаар уйлан, Рахелд өөрийгөө эцгийнх нь

дүү Ребекагийн хүү гэдгээ хэлсэнд тэрээр гүйн явж, эцэгтээ хэлэв. Лабан охин дүүгийнхээ хүү Иаковын тухай сонсоод, түүнтэй уулзахаар гүйн очиж тэврэн үнсээд, гэртээ дагуулан оров. Иаков өөрийнхөө тухай бүгдийг Лабанд ярьж өгчээ.

Лабан хоёр охинтой бөгөөд томынх нь нэр Леа, багынх нь нэр Рахел болой. Леа хараа муутай, харин Рахел нь үзэсгэлэнтэй гоолиг ажээ. Иаков Рахелд дурласан тул “Би тапы бага охин Рахелын төлөө долоон жил танд зарцлагдъя гэсэнд Лабан “Түүнийг өөр хүнд өгснөөс чамд өгсөн нь дээр. Налтай хамт бай” гэжээ.

### Есүс Зарц Болон Ирсэн

“Учир нь Хүний Хүү хүртэл үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд, мөн Өөрийн амийг олны төлөө золиос болгон өгөхийн тулд ирсэн юм” гэж айлдлаа (Марк 10:45). Хэдийгээр Бурханы Хүү Есүс сүйт бүсгүйгээ олж авахын тулд ирсэн ч гэлээ Тэр бидний төлөө зарц болон ирсэн юм. Есүс загалмайд цовдлогдохын өмнөх сүүлчийн орой Өөрийн дагалдагч нартайгаа хооллож байгаад тэдний хөлийг угааж тэдэнд үйлчилснээрээ Өөрийгөө зарц болон ирсэн гэдгээ тэдэнд харуулав. “Тэгвэл Би Эзэн , Багш байтлаа та нарын хөлийг угаасан бол та нар мөн нэг нэгнийхээ хөлийг угаах ёстой” (Иохан 13:14). Иаковын зарцпагдсан жилүүдээс тэрээр Рахелд ямар их хайртай байсан нь харагддаг. Тиймд бидний бусдын төлөөх үйлчлэлээс Бурхан тэдэнд ямар их хайртай нь харагдах болно.

Иаковын хувьд Рахелийн төлөө үйлчилсэн он жилүүд нь түүнд юу ч биш байлаа. Үүнтэй адил Есүс урдаа харагдаж байгаа баяр баясгалангийн төлөө эцсээ хүртэл тэвчихийг хүсэж байсан юм. “Итгэлийн Зохиогч бөгөөд бүрэн дүүрэн Төгсгөгч болох Есүс уруу хараагаа чиглүүлье. Тэр Өөрийнх нь өмнө тавигдсан

баяр баясгалангийн төлөө гутамшгийг эс тоомсорлон, загалмайг тэвчсэн бөгөөд Бурханы сэнтийний баруун гарт заларсан юм” (Еврей 12:2). Бидний хувьд ч гэсэн бусдыг Бурханы араас дагуулахын тулд хэцүү бөгөөд урт удаан үйлчлэлтэй учирч болох юм.

## ТҮҮХ 27. ЛАБАН ИАКОВЫГ МЭХЛЭВ

Эхлэл 29:21-30

Иаков Лабанд “Миний хугацаа дууссан учир эхнэрийг минь надад өгөөч. Би түүн дээр орё” гэжээ. Лабан тэр нутгийн бүх хүмүүсийг цуглуулан найр хийв. Үдэш нь Лабан охин Леагаа Иаковд авчирсанд, Иаков түүн дээр оржээ. Лабан өөрийн зарц бүсгүй Зиллаг охин Леадаа шивэгчин болгон өгчээ. Иаков өглөө нь харсан чинь тэр нь Леа байв. Тэгээд тэрээр Лабанд “Та надад яагаад ингэсэн бэ? Би Рахелын төлөө танд зарцлагдсан биш үү? Та намайг юунд мэхэлсэн бэ?” гэхэд Лабан

“Манай нутагт эгчээс нь түрүүлж дүүг нь урьдаар өгөх ёс байхгүй. Үүний төлөө долоо хоногийг гүйцээ. Тэгээд бид Рахелийг нь ч өгнө. Чи түүний төлөө дахин долоон жил зарцлагдах болно” гэжээ. Тэгээд Иаков хэлсэн ёсоор нь хийжээ. Иаков тэр долоо хоногийг гүйцээсэнд, Лабан түүнд өөрийн охин Рахелыг ч бас эхнэр болгон өгчээ. Лабан өөрийн зарц бүсгүй Билхаг охин Рахелдаа шивэгчинээр өгчээ. Иаков бас Рахел дээр орж, түүнийг Леагаас илүү хайрлан, дахин долоон жил Лабанд зарцлагджээ.

### Бид Юу Тарьснаа л Хураадаг

“Бүү мэхлэгд, Бурхан элэг доог болохгүй. Юу гэвэл хүн юу тарьснаа л хурааж авдаг (Галат 6:7). Иаков Есавын ууган хүүгийн эрхийг худалдаж авах хэцүү нөхцлийг тавьж байсан бол одоо Лабан өөрийн охиноо түүнд эхнэр болгон өгөхийн тулд хэцүү нөхцлийг тавьж байна. Иаков үхэх гэж буй эцгээ мэхэлсэн бол одоо Лабан Иаковыг мэхэллээ. Ямар гашуудалтай юм бэ! “Миний харсны дагуу гэм бурууг хагалж, зовлон зүдгүүрийг таригчид түүнийгээ хурааж авдаг” (Иов 4:8). Хэрвээ бид буурцаг, будаа, улаан буудай тариалах юм бол буурцаг, будаа, улаан буудай л хурааж авах болно. Үүнтэй адилхан бид мэхлэлт, маргаан, харгислалыг тарих юм бол хариуд нь мэхлэлт, маргаан, харгислалыг амсах болно. “Илд агсагч бүхэн илдээр хөнөөгдөнө” (Матай 26:52.6). Тэгвэл сайхан сэтгэл, үнэн, амар

тайвныг тарих нь хир сайн бэ? “Зөв шударгыг тариалж, энэрэнгүйгээр хурааж ав. Боловсруулаагүй газраа хагал. Учир нь ЭЗЭН чиний дээр зөв шударгыг асгахаар ирэх хүртэл Түүнийг хайх цаг нь одоо билээ” (Хосеа 10:12). Тиймээ, Бурхан Иаковын амьдрал дахь хэрэггүй, хатуу хөрсийг нь хагалахын тулд түүнд учирсан нөхцөл байдлыг нь ашигласан юм. Бурхан үргэлжлүүлэн хийх гэж байсан зүйлээ Бетелд эхлүүлжээ. “Та нарын дотор сайн үйлийг эхлүүлсэн Тэрээр үүнийгээ Христ Есүсийн өдрийг хүртэл төгс төгөлдөр болгоно гэдэгт би бат итгэж байна” (Филиппой 1:6).

## ТҮҮХ 28. БУРХАН ЛЕАГ ИВЭЭВ

Эхлэл 29:31-35

ЭЗЭН Леагийн нөхрөөсөө хайр хишиг хүртээгүйг үзээд, Леагийн умайг нээв. Харин Рахел нь үргүй байжээ. Леа жирэмсэлж, хүү төрүүлээд, түүнийгээ Реубен гэж нэрлэжээ. Тэгээд тэрээр “ЭЗЭН миний зовлонг харсан учир одоо миний нөхөр намайг хайрлах болно”

гэжээ. Тэр бас дахин жирэмсэлж, хүү төрүүлээд, “ЭЗЭН миний хайр хишиг хүртээгүйг сонсоод, энэ хүүг надад бас өглөө” гээд түүнийгээ Симеон гэж нэрлэжээ. Тэр бас жирэмсэлж, дахин хүү төрүүлээд “Энэ удаа би ЭЗЭНийг магтана” гээд түүнийгээ Иуда гэжээ. Тэгээд түүний хүүхэд төрүүлэх нь зогсжээ.

### Бурхан Хайрлагдаагүй Нэгнийг Хайрладаг

Та үл хайрлуулахыг болон гологдлыг мэдэрч байна уу? Тэгвэл зүрхээ хамгаал! Есүс гологдол гэж юу болохыг ойлгодог бөгөөд Бурхан доромжлогдсон хүнийг үнэхээр өрөвддөг. “Бүү айгтун. Учир нь чи ичгүүрт унахгүй. Бүү ичингүйр. Учир нь чи гутамшиг болохгүй. Харин чи залуу насныхаа ичгүүрийг мартаж, бэлэвсрэлийнхээ доромжлолыг цаашид дурсахгүй. Учир нь чиний нөхөр бол чамайг Бүтээгч. Түүний нэр нь түмэн цэргийн ЭЗЭН. ЭЗЭН чамайг сэтгэлээр унасан, хаягдсан эхнэр мэт, залуу үедээ гэрлэсэн боловч гологдсон эхнэр мэт дуудсан” гэж чиний Бурхан айлдаж байна” (Исаиа 54:4-6).

“Миний эцэг, эх намайг орхисон, харин ЭЗЭН намайг босгоно” (Дуулал 27:10). “Байгаа юмандаа сэтгэл хангалуун байж, амьдрал чинь мөнгийг хайрлахаас чөлөөтэй байг. Учир нь



Тэр Өөрөө “Би чамайг хэзээ ч мартаггүй” гэж айлдсан. Тиймд бид зоригтойгоор “Эзэн миний туслагч мөн. Би айхгүй. Хүн намайг яах юм бэ?” гэдэг. (Еврей 13:5-6).

Бид Леагийн хүүхдүүддээ өгсөн нэрнүүдээс нь түүний нөхөртэйгөө байх гэсэн хэрэгцээ нь Бурханыг магтах гэсэн магтаал уруу өөрчлөгдөж байгааг харж чадна. Леа Реубенийг төрүүлснийхээ дараа одоо л нөхөр нь өөрийг нь гарцаагүй хайрлана гэсэн мэдрэмж түүнд төржээ. “Реубен” гэдэг нэр нь “Хүүгээ хараач” гэсэн утгатай ажээ. Дараа нь Симеоныг төрөх үед тэрээр Бурхан залбирлыг нь сонссон юм байна гэдгийг ухаарав. “Симеон” нь “Сонссон” гэсэн утгатай нэр юм. Дараа нь тэрээр Левиг төрүүлэх үедээ нөхөртэйгөө Бурханаар холбогдож болох юм байна гэсэн итгэл түүнд төржээ. “Леви” гэдэг нэр нь “Холбогдсон” гэсэн утгатай нэр ажээ. Гэвч тэрээр дөрөв дэх хүүгээ гаргаснаар түүний Бурханд итгэх итгэл нь шинэ түвшинд хүрчээ. Тэрээр дөрөв дэх хүүгээ “Магтаал” гэсэн утга бүхий “Иуда” гэсэн нэрээр нэрлэжээ.

Хэдийгээр Леа эхлээд гашуун нөхцөл байдалтай тулгарсан ч гэлээ Бурхан түүнийг ерөөсөн юм. Бурхан түүнд Иаковын анхны хүү Реубенийг төрүүлэхийг зөвшөөрсөн нь агуу том хүндэтгэл байлаа. Харин Левигээс Изриаль үндэстний тахилчийн овог гарч иржээ. Тэд Бурханд үйлчлэхдээ маш их хүндэтгэлтэй ханддаг байв. Иудагаар дам жуулан Хаадын Хаан Месиа болох Есүс гарах хаадын залгамж эхлэв. Бурхан ийнхүү гологдсон Леаг хайрласан нь ямар агуу хүндэтгэл вэ! Леаг нас барсны дараа түүнийг Абрахам Сара, Исаак Ребека нарын болон өөрийнх нь нөхөр Иаковын дэргэд хүндэтгэлтэйгээр оршуулжээ. “Учир нь цаг зуурын ялихгүй зовлон нь бидэнд мөнх алдрыг үлэмж арвинаар бий болгож байна” Бид үзэгдэх юмсыг бус, харин үл үзэгдэх юмсыг хардаг. Учир нь үзэгдэх юмс бол түр зуурынх, харин үл үзэгдэх юмс бол мөнх билээ” (2Коринт 4:17-18).

Хэрэв Бурхан зүрхний чинь хүслийг хэсэг хугацаанд далд байгаасай гэж хүсэж байвал, Түүнээс танд өгөгдөх мөнхийн

хангалтынх нь төлөө та баяр хөөртэй байгтун. “ЭЗЭнд баярлагтун. Тэр чамд зүрхний чинь хүслийг өгнө” (Дуулал 37:4).

## ТҮҮХ 29. ИАКОВЫН ГЭР БҮЛ ДЭХ АТААРХАЛ



Эхлэл 30:1-24

Рахел өөрөө Иаковд хүү төрүүлж чадаагүйгээ хараад, эгчдээ атаархаж, Иаковд “Надаар хүү төрүүд. Хэрэв тэгэхгүй бол би үхнэ” гэжээ. Иаков Рахелд уурлан “Умайг чинь хаасан Бурханыг би орлох гэж үү?” гэсэнд Рахел “Энд миний шивэгчин Билха байна. Түүнгэй унт! Тэр миний өвөр дээр хүү тавих болно. Тэгвэл түүгээр дамжуулж, би хүүхэдтэй болно” гээд өөрийн шивэгчин Билхаг түүнд татвар эм болгон өгчээ. Иаков түүний өвөрт оржээ. Билха жирэмсэлж, Иаковд хүү төрүүлж өгөв. Рахел “Бурхан намайг өмгөөлж, миний дууг сонсоод, надад хүү хайрлалаа” гээд, түүнийг Дан гэж нэрлэжээ. Рахелын шивэгчин Билха дахин жирэмсэлж, Иаковд хоёр дахь хүүгээ төрүүлж өгөв. Рахел “Би

эгчтэйгээ ширүүн өрсөлдөж дийллээ” гээд түүнд Нафтали гэж нэр өгчээ. Леа өөрийн хүүхэд төрүүлэхээ зогссоныг хараад, өөрийн шивэгчин Зилпаг аваад, Иаковд татвар эм болгон өгчээ. Леагийн шивэгчин Зилпа Иаковд хүү төрүүлж өгөв. Леа “ямар азтай вэ” гээд, түүнийг Гад гэж нэрлэжээ. Леагийн шивэгчин Зилпа Иаковд хоёр дахь хүүгээ төрүүлж өгчээ, Леа “Би баяр хөөртэй байна. Эмэгтэйчүүд намайг аз жаргалтай гэж дуудах болно” гээд түүнийг Ашер гэж нэрлэжээ. Улаан буудай хураах үеэр Реубен галагш гарч, талбайгаас мандарваа цэцэг олоод, ээж Леалаа авчирч өгчээ. Рахел Леад халдан “Хүүгийнхээ олсон мандарваа цэцгээсээ налад өгөөч?” гэжээ. Леа түүнд “Миний нөхрийг авсан чинь багадаа юу? Чи бас миний хөвгүүний мандарваа цэцгийг авах нь уу?” гэв. Рахел “Тэгвэл таны хүүгийн мандарваа цэцгийн оронд өнөө шөнө миний нөхөр тантай хамт унтаж болно” гэв. Иаковыг талбайгаасаа үдэш эргэж ирэхэд, Леа түүнтэй уулзахаар гараад, түүнд “Хөвгүүнийхээ мандарваа цэцгээр би таныг худалдаж авсан учир өнөө шөнө миний өвөрт орох ёстой” гэв. Тэгээд тэр шөнө Иаков түүнтэй унтжээ. Бурхан Леаг сонссон учир Леа жирэмсэлж, тав дахь хүүгээ Иаковд төрүүлж өгөв. Леа “Би шивэгчнээ нөхөртөө өгсөн тул Бурхан

хөлсийг нь надад өглөө” гээд түүний нэрийг Иссахар гэжээ. Леа дахин жирэмсэлж, зургаа дахь хүүгээ Иаковд төрүүлж өгөв. Леа “Бурхан надад сайхан бэлэг өглөө. Би нөхөртөө зургаан хүү төрүүлж өгсөн учир тэрээр надтай хамт амьдрах болно” гээд түүнийг Зебулун гэж нэрлэжээ. Дараа нь тэрээр охин

төрүүлээд, түүнийг Дина гэж нэрлэв. Бурхан Рахелыг дурсан санаж, түүнийг сонсоод, умайг нь нээж өгчээ. Тэгээд тэрээр жирэмсэлж, хүү төрүүлээд “Бурхан миний ичгүүрийг арилгаж өглөө” гэж хэлээд, хүүгээ Иосеф гэж нэрлээд “ЭЗЭН надад бас нэг хүү нэмж өгөх болтугай!” гэжээ.

## **Бурхан Өөрийн Хөвгүүдээ Сахилгажуулдаг**

**“Учир нь салхийг тарьдаг тэд хуй салхийг хурааж авдаг”** (Хосеа 8:7а). Энэ ишлэл Иаковын амьдралыг хэрхэн дүрслэх вэ! Түүний үйлс нь түүний эцэг эхийнх нь хоорондын болон тэр өөрөө ахтайгаа зөрчилдсөнөөс үүдэлтэй. Гэвч одоо тэр зөрчил нь өөрийнх нь гэр бүл дээр түүний эхнэрүүд болон хүүхдүүдийнх нь хооронд улам томоор үүсчээ.

Харин Бурхан Исаактай хүүтэйгээ харилцаж байгаа юм шиг л харилцаж байсан.

**“Учир нь ЭЗЭН хайрладаг хүнээ сахилгажуулдаг юм. Тэр хүлээн авдаг хүү болгоноо ташуурддаг. Та нарын тэвчдэг чинь сахилга баттай болохын төлөө юм. Бурхан хөвгүүдтэйгээ харьцдаг шигээ та нартай тийнхүү харьцдаг. Учир нь эцэг нь сахилгажуулдаггүй хүү хаа байна?”** (Еврей 12:6-7).

Бид Эзэний сахилгажуулалтыг үзэн ядах юм уу эсвэл үүнээс болж сул дорой болох ёсгүй. Бид ямар болох хэрэгтэй байна, тийм болгохын тулд Бурхан бидэнд сахилгажуулалтыг хэрэглэдэг. **“Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдар уруу дуудсан, бүх нигүүлслийн Бурхан Өөрөө та нарыг түр зуур зовсны дараа та нарыг төгс болгож, бататгаж, бэхжүүлэн байгуулах болно”** (1Петер 5.10).

Иаков үүнээс илүү доош орно гэж байх уу даа? Түүний анхны эхнэр Леагаас гарсан ууган хүү нь ээждээ дахин үр тогтоогч

мандарваа цэцэг олж өгчээ. Гэвч удаах эхнэр Рахел нь тэрхүү мандарваа цэцгийг нь авахын тулд Леад Иаковтай хамт нэгэн шөнийг өнгөрүүлэхийг зөвшөөрчээ. Учир нь тэрээр Леаг хүүхэд гаргахаа больсон гэж бодсон ажээ. Энэ нь Иаковын хувьд ямар дорд болж байгаа хэрэг вэ! Бурхан хүмүүсийн өөрсдийнх нь арга чаргаас илүү дээр Өөрийнх нь эрх мэдэл байдаг гэдгийг нэгээс илүү баталж харуулсан. **“Хүн оюун ухаандаа өөрийн замыг төлөвлөдөг бол ЭЗЭН түүний алхаа гишгээг чиглүүлдэг”** (Сургаалт үгс 16:9). Леа дахин өөрөөс нь гарсан хүүгээ Бурханаас өгсөн шан (ивээл) гэж бодсон учраас түүнийг Иссахар гэж нэрлэжээ. Энэ нэр нь “Тэр шан өгдөг” гэсэн утгатай ажээ.

## Хийх Зүйлс

Гэр бүл дэх бүх атаархал дундаас Бурхан Өөрийн сонгосон Израиль үндэстний арван хоёр овгийн эцэг болох арван хоёр хөвгүүдийн гэр бүлийг босгож байжээ. Тэрээр энэ үндэстнээр дамжуулан газар дэлхийн бүх үндэстнийг ерөөхийн тулд Өөрийн Үг болон Өөрийн Хүүг илгээсэн юм.

Хоосон зайд Иаковын арван хоёр хөвгүүдийн нэрсийг бич. Түүх 28, 29 дээр гарсан Судрын хэсгийг ашигла. Харин арван хоёр дахь хүүгийн нэрийг танд тусламж болох үүднээс Түүх 34-өөс авч бичигдсэн болно.

### Нэрний Утга

Леагаас :

- |           |                          |
|-----------|--------------------------|
| (1) _____ | “Хүүг хараач” (Эх 29:32) |
| (2) _____ | “Сонссон” (29:33)        |
| (3) _____ | “Холбогдсон” (29:34)     |
| (4) _____ | “Магтаал” (29:35)        |

Рахелын шивэгчин Билхагаас:

- |           |               |
|-----------|---------------|
| (5) _____ | “Шүүх” (30:6) |
| (6) _____ | “Бөх” (30:8)  |

Леагийн шивэгчин Зилпагаас:

- (7) \_\_\_\_\_ “Бүлэг цэрэг” (30:10)  
(8) \_\_\_\_\_ “Баяр баясгалан” (30:13)

Леагаас (мандарваа цэцэг өгсний дараа):

- (9) \_\_\_\_\_ “Тэр хөлс өгдөг” (30:18)  
(10) \_\_\_\_\_ “Сууц” (30:20)

Рахелаас:

- (11) \_\_\_\_\_ “Нэмэхүй” (30:24)  
(12) Бенжамин “Миний баруун гарын  
Хөвгүүн” (35:18)

## ТҮҮХ 30. ИАКОВ ЛАБАНЫГ ОРХИЖ ЯВАВ

Эхлэл 31:2-7, 20-21, 25а, 26-29,  
44,55

Иаков Лабаны царайг хараад, тэрээр өөрт нь урьдынхтай адилгүй хандаж байгааг ажиглав. ЭЗЭН Иаковд “Чи өвөг дээдсийнхээ нутаг уруу, төрөл садан уруугаа буцаж яв. Би чамтай хамт байна” гэлээ. Иаков хэл явуулж, Рахел Леа хоёрыг сүргийнхээ бэлчээрт дуудуулж ирүүлээд тэдэнд өгүүлрүүн “Би эцгийн чинь хандлагыг харахад, тэр надад урьдынх шиг найрсаг биш байна. Харин миний эцгийн Бурхан надтай хамт байсан. Намайг эцэгт чинь хамаг хүчээрээ зүтгэснийг та нар мэднэ. Гэвч энэг чинь намайг мэхэлж, миний авах хөлсийг арван удаа өөрчилсөн билээ. Гэсэн хэдий ч надад муу юм хийхийг Бурхан түүнд зөвшөөрөөгүй.

Иаков сири хүн Лабанд оргон явахгаа хэлэлгүй, түүнийг мэхэлжээ.

Тэрээр хамаг хөрөнгөө аваад Евфрат мөрнийг гатлан зугтааж, Гилеадын уулархаг нутгийг зорив.

Лабан Иаковыг гүйцэж очоод “Чи надад мэдэгдэлгүйгээр охидыг минь илдээр барьж авсан олзлогдогсод шиг авч яван юу хийчих нь энэ вэ? Чи яагаад хэлэлгүй сэмхэн зугтаж, намайг мэхэлсэн юм бэ? Би чамайг баяр хөөр, ая дуу, ятгын эплгээр үдэх байсан байх. Чи ач, зээ охидыг минь надад үнсүүлсэнгүй. Чи мунхаг зүйл хийлээ. Чамайг дөнгөх чадал надад бий. Харин өнгөрсөн шөнө эцгийн чинь Бурхан надад “Болгоомжил, Иаковд сайн муу юу ч битгий хэл” гэсэн. Одоо нааш ир! Чи бид хоёулаа хоорондоо гэрээ байгуулья. Тэр бол чи бид хоёрын хоорондын гэрч болог гэв.

Лабан өглөө эртлэн босоод, ач зээ нараа, охидоо үнсэж ерөөгөөд, нутаг уруугаа эргэн оджээ.

## Ажилчдын Тухай Зарим Бодол

Иаков Рахелын төлөө долоон жил ажилласан боловч түүнд Леаг өгчээ. Хэдийгээр Лабан Рахелыг долоо хоногийн дараа түүнд өгсөн боловч Иаков дахин долоон жил ажиллах ёстой байлаа. Иосефыг төрөх үед Иаков арван дөрөв дэх жилдээ ажиллаад ажиллах хугацаагаа дуусгажээ. Тэрээр Канаан нутаг уруугаа буцахыг хүссэн боловч Лабан түүнийг Месопотамид үлдээч хэмээн хүсчээ. Учир нь тэрээр Иаковын улмаас Эзэн өөрийг нь ивээсэн гэдгийг мэдэж байлаа. Тийнхүү Иаков зөвшөөрөөд дахин зургаан жил тэднийд ажиллав. Энэ хугацаанд Иаков Лабаны өгснийг үржүүлэхийн тулд өөрийн арга ухаан, ур чадвараа ашигласан бөгөөд Бурхан түүний гарын бүх ажлыг нь ерөөжээ. Лабан Иаковд ямар нэгэн юм чинийх гэж хэлэх бүрд Бурхан Иаковын тухайн салбарыг нь маш ихээр цэцэглүүлж байсан тул Лабан бодлоо өөрчилж түүний ажлын хөлсийг нь өөрчлөх хэрэгтэй болж байлаа. Тэгэх тусам Иаков маш баян болжээ. Хэдийгээр Иаков Лабаны ажилчин байсан боловч тэрээр шударга байсан юм. **“Боолчууд аа, бүхий л хүндлэлээр зөвхөн сайн, дөлгөөн төдийгүй, бас шударга бус авирлагч эзэддээ ч захирагд (1Петр 2:18). “Боолууд аа, махан биеийнхээ эзнийг бүх талаар дагагтун. Хүнд таалагддаг хүмүүс шиг харцаар үйлчлэлгүй, харин Эзэнээс эмээн, чин сэтгэлээсээ үйлчил. Та нар юу ч хийсэн хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө мэт чин сэтгэлээсээ хийгтүн. Ингэхдээ та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авна гэдгээ мэдэн хийгтүн. Чи Эзэн Христэд үйлчилж байгаа юм” (Колоссой 3:22-24).**

Иаков Лабаны хандлага нэг л биш байсныг мэдэж байлаа. Иаков түүний шударга бус харьцаанд гашуудсангүй. Тэрээр Бурханы ивээлийн төлөө Түүнд алдрыг өргөж байв. **“Хэнээс ч хүчээр мөнгө бүү ав. Хэнийг ч хилсээр бүү гүтгэ. Авдаг хөлсөндөө сэтгэл хангалуун бай” (Лук 3:14.б). “Харин хэрэв та нар зөвийг үйлдээд зовоходоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы тааллыг олдог” (1Петер 2:20.б).** Бид ч гэсэн мөнхийн өмч хөрөнгөтэйгөө мэдэх тул эд хөрөнгийг минь булаан авахад

сайныг үйлдэн тэвчиж, тэр бүү хэл баяр хөөртэй байж чадна. (Еврей 13:24).

Иаковд Бурхан дахин үзэгдэж гэртээ харь хэмээжээ. Магадгүй айдсын улмаас Иаков шууд явчихаагүй байх. Гэвч Бурхан Иаковыг асуудлаас зугтахгүй байхыг хүсэж байсан учир Тэрээр хор учруулахгүйгээр түүнийг хавчихыг Лабанд зөвшөөрчээ. Ингэснээр тэд зохицож чадах байв. “Харин та нар бүү яарч гар, оргодол мэт бүү зугтагтун. Учир нь ЭЗЭН та нарын өмнө явна. Израилийн Бурхан та нарын ар талыг хамгаална” (Исаиа 52:12).

Бид Бурханыг дагаж байх үед Тэрээр биднийг ардаа ямар нэгэн дуусгаагүй ажил орхихыг хүсдэггүй.

## ТҮҮХ 31. ИАКОВ ЕСАВТАЙ УУЛЗАХААС АЙВ

Эхлэл 32:1-13, 20.6

Иаковыг аян замдаа явж байтал, Бурханы тэнгэр элч нар түүнтэй уулзав. Иаков тэднийг хармагцаа “Энэ бол Бурханы цэргийн хуаран байна” гээд, тэр газрыг Маханаим гэж нэрлэв. Иаков Сеирийн нутаг Едомын талд байгаа ах Есав уруугаа өөрөөсөө түрүүлж, элч нарыг илгээгээд, тэдэнд тушааж “Миний Эзэн Есавд ингэж хэл. “Таны зарц Иаков ингэж хэлүүллээ. “Би Лабантай хамт өнөөг хүртэл суулаа. Надад үхэр, илжиг, хонин сүрэг, эрэгтэй, эмэгтэй зарц нар байна” гэж хэл” гэв. Элч нар Иаковд буцаж ирээд, “Бид таны ах Есавд хүрч очлоо. Тэрээр тантай уулзахаар дөрвөн зуун хүнийг дагуулан ирж байна” гэжээ. Иаков ихэд айн, сэтгэлийн дарамтанд оров. Тэгээд хамт байсан хүмүүсээ болон хонь, үхэр, тэмээдээ хоёр хэсэг болгон

хуваав. Тэгээд Иаков “Хэрэв Есав ирээд, нэг хэсэг уруу нь дайрвал үлдсэн хэсэн нь зугтах болно” гэжээ. Иаков “Миний өвөг Абрахамын Бурхан, миний эцэг Исаакийн Бурхан, ЭЗЭН минь! Та надад “Чи төрсөн нутаг төрөл төрөгсөд уруугаа буц Би чамайг ерөөх болно” гэж надад хэлсэн. Би Танаас өчүүхэн зарц надад үзүүлсэн хайр ерөөл, үнэн шударга бүхнийг хүртэх зохисгүй. Би энэ Иордан голыг гандхан таягтайгаа гаталж очсон. Харин би одоо хоёр ч хэсэг сүрэгтэй болсон. Миний ах Есавын гараас намайг авраач гэж гуйн залбирч байна. Учир нь тэр хүрч ирээд, намайг болон эхнэр хүүхдүүдийг минь дайрна гэхээс би айж байна. Та “Би чамд хайр ерөөлөө хүртээж, үр хүүхдүүдийг чинь далайн тоо томшгүй элс мэт олон болгож өгнө” гэж хэлсэн биз дээ гэв. Иаков тэр шөнөдөө тэндээ хонож, ах

Есавдаа зориулан эд хөрөнгөөсөө бэлэг сонгожээ. Иаков “Би өөрийнхөө түүнд явуулж байгаа бэлгээрээ түүнийг тайтгаруулаад, дараа нь би өөрөө түүнтэй уулзвал ах минь намайг хүлээн авч магадгүй” гэв.



## Залбирал Амар тайвныг Авчирдаг

Та айсан үедээ залбирдаг уу аль эсвэл сандралд ордог уу? Иаков төрсөн нутгаа хараад Есав надаас одоо хүртэл өс авах гэж байгаа хэмээн ихэд айж байв. Харин Бурхан түүнд маш олон тэнгэр элчийг харуулжээ. “ЭЗЭНий тэнгэр элч Түүнээс эмээгчдийн эргэн тойронд байж, тэднийг авардаг” (Дуулал 34:7). Иаковд чөлөөлөлт хэрэгтэй байв! Есав 400 хүнтэй хамт түүн уруу ирж байв! “Юунд ч бүү санаа зов! Харин аливаа зүйлд залбирлаараа болон гуйлтаараа талархалтайгаар хүсэлтээ Бурханд мэдүүл. Бүх оюун ухаанаас дээгүүрх Бурханы амар тайван нь Христ Есүс дотор та нарын зүрх бодлыг тань хамгаална” (Филиппой 4:6-7).

Иаковын хэцүү цаг мөчтэй тулгарах үеийнх нь залбирлаас бидний залбиралд байх хэрэгтэй долоон зүйл:

1. Тэр Бурхантай хувьчлан ярилцсан. (9-р ишлэл). Бид Бурханыг хувьчлан мэдэх үедээ Түүнтэй найзууд шиг харилцаж чаддаг.

2. Тэр Бурханы хүслийг биелүүлж байгаагаа мэдэж байсан (9-р ишлэл). “Хэрэв бид Түүний хүслийн дагуу юуг ч гуйвал, Тэр биднийг сонсдог гэдэг нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм” (1Иохан 5:14).

3. Тэр өөрийгөө Бурханы өмнө даруу болгов (10-р ишлэл). Тэр Бурханд өөрийн гутамшигтай үйлсийг гэмшжээ. “Тэрээр даруу хүнийг аврах болно” (Иов 22:29.6). “ЭЗЭН эмтэрсэн зүрхтэй хүнд ойртон байдаг бөгөөд Сүнсээрээ гэмшигчдийг авардаг” (Дуулал 34:18).

4. Тэр Бурхан өөрийнх нь төлөө аль хэдийнэ хийчихсэн зүйлийг санасан (10-р ишлэл). Бурхан Өөрийн хүмүүсийн

магтаалд оршдог (Дуулал 22:3). “ЭЗЭНийг хийгээд Түүний хүч чадлыг эрэлхийлэгтүн. Түүний нүүр царайг үргэлж хайгтун. Түүний үйлдсэн гайхамшгуудыг нь санагтун” (Дуулал 105:4-5а). “Тиймээс сүнс минь миний дотор сульдсан билээ. Зүрх минь ч миний дотор зогсох шахсан юм. Би эртний өдрүүдийг санадаг. Би Таны үйлс бүхнийг тунгаадаг. Би Таны гарын үйлсийг нягтлан боддог. Өө, ЭЗЭН, намайг дайснуудаас минь авраач. Би Таны дотор хоргодно” (Дуулал 143:4-5, 9).

5. Түүний гуйлт нь тодорхой бөгөөд онцгой байсан (11-р ишлэл). “Гуй, тэгвэл та нарт өгнө” (Матай 7:7а).

6. Тэр өөрт буй мэдрэмжээ Бурханд яг байгаагаар нь илэрхийлэн гаргасан (11-р ишлэл). “Хүмүүс ээ, хэзээд Түүнд итгэ. Түүний өмнө зүрхээ нээ. Бурхан бидэнд хоргодох газар юм” (Дуулал 62:8).

7. Тэр Бурханы амлалтанд итгэсэн (12-р ишлэл). Бид өөрсдийн залбиралдаа Бурханы Үгийг бариад Түүний амлалтуудыг нэхэж болно. “Тэд итгэлээрээ ...амлалтуудад хүрчээ” (Еврей 11:33а).

Иаковыг залбирсны дараа Бурхан түүнд Есавыг тайвшруулахын тулд 580-н малыг бэлэг болгон түүнд барих төлөвлөгөөг өгчээ. “Тайвшруулах” гэсэн үгийн жинхэнэ утга нь “цагаатгал,” “бүрхэх,” “эвлэрүүлэл” зэрэг нь юм. Иаков өөрийнх нь бэлэг Есавд өөрийг нь уучлахад тус болж чадна хэмээн найджээ. “Магтуулах зохистой ЭЗЭНийг дуудаад, өөрийн дайснуудаас би аврагдсан” (Дуулал 18:3).

## ТҮҮХ 32. ИАКОВ БУРХАНТАЙ БАРИЛДАВ

Эхлэл 32:22-28; 33:1-4

Тэр шөнө босож, хоёр эхнэр, хоёр шивэгчин, арван нэгэн хүүхдээ дагуулан, Иаббок голын гарцаар гарчээ. Иаков тэднийг дагуулан гол гаргаад, дараа нь өөрт нь байсан болгоноо гаргажээ. Иаков ганцаараа



үлдсэн бөгөөд нэгэн хүн Иаковтай үүр цайтал барилдав. Тэрээр Иаковыг дийлж чадахгүйгээ үзээд, гуя уруу нь цохьсонд Иаковын гүнх нь тэр хүнтэй барилдаж байхад мулгарчээ. Тэр хүн “Үүр цайж байгаа учир намайг явуул” гэсэнд Иаков “Таны намайг ерөөхөөс нааш би таныг явуулахгүй” гэжээ. Тэгээд тэр хүн “Чиний цэр хэн бэ?” гэж асуусанд тэрээр “Иаков” гэж хэлжээ. Тэр хүн “Үүнээс хойш чамайг Иаков гэхгүй харин Израиль гэж нэрлэх болно. Учир нь чи Бурхантай, бас хүмүүстэй тэмцэлдэж ялсан билээ” гэв.

Иаковыг хараагаа өргөн харгал, Есав дөрвөн зуун хүнийг дагуулан яваа харагдлаа. Иймээс тэрээр хүүхдүүдээ Леа, Рахел болон хоёр шивэгчиндээ хувааж өгөөд, шивэгчид болон тэдний хүүхдүүднийг өмнө нь, Леаг хүүхдүүдтэй нь хамт дараа нь, Рахел Иосеф хоёрыг сүүлд нь оруулав. Харин Иаков өөрөө тэдний өмнө гарч, долоон удаа газарт мөргөөд, ах Есав уруугаа дөхөж очиход, Есав гүйж ирээд, түүнийг тэврэн хүзүүдэж үнсээд, хоёулаа уйладдав.

## Бурханы Нүүр Царайг Эрэхүй

“Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно” (Иеремиа 29:13). “Гуйдаг хүн бүр авна, эрж хайдаг хүн олно, тогшдог хүнд нээгдэнэ” (Матай 7:8).

Сүүлд нь Иаков өөрийнхөө арга ухаанаар нэг их удаан амьдарч чадахгүй учраас Бурханы ивээлийг өөртөө байлгах ёстой юм байна гэдгийг ойлгожээ. Бурхан түүний “далдуур үймүүлэгч” болон “шахан гаргагч” гэсэн утгатай *Иаков* нэрийг нь “Бурхантай хамт Хан хүү” гэсэн утгатай *Израиль* хэмээх нэрээр сольжээ. Яагаад гэвэл Иаков өөртөө найдахаа больж Бурханыг хайсан учраас Бурхан түүнийг ивээжээ. Бурханы цохилт Иаковыг догolon болгосон нь түүний энэ сул дорой байдал түүнийг өөрийнхөө хүч чадлаар бус зөвхөн Бурхан дотор хүчирхэгжихийг сануулахын тулд байлаа.

Элч Паул хүртэл махан биедээ өргөстэй байсан бөгөөд энэ нь түүний сул дорой байдал болж байлаа. Тэрээр үүнийг өөрөөс нь салгаач гэж Бурханаас гурвантаа гуйсан ажээ. “Бурхан надад “Миний нигүүлсэл чамд хангалттай. Учир нь мөхөс байдал дотор [Миний] хүч бүрэн төгс болно” гэж айлдсан. Иймд би ихэд баяртайгаар мөхөс байдлуудаараа сайрхана. Ингэх нь

Христийн хүч миний дотор оршихын тулд билээ... Учир нь би хэзээ мөхөс байна, тэр үед хүчтэй байдаг” (2Коринт 12:9-10).

## Эхлээд Эвлэрэх

Иаков өөрийн замаар Бетел уруугаа буцаж байхдаа Бурханыг үнэнээр магтаж, Түүнд үйлчлэхээсээ өмнө ахтайгаа эвлэрэх хэрэгтэй байлаа. “Иймээс, хэрэв чи тахилын ширээнд өргөл өргөх гэж байхдаа чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь байгааг санавал, өргөлөө тахилын ширээний өмнө орхиод замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь өргөлөө ирж өргө” (Матай 5:23-24).

Эвлэрүүллийн ямар гайхалтай дүр зураг вэ! Иаков ахынхаа өмнө үнэхээр даруу байсан юм. Тэрээр түүнд долоон удаа мөргөжээ. Бурхан Есавын зүрх сэтгэлийг дүүгээ хүлээж авах хүртэл ямар гайхалтайгаар өөрчлөн бэлтгээ вэ! “Хүмүүний зам ЭЗЭНий таалалд нийцэх цагт Тэрээр түүний дайснуудыг нь хүртэл түүнтэй эв түнжинтэй байлгадаг” (Сургаалт үгс 16:7). “Тэр намайг хүчит дайснаас минь болон намайг үзэн ядагчдаас аварсан. Учир нь тэд миний хувьд дэндүү хүчтэй байв” (Дуулал 18:17).



## ТҮҮХ 33. ИАКОВ БЕТЕЛД ЭРГЭЖ ИРЭВ

Бурхан Иаковд хандаж “Чи босоод Бетел уруу яв, тэнд суурьш. Тэгээд Есав ахаасаа нүүр буруулан зугтаж байсан тэр үед чамд үзэгдсэн Бурханд зориулан тэндээ тахилын ширээг босго” гэв. Иаков гэрийнхэн болон хамт байгаа бүх хүмүүстээ

хандаж “Та нар өөрсөддөө байгаа харийн бурхдаа хаяж, биесээ ариусган, хувцсаа сольцгоо! Бүгдээрээ босож, Бетел уруу явцгаая. Миний зовлонг өдөр надад хариу өгч, хаана ч явсан, надтай хамт байсан Бурханд зориулж, тахилын ширээг тэнд би

босгоно” гэж хэлэв. Тэд гартаа байсан хамаг харийн бурхад, чихэндээ байсан ээмгүүдээ Иаковд өгчээ. Иаков тэдгээрийг нь Шехемийн ойролцоох царс модны доор булав. Тэд хөдөлсөн бөгөөд тэдний эргэн тойронд байсан бүх хотыг Бурхан айлган сүрдүүлж байсан тул Иаковын хөвгүүдийн

хойноос хэн ч мөрдөн хөөсөнгүй. Иаков болон түүнтэй хамт байсан бүх хүн Канаан нутаг дахь Луз буюу Бетелд хүрч ирэв. Тэрээр тэндээ тахилын ширээ босгож, уг газрыг Елбетел хэмээн нэрлэжээ. Учир нь Иаковыг ахаасаа зугтаж байсан тэр үед тэнд Бурхан Өөрийгөө түүнд илчилжээ.

## Бодох Зарим Зүйлс

Иаков хэрэв Бурхан өөрт нь боломж өгөх юм бол аль эрт Бетел уруугаа буцна гэж тангарагласан байлаа. (Эхлэл 28:20-22). Гэвч тэр хурдан харьсангүй. Тэрээр буцах замдаа Шехемд буудаллав. Учир нь тэнд түүний нэр муулагджээ. (Эхлэл 34-р бүлгийг унш). Харин одоо Бурхан Иаковд тодорхойгоор Бетел уруу явж, тэндээ амьдран Өөрт нь зориулан тахилын ширээ босгохыг тушаажээ” Энэ нь гэмшлийн дуудлага байлаа.

Есүс нэгэн удаа Ефесийн нэгэн сүмд хандан “Харин Надад чиний эсрэг зүйл байна. Юу гэвэл чи анхны хайраа орхижээ. Тиймээс чи хаанаас унаснаа санаж гэмш. Чи анх хийж байсан үйлсээ үйлд” хэмээжээ (Илчлэлт 2:4-5а). Иаков одоо л гэр бүлийнхээ сүнслэг удирдлагыг сэргээв. Бүх худал шүтээнүүдээ зайлуулсан бөгөөд гэр бүлийнх нь гишүүд өөрсдийгөө ариусгаад, хувцсаа сольж өмсжээ. Тэд Бетелд (“Бурханы өргөө”) ирэхэд Иаков Бурханд зориулан тахилын ширээ босгосон бөгөөд үүнийгээ “Элбетел” гэж нэрлэжээ. Энэ нь “Бурханы өргөөний Бурхан” гэсэн утгатай ажээ. Бурханы өргөөнд очих нь сайн хэрэг мөн боловч Бурханыг Өөрийг нь таньж мэдэх нь илүү чухал юм. Та гэр бүлийнхэндээ Бурханы тухай заадаг уу аль эсвэл Бурханыг яг Өөрийг нь хэн бэ гэдгийг хэлж өгдөг үү?



Бид гэр бүлийнхнийгээ Бурханы магтаал дотор болон өөрсдийгөө Түүнд амьд тахил болгон өргөдөг болсныхоо дараа удирдах хэрэгтэй. Зайлуулах ёстой ямар төрлийн “хуурамч шүтээн” танай гэр бүлд байна вэ? Бурхан таны анхны хайр байсан тэр мөч рүүгээ эргэн оч.

**“Чи өөрийн Бурхан ЭЗЭНийг бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч чадлаараа хайрла. Өнөөдөр Миний чамд тушааж байгаа энэ үгсийг чи зүрхэндээ байлгаж, хөвгүүддээ хичээнгүйлэн зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, өндийн босохдоо ч түүний тухай ярьж бай”** (Дэд хууль 6:5-7).

## **ТҮҮХ 34. РАХЕЛ БЕТЛЕХЕМД НАС БАРАВ**

Эхлэл 35:16-19

Тэднийг Бетелээс хөдлөөд, Ефратад хүрэхээс арай өмнөхөн Рахел төрөх болж, хүчтэй өвджээ. Түүнийг хүндрэлтэйгээр төрөх үед эх баригч нь “Битгий ай. Та одоо бас нэг хүүтэй болно” гэж хэлэв. Тэрээр

насан эцэслэж, сүнс нь зайлан одох үедээ хүүгээ Бен-Они гэж нэрлэжээ. Харин эцэг нь түүнийг Бениамин хэмээн нэрлэв. Рахел нас барж, түүнийг Ефрат (Бетлехем) орох зам дээр оршуулав.

### **Бетлехемд болсон Онцгой Үйл явдал**

Магадгүй Рахелын гадаад гоо үзэмж нь сүнсний хувьд түүнд саад болж байсан байх. Тэрээр эцгийнхээ гэрийг орхихдоо түүний бурханыг хамт авч явжээ. Гэвч одоо тэд нар нь бүгд зайлуулагдсан юм. Тэрээр эгчтэйгээ барьцаж байсан учир Бурхан түүнийг Өөрийг нь эрж хайгаасай хэмээн түүнд үргүй байх он жилүүдийг зөвшөөрчээ. Ингээд Бурхан түүний залбирлыг сонсож түүнд Иосеф хэмээх хөвгүүн заяажээ. Рахелын Бурханд итгэх итгэл нь туйлын хүчирхэг байсан тул тэрээр Бурхан дахин нэг хүү нэмж өгнө гэж итгэн эхний хүүгээ “Нэмсэн” гэсэн утга бүхий “Иосеф” гэдэг нэрээр нэрлэжээ. Гэвч харамсалтай нь түүний хоёр дахь хүү Бениамин нь төрөх үед тэрээр насан эцэслэжээ.

Рахелын нас барсан Бетлехем нь сүүлд Рут, Боаз хоёр гэр

бүл болж тэдний дундаас Давид хааны өвөө болох Обедийн мэндэлсэн төрөлх хот юм. Давид багадаа хонь хариулж явахдаа Бетлехемийн толгод дээр гарч Бурханд дууллыг өргөдөг байлаа. Олон зуун жилийн дараа Марь Иосеф хоёр Давидын хот Бетлехемд ирж, Аврагч Есүс мэндэлсэн юм. Бетлехемд болсон харамсмаар зүйл нь Херод хаан Есүстэй хамт төрсөн бүх хоёр наснаас доошхи балчир насны хүүхдүүдийг алахыг тушаасан явдал байлаа. “Эш үзүүлэгч Иеремиагаар дамжуулан хэлсэн нь тэр цагт биелэгдсэн агаад ингэхдээ “Ихэд гашуудан уйлах дуу Рамад сонсдов. Рахел тайтгарлыг авахаас татгалзан, хүүхдүүдийнхээ төлөө уйлна. Учир нь тэд нар нь байсангүй” гэсэн байв” (Матай 2:17-18).

“Харин чиний хувьд, Бетлехем Ефрата аа, хэдийгээр чи Иудагийн бүлүүдийн дунд өчүүхэн авч, Миний төлөө Израилийг захирах Нэгэн нь чамаас гарах болно. Түүний гарч ирэх нь эртнээс, мөнхийн өдрүүдээс байсан юм” (Мика 5:2).

## ТҮҮХ 35. ТААЛЛЫГ ОЛСОН ХҮҮ ИОСЕФ

Эхлэл 37:1-8, 12-14а, 17-28, 31-35

Иаков эцгийнхээ сууж байсан газар Канааны нутагт амьдран суужээ. Иаковын үр удмынхан энэ болой. Арван долоон настай байхдаа залуу хүү Иосеф ах нартайгаа эцгийнхээ татвар эхнэр Билха, Зилша хоёрын хөвгүүдийнх нь хамт хонь хариулж байлаа. Иосеф эцэгтээ тэдний талаар сайнгүй мэдээ авчиржээ. Израилийг өндөр настай болсон хойно Иосеф төрсөн тул тэрээр түүнийг бусад хөвгүүдээсээ илүү хайрлаж, түүнд урт, тансаг дээл хийж өгчээ. Эцэг нь түүнийг бусад хөвгүүдээсээ илүү хайрлалгийг ах нар нь хараад, Иосефийг үзэн ядаж,



түүнтэй эв найртай ярилцаж чаддаггүй байжээ.

Иосеф нэгэн зүүд зүүдлээд, түүнийгээ ах нартаа ярьсанд тэд түүнийг улам үзэн ядах болжээ. Иосеф тэдэнд ярьсан нь “Миний зүүдэлсэн зүүдийг

сонсогхооно уу” гээд тэдэнд ярьсан нь “Биднийг тариалангийн талбайд сүрэл боож байтал миний боосон сүрэл босоод зогсчихов. Гэтэл та нарын боосон сүрэл миний сүрлийг тойрон цуглараад, түүнд мөргөцгөөв” гэжээ. Ах нар нь түүнд хандаж “Чи үнэхээр бидний хаан болно гэж үү?” гэгцгээжээ. Ах нар нь түүний зүүд, түүний ярианаас болоод улам илүү үзэн ядах болжээ.

Ах нар нь Шехемд очиж, эцгийнхээ хонийг хариулахаар явахад Израиль Иосефт хандаж “Ах нар чинь Шехемд хонио хариулж байгаа биш үү? Нааш ир! Би чамайг тэдэн уруу явуулья” гэсэнд Иосеф эцэгтээ “Тэгье” гэжээ. Израиль түүнд “Одоо чи яваад, ах нараа, бас хонин сүргээ мэнд сайн байгаа эсэхийг үзээд, надад эргэж хэл” гэв”...Иосеф ах нарынхаа хойноос явж, тэднийг Дотанаас олжээ.

Тэд Иосефыг тэнд ойртож ирэхээс нь өмнө холоос хараад, түүнийг алахаар хуйвалджээ. Тэд “Нөгөө зүүдлэгч ирж байна” хэмээн бие биедээ хэлэв. “За, одоо цөмөөрөө нааш ир! Түүнийг алж, энэ нүхлүүдийн нэгэнд хаяад, “Зэрлэг араатан түүнийг идсэн” гэж хэлцгээе. Тэгээд түүний зүүд юу болохыг харшгаая л даа” гэжээ. Реубен үүнийг сонсоод, Иосефыг тэдний гараас аврахаар “Бид түүний амь насыг хорлохоо больцгооё” гэв. Реубен бас тэдэнд “Цус бүү урсга. Түүнийг цөлнйн энэ нүхэнд хая. Харин түүнд гар бүү хүр!” гэв. Энэ нь түүнийг аварч, эцэг

уруу нь буцаах гэснийх ажээ. Иосефыг ах нар дээрээ хүрч ирмэгц тэд, Иосефын дээл буюу өмссөн тансаг дээлийг тайлж, түүнийг барьж аваад нүхэнд шидэв. Тэр нүх нь дотроо усгүй хоосон байлаа.

Тэд сууцгаан, хоолоо идэж байгаад, хараагаа өргөн хартал, ишмаелчуудын жингийн цуваа Гилеадаас ирж явав. Тэд тэмээнүүддээ анхилуун үнэрт бараа, үнэрт тос, гүгэл ачаад Египет уруу аваачихаар явж байжээ. Иуда ах дүү нартаа хандаж “Бид дүүгээ алж, түүний цусыг нууснаар юу хожих юм бэ? Түүнийг ишмаелчуудад худалдашгаая! Түүнд гар бүү хүргээ! Тэр бол бидний дүү, бидний мах цусны тасархай гэсэнд ах дүү нар нь үгэнд нь оров. Мидианыхны худалдаачид ирж өнгөрөхөд, тэд Иосефыг нүхнээс нь татаж гаргаад ишмаелчуудад хорин шекел мөнгөөр түүнийг худалдав. Жинчид Иосефыг авч Египет уруу оджээ.



Тэд Иосефын урт дээлийг аваад, нэг эр ямааг алаад, цусанд нь түүний урт дээлийг дүрэв. Тэгээд тэд тэр тансаг дээлийг илгээж, эцэгтээ хүргээд, “Бид үүнийг оллоо. Хүүгийн чинь урт дээл мөн, эсэхийг хараарай!” гэсэнд тэрээр дээлийг таниад, “Миний хүүгийн дээл мөн байна. Зэрлэг араатан түүнийг барьж иджээ. Иосеф тастчуулсан нь гарцаагүй” гэхэд Иаков хувцас хунараа урж

тастаад, бүдүүн таараар ууц нуруугаа ороож, хүүгийнхээ төлөө олон хоног гашуудан гашуудсаар байлаа. Хөвгүүд охид нь бүгдээрээ түүнийг тайвшруулахаар очиход тэрээр тайвшрахаас татгалзаж, “Би хүүгийнхээ төлөө гашуудсаар, өөр ертөнцөд одсон хүүгийнхээ араас хүрч очъё” гэв. Тэгээд эцэг нь түүний төлөө гашуудан уйлжээ.

## Иосефыг Ах нар нь Үзэн ядав

Бурхан олон тооны ертөнц бүтээснийгээ “Тэр бас оддыг бүтээв” (Эхлэл 1:16) гэсэн ганцхан богино өгүүлбэрт багтаан өгүүлсэн байдаг. Харин Тэрээр Иосеф хэмээх нэгэн хүний түүхийг өгүүлэхийн тулд Эхлэл номын бүхэл бүтэн дөрвөн бүлгийг түүнд зориулжээ. Учир нь бурханлаг амьдарсан нэг хүн ч гэсэн Бурханы хувьд чухалд тооцогддог. Та ч гэсэн Иосеф Христийн адил бүх зовлон бэрхшээлээ даван туулж гарсан шиг Бурханы Хүү Есүстэй адил болгогдохоор сонгогдсон.

Бид Иосеф Есүстэй хир адил болсныг харах болно. Бурхан Иосефт зориулсан Өөрийн зорилгыг хоёр удаа түүний зүүдэнд илэрхийлжээ. Мөн Иосеф зөвийг үйлдэж, бусад ах нараасаа илүү аав Иаковтаа сайшаагдаж байсан учир тэд түүнийг үзэн ядах болов. Есүс хүртэл хүүхэд байхдаа Өөрийн тэнгэрлэг Эцгийнхээ ажлыг явуулж байсан юм. Есүс Иосеф хоёр хоёулаа аавын хайртай хүүхдүүд байсан бөгөөд хоёулаа тэднээр илгээгдэж байсан боловч хоёуланг нь хүлээж аваагүй юм. “Тэр [Есүс] Өөрийнхөндөө ирсэн боловч Өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй” (Иохан 1:11). “Тэд намайг шалтгаангүйгээр үзэн ядсан” (Иохан 15:25a).

Есүс Өөрийгөө Сайн Хоньчин гэж хэлсэн байдаг (Иохан 10:11). Мөн Иосеф хоньчин байсан юм. Иосеф Есүс хоёрын

хоёулангийнх нь дээлийг тайлж авч байсан бөгөөд хоёулаа худал зүйлд буруутгагдаж байсан. Мөн хоёуланг нь Египетэд аваачиж байсан. Есүсийг нялх байхад нь Херод хааны уур хилэнд өртүүлэхгүй гэж тэнд аваачиж байжээ. Мөн хоёулаа боол болон худалдагдсан. Есүс гучин мөнгөн зоос буюу жирийн нэгэн боолын үнээр худалдагдсан бол Иосеф хорин мөнгөн зоос буюу зэрэмдэг согогтой боолын үнээр худалдагдаж ээ. Ямар муухай доромжлол вэ! Гэвч Бурхан Иосефт агуу зүйлийг бэлдэж байлаа. **“Хэн та нарын дунд агуу болохыг хүснэ, тэр хүн та нарын зарц болог”** (Марк 10:43.6). Есүс Иосеф хоёр хоёулаа харь газар очиж үйлчлэхийн тулд эцгийнхээ гэрт байхдаа агуу хүндэтгэл хүлээсэн байр сууриа орхицгоон явсан билээ.

**“Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай. Тэрээр хэдийгээр Бурханы мөн чанараар оршин байсан боловч, Бурхантай тэгш байх явдлыг Өөртөө хадгалах зүйл гэж үзсэнгүй, харин Өөрийгөө хоослож, боолын дүрийг авч, хүнтэй адил болжээ”** (Филиппой 2:5-7). Харин та бусдад хэрхэн үйлчилж байна вэ? Хэрэв та яг одоо даруу болох үйл явц дундуур гарч байгаа бол Есүсийг санагтун. **“Сэтгэлээр унахгүй байж тэнхээгээ барахгүйн тулд Түүнийг санагтун”** (Еврей 12:3).

Түүнчлэн та Бурхан зохистой цагт таныг өргөмжлөх болно гэдгийг санагтун. Мөн Тэрээр таныг ямар ч зовлон дунд байсан гэсэн үргэлж таныг тайвшруулдаг. **“Иймд Бурханы хүчирхэг мутрын дор өөрсдийгөө даруу байлга. Тэгвэл Бурхан зохистой цагт та нарыг өргөмжилнө. Тэр та нарын төлөө санаа зовдог учраас бүх зовнилоо Түүнд үүрүүл”** (1Петер 5:6-7).

Есүс **“Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ”** гэжээ (Иохан 20:21.6).

Бид Иосеф Есүс хоёрт учирснаас илүү хэцүү зүйлсийг хүлээж авч чадахгүй. **“Хэрэв тэд Намайг хавчсан бол, та нарыг бас хавчих болно...”** (Иохан 15:20.6). Гэвч бид Бурхан бидэнтэй байгаа гэдгийг болон Тэрээр Өөрийн зорилгыг бидний дотроос биднээр дамжуулан

гаргах гэж байгааг мэдэх юм бол амар тайван байж чадна. “Учир нь энэхүү өнөө үеийн зовлонгууд нь бидэнд илчлэгдэх тэрхүү алдартай зүйрлүүлшгүй гэж би боддог” (Ром 8:18). Тиймээс бид Түүнтэй хамт хаанчлах цаг айсуу.

## ТҮҮХ 36. ИОСЕФ СОРИГДОВ

Иосеф Египет уруу хүргэгдэв. Тэнд түүнийг авчирсан ишмэлчүүдийн гараас Фараоны түшмэл, ордны харуулын захирагч Потифар гэдэг нэгэн египет хүн түүнийг худалдан авчээ. ЭЗЭН Иосефтой хамт байсан учир түүний бүх ажил үйлс бүтэмжтэй болж, тэр өөрийн эзэн Египет хүний гэрт сууж байлаа. Түүний эзэн нь ЭЗЭН түүнтэй хамт байгааг харж, мөн ЭЗЭН түүний хийсэн бүхнийг бүтэмжтэй болгож байгааг үзэв. Иосеф эзнийхээ хайр ерөөлийг хүртэж, түүнд зарагдсанд тэрээр түүнийг гэрийнхээ даамал болгон, бүх эд хөрөнгөө түүнд даатгажээ.

Тэрээр Иосефын гарт бүх эд хөрөнгөө даатгаад, өөрийн идэх хоолноос бусад зүйлийг мэдэхээ больжээ. Иосеф нь чийрэг сайхан биетэй, үзэсгэлэнтэй сайхан эр байлаа. Түүнээс хойш эзнийх нь эхнэр Иосефыг харцаараа өдөж, “Надтай унтаач” хэмээн гуйв. Харин Иосеф татгалзаж, эзнийхээ эхнэрт “Миний эзэн гэрийн доторх бүх эд хөрөнгийг мэддэггүй, бүгдийг нь надад даатгасан...”

Энэ гэрт надаас илүү их хүн байхгүй. Эзэн танаас бусад юуг ч надад хориглоогүй учир нь та бол түүний эхнэр. Би яаж ийм муухай хэрэг үйлдэж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ?” гэв. Тэр



эмэгтэй өдөр бүр Иосефыг гуйсаар байсан боловч Иосеф үгийг нь сонссонгүй, түүнтэй унтсан ч үгүй, түүнтэй хамт байсан ч үгүй. Нэгэн өдөр Иосефыг ажлаа хийхээр гэрт нь ороход, гэрийнхнээс нэг ч хүн тэнд байсангүй. Тэр эмэгтэй түүний хувцаснаас чангааж, “Надтай унтаач” гэсэнд Иосеф түүний гарт хувцсаа орхиод, гадагш зугтан гарав.

Тэрээр эзнийхээ гэртээ иртэл нь нөгөө хувцсыг дэргэдээ тавьж байв. Тэгээд тэр түүнд мөн л нөгөө үгээ хэлж “Таны бидэнд авчирсан еврей зарц намайг доромжлохоор над уруу орж иртээ. Намайг чанга дуугаар хашхирахад тэрээр хувцсаа надад орхиод, гадагш зугтан гарсан” гэв. Эзэн нь “Таны зарц намайг ишгэлээ” гэж өөрт нь хэлсэн эхнэрийнхээ үгийг сонсоод, уур нь шатжээ. Иосефын эзэн түүнийг барьж,

шоронд хорив. Тэр шорон нь хааны ялтнуудыг хорьдог шорон байжээ. Иосеф шоронд хоригдож байсан ч ЭЗЭН Иосефтой хамт байж, түүнд хайр энэрлийг үзүүлж, шоронгийн харгалзагчийн ерөөлийг ч хүртээжээ.

Шоронгийн харгалзагч нь шоронд байсан бүх хоригдлыг Иосефын гарт даатгав. Тэнд хийгдэх ажил болгонд Иосеф хариуцлагатай байв. Учир нь Эзэн Иосефтой хамт байж, түүний хийсэн бүхнийг бүтэмжтэй болгожээ.

## Бодох Зарим Зүйлс

“Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн гарах замыг ч өгдөг юм” (1Коринт 10:13).

**Иосеф зугтаж байж л сорилтноос гарч чадах байсан.** “Хэрэв та нар нүгэл үйлдээд ширүүн нударгад өртөхдөө тэвчлээ ч, үүнд ямар гавьяа байх билээ? Харин хэрэв та нар зөвийг үйлдээд зовоходоо, үүнийг хүлцэн тэвчвэл, энэ нь Бурханы тааллыг олдог” (1Петер 2:20).

“Харин та нар зөвт байдлын төлөө зовлон эдлэхэд хүртэл хүрлээ ч та нар ерөөлтэй. Тэдний сүрдүүлгээс бүү ай, бүү зов... Христийг Эзэн хэмээж зүрхэндээ тусгаарлан нандигна. Мөн сайн мөс чанартай бай! Ингэснээр Христ доторх та нарын сайнаар биеэ авч явахыг муучлагчид та нарыг гүйтгэсэн зүйлдээ ичих болно” (1Петер 3:14-16).

**Мөн Есүс хүртэл соригдож байсан боловч хэзээ ч бууж өгөөгүй юм.** “Учир нь Тэр Өөрөө соригдон зовлон эдэлж байсан тул сорилтонд орогсдод тусалж чадна” (Еврей 2:18).

“Учир нь бидэнд байгаа нь бидний мөхөс байдлыг хуваалцаж чаддаггүй тэргүүн тахилч бус, харин нүгэлгүй атлаа бүх талаар бидэн шиг соригдсон Нэгэн билээ. Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очицгооё” (Еврей 4:15-16).

## Иосеф Шоронд байхдаа Бурханд Үйлчлэв

Иосефыг шоронд байхад нь түүнд олон хариуцлага өгөгдсөн бөгөөд Бурхан түүний хийсэн бүхнийг нь бүтэмжтэй болгож байлаа. Мөн Иосефыг шоронд байх жилүүдэд нь Бурхан түүнд хоёр залуу хоригдлын зүүдийг нь тайлахад тусалжээ. (Эхлэл 40-р бүлэг). Хоёр тайлбар нь хоёулаа биелжээ. Фараон ахлах талхчингаа дүүжилсэн боловч ахлах сөнчөө хуучин ажилд нь эргүүлэн тавьжээ.

**Иосеф ахлах сөнчийг Фараон хуучин ажилд нь эргүүлж тавих үед өөрийг нь санахыг түүнээс гуйжээ. Гэвч хааны сөнч Иосефийг саналгүй таг мартчихав. Хоёр жилийн дараа Фараон зүүд зүүдэлсэн боловч түүнийг нь тайлах хүн байсангүй. Яг тэр үед хааны сөнч Иосефыг санаж, хааны зүүдийг тайлж чадах нэг хүн байгааг түүнд хэлсэнд тэрээр түүнийг Иосеф уруу илгээв. "Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая. Учир нь хэрэв бид шантрахгүй байвал цаг нь болохоор хурааж авна" (Галат 6:9).**

## ТҮҮХ 37. ИОСЕФ ЕГИПЕТИЙН УДИРДАГЧ БОЛОВ

Эхлэл 41:14-40, 42, 46-54

Тэгээд Фараон зарлага явуулж, Иосефыг дуудуулав. Тэд шоронгоос түүнийг даруй гаргажээ. Иосеф сахлаа хусаж, хувцсаа солиод, Фараон дээр орж ирэв. Фараон Иосефт хандаж “Би нэг зүүд зүүдэллээ. Гэтэл түүнийг тайлж чадах хүн нэг ч байсангүй. Чамайг зүүд сонсоод тайлж чаддаг гэж би сонслоо” гэв. Иосеф Фараонд хандаж “Энэ бол би биш, харин Бурхан Фараонд сэтгэлийг амраах хариу өгнө” гэв. Фараон Иосефт хандаж “Би зүүдэндээ Нил мөрний

эрэг дээр зогсож байх юм. Тэгтэл тарган, сайхан долоон үхэр Нил мөрнөөс гарч ирээд, зэгснээс идэж байлаа. Тэдний хойноос туранхай, муухай долоон үхэр гарч ирлээ. Би тэдэн шиг муухай үхрүүдийг Египетийн нутагт хэзээ ч үзээгүй билээ. Тэр туранхай муухай үхрүүд нь түрүүчийн долоон тарган үхрүүдийг идчихлээ. Тэд түүнийг идсэн боловч юу ч идээгүй юм шиг урьдын адил муухай хэвээрээ л байлаа. Тэгээд би сэрлээ. Би бас зүүдэндээ харсан нь: нэг ишнээс долоон өтгөн сайхан тариан түрүү гарч, түүний дараа

дорнын салхинд хатаж хорчийсон долоон нарийхан түрүү гарч ирэв. Тэгээд тэр нарийхан түрүүнүүд нь долоон сайхан түрүүгээ залгчихав. Би зүүдээ мэргэч, төлгөчдөд хэлсэн боловч түүнийг надад тайлж чадсан хүн нэг ч байсангүй” гэж хэлэв. Иосеф Фараонд хандаж “Фараон таны зүүд чинь нэг л байна. Бурхан Өөрийн хийх гэж байгаа зүйлээ Фараон танд үзүүлжээ. Долоон сайхан үхэр бол долоон жил, долоон сайхан түрүү бол бас долоон жил юм. Эдгээр зүүд нэг бөгөөд адилхан юм. Тэдний хойноос гарч ирсэн долоон муухай үхэр нь долоон жил юм. Бурхан Өөрийн хийх гэж байгаа зүйлээ Фараонд үзүүлнэ гэж миний Фараонд хэлсэн үг бол энэ юм. Египетийн бүх нутаг даяар маш өнтэй сайхан долоон жил болж, дараа нь ган зудтай долоон жил залгаж, Египетийн нутагт өнтэй сайхан байсан бүхэн маргагдаж, тэр нутаг өлсгөлөнд сүйрэх болно. Залгаж ирсэн ган зуд нь маш хүнд хэцүү учир тэр нутагт өнтэй сайхан байсан жилүүдийг огт санаж чадахгүй болно. Фараон та тэр зүүдийг хоёр дахин зүүдэлсэн нь Бурхан хийх гэж байгаа зүйлээ хатуу шийдсэний учир тэр бөгөөд Бурхан үүнийгээ даруй хийх болно. Фараон та цэцэн мэргэн ухаантай хүн олж, Египетийн нутгийг захируул. Фараон та тийнхүү газар нутагтаа түшмэдийг томилж, өнтэй сайхан долоон жилийн дотор Египетийн газар нутгийн ургацын тавны нэгийг нь хурааж, тэднээр ирэх



өнтэй сайхан он жилүүдийн бүх ургацыг хураалгаж, үр тариагаа Фараоны гарт мэдүүлж, хүнсэнд зориулж, хотуудад хадгалуул. Энэ ургацыг Египет нутагт болох гэж байгаа долоон жилийн ган зудад зориулан нутагтаа нөөцөл. Тэгвэл тэр газар нутаг ган зудад сүйрэхгүй болно” гэв. Энэ нь Фараоны болон түүний бүх түшмэдэд сайхан санагджээ. Фараон түшмэддээ хандаж “Бурханы сүнсгэй ийм хүнийг хаанаас олох вэ?” гээд Фараон Иосефт хандаж “Бурхан энэ бүх зүйлийг чамд л үзүүлсэн учир чам шиг цэцэн, мэргэн ухаантай хүн алга. Чи миний өргөөг захирах болно. Миний ард түмэн бүгдээрээ чиний үгийг дагана. Би зөвхөн хаан ширээнд сууж байгаагаараа чамас илүү” гэж Иосефт хэлээд, өөрийн тамгатай бөгжөө гараасаа мултлан, Иосефын гарт зүүж, нарийн даавуун дээлээ өмсгөн, алтан гинжийг хүзүүнд нь зүүв.

Иосеф Египетийн хаан Фараоны өмнө ирж зогсохдоо гучин настай байлаа. Иосеф Фараоныхаас

гараад, Египетийн бүх газар нутгаар аялав. Өнгтэй долоон жилийн туршид тэр нутагт маш арвин ургац гарчээ. Иосеф Египетийн газар нутагт долоон жилийн турш гарсан бүх ургацыг хураан авч, хотуудад хадгалж, хотын эргэн тойрон дахь талбайн ургацыг хот тус бүрд нь нөөцлөв. Иосеф далайн эргийн элс мэт арвин их тариа хураасан нь хэмжээлшгүй их байсан учир түүнийгээ тоолохоо больжээ. Ган зудгай жилүүд эхлэхээс өмнө Иосефт хоёр хүү төрөв. Тэднийг Оны тахилч Потиферагийн охин Асенат Иосефт төрүүлжээ. Иосеф ууган хүүдээ Манассе гэдэг нэр өгөөд, “Учир нь Бурхан миний бүх зовлонг хийгээд эцгийн минь бүх гэрийг надад мартуулсан юм” гэжээ. Удаах хүүдээ Ефраим гэдэг нэр өгөөд, “Учир нь

Бурхан миний зүтгэж хөдөлмөрлөсөн газраас намайг агуу их үр бүтээлтэй болгосноос тэр болой” гэжээ. Египетийн газар нутагт өнгтэй долоон жил дуусаж, Иосефын хэлсэн ёсоор, ган зудгай долоон жил эхэлжээ. Бүх газар нутаг ган зудад нэрвэгдсэн боловч харин Египетийн бүх нутаг хоол хүнгтэй байжээ”

Эхлэл 42:1-3

Энэ үед Египетэд үр тариа байгааг Иаков мэдээд, хөвгүүддээ хандаж, “Та нар яагаад бие биеэ хараад суугаад байгаа юм бэ?” гэж хэлэв. Иаков бас “Египетэд үр тариа байна” гэж би сонслоо. Та нар тийшээ явж, тэндээс билэнд үр тариа худалдаж авчир! Тэгвэл бид амьд үлдэж үхэхгүй” гэв. Тэгээд Иосефын арван ах нь Египетээс үр тариа худалдаж авахаар явав.

## Бодох Зүйлс

Иосеф шиг Есүс Өөрийн үйлчлэлээ гучин настайдаа эхэлжээ. Мөн Иосеф хэцүү зовлонтой мөчүүдийнхээ дараа өндөр байр сууринд тавигдсантай яг адил Есүс ч бас Өөрийн зөв газраа ийнхүү өргөгджээ. “Хүн төрхийг олсон Тэрээр үхэлд ч төдийгүй загалмайн үхэлд ч хүртэл дуулгавартай байснаараа Өөрийгөө даруу болгов. Тиймээс ч Бурхан Түүнийг үлэмжийн дээдээр өргөмжилсөн бөгөөд аливаа нэрнээс дээд нэрийг Түүнд соёрхов. Энэ нь Есүсийн нэрд тэнгэрт байгаа, газар дээр байгаа, газрын доор байгаа бүх юмс өвдөг сөгдөж, мөн бүх хэл Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хүлээн зөвшөөрөх ёстойн учир ажээ” (Филиппой 2:8-11).

“Тэр үндэстнүүдийн хоорондохыг шүүж, олон ард

түмнүүдэд шийдвэр гаргах болно... Үндэстэн үндэстнийхээ эсрэг илд далайхгүй бөгөөд дахин хэзээ ч тэд дайтахад суралцахгүй” (Исаиа 2:4).

Нэгэн удаа Иосефын ах нар нь түүнд хандан “**Чи үнэхээр бидний хаан болно гэж үү? Чи үнэхээр биднийг захирах болно гэж үү?**” (Эхлэл 37:8). Нэгэн сургаалт зүйрлэлээр Есүс тухайн үед Өөрийнх нь эсрэг байсан Иудейн удирдагчдын хандлагыг илэрхийлэн харуулав. “**Энэ хүн биднийг захирахыг бид үл хүснэ**” (Лук 19:14). Гэвч энэ дэлхийн бүх хаанчлал Христийн хаанчлал болох бөгөөд “**Тэрээр үүрд мөнхөд хаанчлах болно!**” (Илчлэлт 11-15).

Та Есүсийг өөрийн амьдралдаа Эзэнээ болгон хүлээн авсан уу? Та түүний удирдлаганд дуулгавартай байсан уу? “**Энэ бол итгэмжит үг мөн. Учир нь хэрэв бид Түүнтэй хамт үхсэн хүн юм бол, мөн Түүнтэй хамт амьд байх болно. Хэрэв бид тэвчвэл, мөн Түүнтэй хамт хаанчлах болно. Хэрэв бид Түүнийг үгүйсгэвэл, мөн Тэр биднийг үгүйсгэх болно**” (2Тимот 2:11-12).

Хэрэв бид аврагдсан л юм бол Есүстэй хамт хаанчлах өдөр ирж байгаа. (Илчлэлт 5:9-10)

“**Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийнд заларсны адил Надтай хамт Миний сэнтийнд залрахыг ялагчид соёрхоно**” (Илчлэлт 3:21).

## **ТҮҮХ 38. ИОСЕФ ӨӨРИЙН АХ НАРАА УУЧИЛСАН НЬ**

Эхлэл 45:1-11, 14-15

Иосеф хажуудаа байсан үйлчлэгч зарц нарынхаа өмнө сэтгэлээ барьж чадахгүйд хүрээд, “Бүгдээрээ надаас зайлцгаа!” хэмээн хашхирчээ. Иосефыг ах дүү нартаа өөрийгөө таниулахад нь түүний хамт хэн ч

байсангүй. Иосефыг енгэнэн уйлсан нь египетчүүдэд сонсогдсон ба Фараоны ордонд ч сонсогджээ. Иосеф ах дүү нартаа хандан “Би Иосеф байна. Эцэг минь одоо хүртэл амьд сэрүүн байна уу?” гэсэнд ах дүү нар нь түүнээс айн сандарснаасаа



болоод хариулж чадсангүй. Иосеф ах нартаа “Над уруу ойртогчоо” гэсэнд тэд ойртон очжээ. Тэгээд Иосеф “Би бол та нарын дүү Иосеф, та нарын египет уруу худалдсан тэр хүн чинь байна. Та нар намайг энэ газар худалдсандаа бүү санаа зов, бүү харамс” Бурхан амийг аврахаар та нараас өмнө намайг илгээжээ. Энэ нутагт хоёр жилийн турш ган зуд болсон бөгөөд бас дахин таван жил газар хагалж ч чадахгүй, ургац хурааж ч чадахгүй. Бурхан их авралаараа та нарыг амьд үлдээж, үр удмыг чинь газар дэлхий дээр уламжлан үлдээхээр та нараас өмнө намайг илгээжээ. Тийм учраас намайг нааш нь та нар явуулаагүй, харин Бурхан явуулсан. Бурхан намайг Фараоны эцэг, түүний бүх гэрийн эзэн, Египетийн бүх нутгийн захирагч болгосон билээ. Та нар эцэг дээр минь түргэн очиж, түүнд “Таны хүү Иосеф ингэж хэлэв. “Бурхан таны хүү Иосефыг бүх Египетийн эзэн

болгожээ. Над уруу даруй түргэн ирээч. Та үр хүүхэд, ач зээ нар, мал сүрэг, бүх эд хөрөнгийнхөө хамт Гошен нутагт амьдран сууж, налад ойрхон бай. Ган зуд дахин таван жил үргэлжлэх учир би тэнд таныг тэжээнэ. Та болон танайхан, таны бүх харьяат нар ядарч зүдэрч магадгүй” гээрэй” гээд өөрийн дүү Бениаминыхаа хүзүүгээр тэврэн уйлахад Бенямин ч бас түүний хүзүүгээр тэврэн уйлав. Иосеф бас ах нараа үнсээд, тэвэрч уйлав. Тэгээд ах нар нь түүнтэй ярилцаагаав.

Эхлэл 47:28; 50:15, 18-22

Иаков Египетийн нутагт арван долоон жил амьдран сууж, зуун дөчин долоо насалжээ.

Иосефийн ах дүү нар эцгийнхээ нас барсныг хараад “Хэрэв Иосеф бидний эсрэг өс санаж, өөрт нь бидний хийсэн бүх гэм хорыг бидэнд эргүүлж хийх гэвэл яах вэ?” хэмээн ярилцаагаав. Тэгээд тэд Иосефт хэл дамжуулж “Эцэг чинь нас барахынхаа өмнө “Ах нар чинь чамд гэм хорыг хийсэн боловч тэдний буруу нүглийг чи одоо уучлаарай гэж та нар Иосефт хэл” гэсэн учир та эцгийнхээ Бурханы зарц бидний гэм нүглийг уучилна уу?” гэж хэлсэнд тэдний үгийг сонсоод, Иосеф уйлав. Ах нар нь түүний өмнө очиж сөгдөн “Бид бол таны зарц нар” гэсэнд Иосеф тэдэнд хандаж “Битгий айдгаа. Би яахан Бурханыг орлож чадах билээ? Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө

түүнийг сайнаар эргүүлсэн юм. Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө түүнийг сайнаар эргүүлсэн юм. Та нар одоо битгий айцгаа. Би та нарыг болон

хүүхдүүдийг чинь тэтгэн тэжээе” гэж хэлээд, тэднийг тайвшруулж, нинжин сэтгэлээр ярилцав. Иосеф эдгийнхээ гэр бүлийнхэнтэй хамт Египетэд суугаад зуун арван жил наслажээ.

## **Иосеф Өөрийн Амьдрал дахь Бурханы Зорилгыг Олж Мэдэв.**

Иосефыг залуу хөвгүүн байх үед нь Бурхан түүний зүүдэнд түүнд зориулсан Өөрийн төлөвлөгөөг харуулжээ. Тэрээр өөрт нь тохиолдсон бүхэн Бурханы төлөвлөгөө мөн гэдэгт итгэж байсан учраас ах нараа уучлахад амархан байсан юм. Иосеф анхны хүүгээ төрөх үед түүнд “Мартсан” гэсэн утга бүхий Манассе гэдэг нэр өгснөөс нь хойш бид аль хэдийнэ тэрээр ах нараа уучилсан юм байна гэдгийг мэдсэн. Иосеф өнгөрснөө ардаа орхихоор шийдсэн юм. “Харин би нэг л юмыг хийдэг, ардахаа мартаж, урьдах зүйлс уруугаа зүтгэн тэмүүлж, Христ Есүс доторх Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналыг авахын төлөө бариа уруу урагшилдаг” (Филиппой 3:13б-14).

Иосефын уучлангуй, мартагч сүнсийг Бурхан ивээсэн юм. Тэрээр өөрийн хоёр дахь хүүгээ “Хоёр дахин үр жимс” гэсэн утгатай “Ефраим” гэдэг нэрээр нэрлэжээ. Бид эргэн тойрныхоо бүх нөхцөл байдал дотор Бурханы мутар ажиллаж байгааг харахын тулд Түүний төлөвлөгөөтэй уучлангуй болон үүндээ сэтгэл хангалуун байдалтайгаар зохицох нь ямар гайхалтай хэрэг вэ! Есүс Өөрийг нь цовдолсон хүмүүсийг уучилсан. Учир нь тэд юу хийж байгаагаа үнэхээр мэдэхгүй байгааг Есүс ойлгож байсан юм.

Иосефын бүх зовлон бэрхшээл нь түүнийг Христийн дүртэй адил болгож байсан юм.

**“Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүст сайны төлөө Бурхан бүх юмыг хамтдаа ажиллуулдаг**

гэдгийг бид мэднэ. Тэр өөрийнхөө Хүүг олон ах дүүсийн дунд ууган нь байлгахын тулд, урьдаас мэдсэн хүмүүсээ Тэр бас Түүний дүртэй адил болгохоор урьдаас тогтоосон юм” (Ром 8:28-29).

Иосеф ах нарынхаа зүрх сэтгэлийнх нь хандлагыг нь шалгаж байсан шиг Есүс биднийг бие биенээ хир их хайрлаж байгааг харахын тулд бидний зүрх сэтгэлийн хандлагыг шалгадаг.

**“Хэрэв та нар Намайг хайрладаг бол, Миний тушаалуудыг сахь. Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагун”** (Иохан 14:15; 15:12). Хэрэв бид Түүнийг хайрладаг бол Есүс яг Иосеф ах нарыгаа уучилж, тэднийг халамжилсан шиг Өөрийгөө бидэнд илчилж, биднийг уучлан, биднийг тэвэрч авах болно.

Бурхан бас таны амьдралд буй агуу төлөвлөгөөнийхөө төлөө таныг бэлтгэж байна. **“Чи үүн шиг ийм цагийн төлөө л хааны эрх дарханд хүрсэн ч юм бил үү хэн мэдэх вэ?”** (Естер 4:14.6). Хүн бүрийг Бурхан хаана байгаасай гэж хүсэж байна, тэр газар нь бүгдээрээ байцгаая . Тэгж чадвал Бурхан биднийг Өөрийн агуу хаанчлалынхаа төлөө ашиглаж чадна.

## **Хийх Зүйл**

**Эхлэл 50:20**-ийг цээжил.

## ГОЛ СЭДВҮҮДИЙН ТОВЬЁГ

- АБРАМ, хуудас 40-55  
дуудагдсан нь, 40-42  
Лот хоёр, 45-48  
гэрээ, 49-52, 54-55
- АБРАХАМ, 57-61, 68-73  
Зуучлан гуйв, 57-61  
Бурханы найз, 60-61  
Итгэл нь соригдов, 68-70  
Исаактаа эхнэр хайв, 70-73
- АДАМ, 15-16  
УУР харьцаатай бай  
АВРАЛЫН ХӨВӨГЧ АВДАР, 37-38  
БУРХАНЫ ХУЯГ, 48  
БАБЕЛ, 39  
БЕТЕЛ, 80-81, 96-97  
БЕТЛЕХЕМ, 98-99  
КАИН АБЕЛ ХОЁР, 25-26  
ЗЭМЛЭЛ, 88  
ХӨВЧ ХӨНДӨЛТ, 54-57  
ГЭРЭЭ, 49-52, 54-55  
БҮТЭЭЛ, 1-14  
ХРИСТИЙН ЗАГАЛМАЙ, 8, 70  
ЕЛИЕЗЕР, 70-73  
АЛБАТУУД, 90-91  
ЕНОХ, 30-31  
ЕСАВ, 74-80, 92, 95-96  
ИТГЭЛ, 41-42, 52, 65, 68-70  
ҮЕР, 35-37  
УУЧЛАЛ, 109-110  
ҮР ЖИМСТЭЙ БАЙДАЛ, 11-12, 111  
УДИРДАМЖ, 72  
ХАГАР, 53-54, 65-66, 68  
ИСААК, 64-71, 73-79  
ИШМАЕЛ, 53-54, 65-68  
ИАКОВ, 74-84, 86-97  
ууган хүүгийн эрх худалдаж  
авсан нь, 74, 76  
ивээл авахын тулд мэхлэсэн  
нь, 76-80
- Бетелд зүүдэлсэн зүүд, 80-81  
Рахелийн төлөө зарцлагдсан  
нь, 82-83  
Гэр бүлийн зөрчилдөөн, 83-94  
Бурхантай барилдсан нь, 94-95
- ИАКОВЫН ХӨВГҮҮД, 86-89  
ЕСҮС, 52  
бүтээл дотор  
илэрхийлэгдсэн, 5-14  
дахин ирэх, 31,34  
хамгаалалтын хөвөгч  
авдар, 37-38  
Мелхизедекийн дагуух хаант  
тахилч, 49  
Исаакт илэрхийлэгдсэн, 70  
Тэнгэрийн зам, 81  
үйлчлэхээр ирсэн, 82-83  
Иосефт илэрхийлэгдсэн  
нь, 101-102, 104, 108
- ИОСЕФ, 87, 89, 99-111  
тааллыг олсон хүү/ ах нар нь  
үзэн ядсан нь, 99-102  
соригдов, 103-104  
хоригдол байхдаа/ удирдагч  
байхдаа, 104-108  
уучилсан нь / зорилгоо олсон  
нь, 109-111
- ШҮҮЛТ, 33-35  
ЛЕА, 84-87  
ЛОТ, 45-48  
ГЭРЛЭЛТ, 16-17, 45, 72, 79  
МЕЛХИЗЕДЕК, 47, 49  
МЕТСУЛА, 30-31  
НОА, 32-38  
ЗАЛБИРАЛ, 59-60, 72, 93-95  
БАРДАМНАЛ, 39-40  
АМЛАЛТУУД, 5-6, 42, 51, 58-59,  
65, 94  
ХАНГАЛТ, 15-16, 68-69

РАХЕЛ, 82-83, 86-89, 98  
БИД ЮУ ТАРЬСНАА ХУРААНА,  
83-84  
РЕБЕКА, 71-75, 77-79  
ЭВЛЭРҮҮЛЭЛ, 95-96  
АВРАЛ, 21-22, 27  
ГЭМШИЛ, 46, 79-80, 97  
АМРАЛТ, 13-14  
ДАХИН АМИЛАЛТ, 9-10, 70  
САРАИ/САРА, 43, 45, 58-59, 64-65  
САТАН, 18-20; эсэргүүцэх, 23-25,  
52

ГЭМ, үр дагаварууд, 18-21,  
44, 63-64  
зорсоох, 7, 44, 55-57, 64, 66-68  
СОДОМ/ГОМОРРА, 61-62  
СҮНСНИЙ ТУЛАЛДААН, 42, 48-49,  
66-68  
ЗӨВТ БАЙДЛЫН ТӨЛӨӨХ  
ЗОВЛОН, 26-27  
УРУУ ТАТЛАГА, 63-64, 103-104  
БУРХАНТАЙ ХАМТ АЛХАХ, 30-31

## Хариултууд

Эхлэл номын энэхүү Библи судлалд гарсан асуултуудын хариуг доороос харж болно. Ингэснээр та хийсэн ажлаа шалгаж, зөв хариултыг мэдэж чадна. Харин та бүх асуултанд хариулсныхаа дараа энэ хуудаснаас лавлан хараарай.

### Хуудас 3-4

1. элин хальж, гэрэл, гэрлийг, харанхуй
2. огторгуйг, усыг, уснаас
3. хуурай газар, ногоо, үрт, модыг
4. өдрийг, шөнийг, гэрэлтүүлэгчийг, оддыг, тэмдэг, дөрвөн улирал, өдөр, жилүүдэд
5. далай тэнгисийн, амьтад, үржин амьдардаг, амьтдыг, жигүүртэн шувуудыг
6. зэрлэг араатныг, мал адгуусыг, газраар мөлхөгч, Бурхан, хүнийг, сайхан
7. дуусгаж, амарчээ

### Хуудас 15-16

1. Еден, цэцэрлэг,
2. арчлуулан, сахиулахын,
3. аль, дураараа, сайн, мууг, мэдүүлэгч, үхнэ
4. хавирганаас, эмэгтэй хүн,

### Хуудас 32-33

1. гэм, хүсэл, ямагт, хүчирхийлэл
2. харамсаж, гашуудав
3. мэлмийд, зөв шударга, гэм зэмгүй, явдаг
4. бүгдийг

### Хуудас 42

1. үндэстэн
2. ерөөнө
3. алдар нэрийг
4. ерөөлийн
5. ерөөгчдийг, ерөөнө
6. хараагч, хараана
7. үндэстэн, ерөөгдөнө

### Хуудас 74-75

1. жирэмслэхгүй, түүний, жирэмсэлжээ
2. 40, 60, 20
3. тэмцэлдсэн, үндэстэн, том, багадаа
4. ангийн маханд, Есавдаа
5. Иоковдаа, номхон дөлгөөн, майхандаа, анчин, хээр талын

### Хуудас 89

1. Реубен
2. Симеон
3. Леви
4. Иуда
5. Дан
6. Нафтали
7. Гад
8. Ашер
9. Иссахар
10. Зебулун
11. Иосеф
12. Бенжамин

---

“Та нар Намайг хайх бөгөөд бүхий л зүрхээрээ Намайг хайвал олно”  
(Иеримиа 29-13).

Та санал хүсэлтээ  
УБ-13, Ш/х 180  
хаягаар бичээрэй.

10М 6/05